"Улаанбаатар Үнэт Цаасны Бирж" ХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн
2021 оны 9 дүгээр сарын 15-ны
өдрийн 24/21 тоот тогтоолын хавсралт

БҮРТГЭЛИЙН ЖУРАМ

УЛААНБААТАР ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

ЖУРМЫН АГУУЛГА

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР **4**

НЭГ. УДИРТГАЛ **9**

1.1. Зорилго 9

1.2. Хамрах хүрээ 9

1.3. Хүчин төгөлдөр байдал 10

ХОЁР. БҮРТГЭЛИЙН АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ **11**

2.1. Ерөнхий зүйл 11

2.2. Бирж, түүний үйл ажиллагаа 12

2.3. Үнэт цаас гаргагч, түүний үйл ажиллагаа 14

2.4. Мэргэжлийн байгууллагууд, түүний үйл ажиллагаа 14

ГУРАВ. БҮРТГЭЛ, ТҮҮНИЙ АРГА ХЭЛБЭР **19**

3.1. Үнэт цаасны талбар 19

3.2. Бүртгэлийн арга хэлбэр 19

ДӨРӨВ. БҮРТГЭЛИЙН ШАЛГУУР **22**

4.1. Ерөнхий зүйл 22

4.2. Ерөнхий шалгуур 22

4.3. Засаглалын шалгуур 23

4.4. Санхүүгийн шалгуур 28

4.5. Нэмэлт шалгуур 28

4.6. Бүртгэлийн шалгууруас хөнгөлөх, чөлөөлөх 30

ТАВ. ҮНЭТ ЦААС БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ ГАРГАХ **32**

5.1. Ерөнхий зүйл 32

5.2. Шинээр өргөдөл гаргагч үнэт цаас бүртгүүлэх 32

5.3. Бүртгэлтэй Үнэт цаас гаргагч үнэт цаас бүртгүүлэх 44

5.4. Өргөдөл гаргах явцад өөрчлөгдсөн мэдээлэл хүргүүлэх 44

ЗУРГАА. БҮРТГЭЛИЙН БАРИМТ БИЧИГ **46**

6.1. Ерөнхий зүйл 46

6.2. Бүртгэлийн баримт бичигт тавигдах шаардлага 46

6.3. Бүртгэлийн баримт бичгийн агуулга 49

6.4. Мэдэгдэл 51

6.5. Хэл 52

6.6. Зураг, график 52

6.7. Ашгийн урьдчилсан таамаглал 52

6.8. Төсөвлөсөн санхүүгийн мэдээлэл 52

6.9. Бизнесийн болон хөрөнгийн үнэлгээ 53

6.10. Бүртгэлийн баримт бичигт өөрчлөлт оруулах 54

6.11. Бүртгэлийн баримт бичгийн талаар олон нийтэд мэдээлэх 54

6.12. Бүртгэлийн баримт бичгийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр танилцуулах 55

6.13. Үнэт цаас танилцуулсны дараа олон нийтэд мэдээлэл хүргэх 55

6.14. Бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн ирүүлэх баримт бичиг 56

ДОЛОО. БҮРТГЭХ ҮНЭТ ЦААС 58

7.1. Ерөнхий зүйл 58
7.2. Хувьцаа 58
7.3. Өрийн хэрэгсэл 64
7.4. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх 66
7.5. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас 71
7.6. Бусад үнэт цаас 74

НАЙМ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТОГТМОЛ ХҮЛЭЭХ ҮҮРЭГ 77

8.1. Ерөнхий зүйл 77
8.2. Мэдээлэл ирүүлэх 77
8.3. Мэдээлэл, баримт бичиг хүргүүлэх 78
8.4. Цахим хэрэгсэл ашиглах 79
8.5. Мэдээлэл, баримт бичиг боловсруулах 80

ЕС. ХЯНАЛТ 81

9.1. Бүртгэлийн хорооны хяналт 81
9.2. Биржийн ТУЗ-ийн хяналт 83
9.3. Шийдвэрийг хянуулах хүсэлт гаргах хугацаа 84
9.4. Хяналтын хурлын мэдэгдэл 84
9.5. Хурлын өмнөх үйл явц 84
9.6. Хяналтын хурал 85
9.7. Хяналтын үйл ажиллагаан дахь Бүртгэл хариуцсан албаны чиг үүрэг 85
9.8. Шийдвэрийн үндэслэл гаргуулах хүсэлт 85
9.9. Хураамж 85

АРАВ. ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ ТҮР ЗОГСООХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, БҮРТГЭЛЭЭС ХАСАХ 86

10.1. Арилжааг түр зогсоох, түдгэлзүүлэх, үнэт цаасыг бүртгэлээс хасах 86
10.2. Үнэт цаасны арилжааг түр зогсоох, түдгэлзүүлэх 86
10.3. Үнэт цаас гаргагчийн хүсэлтээр Биржийн бүртгэлээс хасах 88

АРВАН НЭГ. БУСАД 91

11.1. Бүртгэлийн хураамж болон бусад төлбөр 91
11.2. Үнэт цаас худалдан авах, захиалахад тавигдах хязгаарлалт 91
11.3. Олон нийтэд хамаарах болон хамаарахгүй этгээд 91

АРВАН ХОЁР. ХАВСРАЛТ 93

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Энэ журам заасан дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

Бүртгэлийн ажиллагаа	
Бүртгэлийн журам	Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 47.2.3-т заасны дагуу Биржээс баталсан үнэт цаасны бүртгэлийн журам, түүний хавсралт, тэдгээрт орсон нэмэлт өөрчлөлт, уг журамд заасны дагуу байгуулсан бүртгэлийн гэрээ, бусад холбогдох бичиг баримт
Талбар	Биржээр арилжигдах үнэт цаасны бүртгэл
Үндсэн талбар	Бүртгэлийн журамд заасан шаардлагыг хангаж Биржид бүртгүүлсэн үнэт цаасыг арилжих талбар
Хөгжлийн талбар	Бүртгэлийн журмын 7.2.2-д заасан Үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг арилжих талбар
Бүртгэлийн арга хэлбэр	Үнэт цаас гаргагчийг Биржид бүртгэх аргачлал
Бүртгэлийн шалгуур	Үнэт цаас гаргагчийг Биржид бүртгэх ерөнхий, засаглалын, санхүүгийн болон бусад нэмэлт шалгуур үзүүлэлт
Бүртгэлийн баримт бичиг	Энэ журмын 6 дугаар бүлэгт заасны дагуу бэлтгэсэн үнэт цаасны танилцуулга, түүнд хавсаргасан бусад мэдээлэл, баримт бичгүүд
Өргөдөл гаргагч	Үнэт цаасыг шинээр, эсхүл нэмж Биржид бүртгүүлэхээр өргөдөл гаргаж байгаа этгээд
Шинээр өргөдөл гаргагч	Үнэт цаасаа нийтэд санал болгохоор Биржид бүртгүүлэх өргөдөл гаргаж байгаа Биржид бүртгэлгүй хуулийн этгээд
Бүртгэлийн ажиллагаанд оролцогчид	
Бирж	”Улаанбаатар Үнэт Цаасны Бирж” ХК
Бүртгэлийн хороо	Биржийн бүртгэлийн ажиллагааг хэрэгжүүлэх, Үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг бүртгэх эсэх, тэдгээрийн бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасах тухай асуудлыг шийдвэрлэх болон Бүртгэл

	хариуцсан албаны шийдвэрийг хянах чиг үүрэг бүхий Биржийн хороо
Үнэт цаас гаргагч	Үнэт цаасны зах зээлд арилжих үнэт цаасаа Биржид бүртгүүлсэн, эсхүл бүртгүүлэхээр өргөдөл гаргаж байгаа этгээд
Бүртгэлтэй Үнэт цаас гаргагч	Арилжаа эрхлэх байгууллага, Хороонд бүртгэгдсэн хуулийн этгээд
Бүртгэлгүй Үнэт цаас гаргагч	Арилжаа эрхлэх байгууллага, Хороонд бүртгэгдээгүй хуулийн этгээд
Андеррайтер	Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, энэ журмын 2.4.3-т заасан чиг үүргийн дагуу Үнэт цаас гаргагчтай гэрээ байгуулсан хуулийн этгээд
Нийцүүлэгч	Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 эсвэл 24.1.17-д заасан, Хорооны бүртгэлд бүртгүүлсэн этгээдийг хэлэх бөгөөд энэ журмын 2.4.10-т заасан чиг үүрэгтэй, Биржээс гаргасан жагсаалтад багтсан хуулийн этгээд
Хуулийн үйлчилгээ үзүүлэгч	Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.15-т заасан эрхтэй хуулийн этгээд
Хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэгч	Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.16-т заасан эрхтэй хуулийн этгээд
Аудитын үйлчилгээ үзүүлэгч	Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.17-т заасан эрхтэй хуулийн этгээд
Мэргэжлийн зөвлөх	Энэ журамд зохицуулсан асуудлаар Үнэт цаас гаргагчид мэргэжлийн зөвлөгөө үзүүлдэг санхүүгийн зөвлөх, хуульч, нягтлан бодогч, хөрөнгийн үнэлгээчин болон бусад этгээд (андеррайтер, нийцүүлэгч хамаарахгүй)
Хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн мэргэжлийн оролцогч	Хорооны Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих тухай журамд заасан үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий үнэт цаасны компани
Шинжээч	Мэргэжлийн дүгнэлт гаргах эрх бүхий инженер, үнэлгээчин, аудитор болон бусад этгээд

Бүртгэлийн баримт бичиг	
Бүртгэлийн баримт бичгийн анхны төсөл	Бүртгүүлэх өргөдөл анх гаргахад ирүүлэх энэ журмын 5.2.10-т заасан шаардлагыг хангасан бүртгэлийн баримт бичгийн төсөл
Бүртгэлийн баримт бичгийн эцсийн төсөл	Энэ журмын 6.2.3.1-д заасны дагуу ирүүлэх Биржийн саналыг бүрэн тусгасан бүртгэлийн баримт бичгийн төсөл
Бүртгэлийн баримт бичгийг хэвлэх	Үнэт цаасыг нийтэд санал болгох зорилгоор бүртгэлийн баримт бичгийг олон нийтэд тараах, танилцуулахаар хэвлэн нийтлэх
Ашгийн таамаглал	Үнэт цаас гаргагчийн орлого болон алдагдлын таамаглал буюу ирээдүйн орлого болон алдагдлын урьдчилсан төвшинг шууд, эсхүл өмнөх жилүүдийн төвшинтэй жишсэн харьцуулалтад үндэслэсэн тооцоолол Хорогдуулсан мөнгөн гүйлгээний арга, эсхүл ашиг, орлого, мөнгөн урсгалын төсөөлөлд үндэслэн Үнэт цаас гаргагчийн худалдан авсан хөрөнгө болон бизнесийн бүх төрлийн үнэлгээ ашгийн таамаглалд хамаарна.
Арилжааны бус хөрөнгө	Арилжааны зориулалттай хөрөнгөөс бусад үл хөдлөх хөрөнгө
Нийт хөрөнгө	Бүртгэлийн баримт бичиг гаргахаас өмнөх Үнэт цаас гаргагчийн хамгийн сүүлийн аудитлагдсан санхүүгийн тайланд тусгасан эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн нийлбэр
Үл хөдлөх хөрөнгийн хөгжүүлэлт буюу хөгжүүлэлт	Түрээслэх, худалдах, хөрөнгө оруулалт хийх зорилгоор барилга, байгууламжийн зориулалтыг өөрчлөх, сэргээн босгох, шинэчлэх, газар дээр барилга байгууламж барих зэргээр үл хөдлөх хөрөнгөнд хийж буй томоохон өөрчлөн байгуулалтын төсөл
Хөрөнгийн үнэ цэнэ	Хөрөнгийн үнэлгээ хийсний үр дүнд тогтоосон мөнгөөр илэрхийлэгдэх үнэлгээ
Үнэт цаас гаргагч	
Эрх бүхий албан тушаалтан	Компанийн тухай хуулийн 84.1-т заасан этгээд

Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч	Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.29-д заасан этгээд
Ойрын хамааралтай этгээд	Компани, түүний охин компанийн ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, болон тэдгээртэй холбогдох этгээд
ТУЗ	Энэ журмын 2 дугаар бүлэгт Биржийн төлөөлөн удирдах зөвлөлийг, бусад бүлэгт Үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөл
Хамааралтай этгээд	Дараах этгээдүүд (a) бүртгэлтэй Үнэт цаас гаргагчийн, эсхүл түүний охин компанийн ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч (b) сүүлийн 12 сард бүртгэлтэй Үнэт цаас гаргагч, эсхүл түүний охин компанийн ТУЗ-ийн гишүүн байсан этгээд (c) (a) болон (b) хэсэгт заасан этгээдтэй холбогдох этгээд (d) Биржээс хамааралтай этгээд гэж үзсэн бусад этгээд
Холбогдох этгээд	Хувь хүний тухайд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.30-ын (a), (b), (c), (d) хэсэгт заасан этгээд Компанийн тухайд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.30-ын (e), (f) болон Компанийн тухай хуулийн 6.14-д заасан этгээд
Үнэт цаас гаргагчийн нэгдэл	Компанийн тухай хуулийн 6.14-т заасан нэгдэл
Бусад	
Хороо	Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан “Санхүүгийн Зохицуулах Хороо”
Арилжаа эрхлэх байгууллага	Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.11-т заасан үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд
Арилжааг түр зогсоох	Хорооны улсын байцаагчийн дүгнэлтэд үндэслэн үнэт цаасны арилжааг 2 (хоёр) хүртэл хоногийн хугацаагаар түр зогсоох

Арилжааг түдгэлзүүлэх	Хорооны улсын байцаагчийн дүгнэлтэд үндэслэн 2 (хоёр) хоногоос дээш хугацаагаар арилжаа зогсоох
Буцаах шийдвэр	Өргөдөл гаргагчийн бүртгүүлэх өргөдөл, түүнд хавсаргасан бүртгэлийн баримт бичгийн анхны төсөл, энэ журмын 6.2.1-т заасан холбогдох бусад баримт бичигт тусгасан мэдээлэл нь энэ журмын 5.2.10-т заасан шаардлагыг хангаагүй гэсэн үндэслэлээр өргөдлийг өргөдөл гаргагч болон түүний андеррайтерт буцаахаар шийдвэрлэсэн Бүртгэл хариуцсан албаны шийдвэр болон Бүртгэлийн хорооноос өргөдлийг дээрх шаардлагыг хангаагүй гэх үндэслэлээр Бүртгэл хариуцсан албанд буцаасан шийдвэр
Тэнцвэржүүлэх гэрээ	Үнэт цаасаа давхар бүртгүүлж буй нэг компани хэлбэрээр бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг 2 (хоёр) буюу хэд хэдэн компанийн хооронд байгуулах гэрээ
Харилцан хамааралтай хэлцэл	Ойрын хамааралтай болон хамааралтай этгээдүүдийн хооронд байгуулсан хэлцэл
Мэдэгдвэл зохих хэлцэл	Биржийн мэдэгдэх шаардлагатай гэж үзсэн аливаа төрлийн хэлцэл

НЭГ. УДИРТГАЛ

1.1. Зорилго

1.1.1. Энэ журмын зорилго нь “Улаанбаатар Үнэт Цаасны Бирж” ХК (цаашид “Бирж” гэх)-ийн бүртгэлийн ажиллагааны үндсэн зарчим, оролцогчид, бүртгэлийн арга хэлбэр болон Үнэт цаас гаргагчид тавигдах шаардлагыг тодорхойлж, өргөдөл гаргагч Биржид бүртгүүлэх, бүртгэлтэй Үнэт цаас гаргагч нэмж үнэт цаас гаргах, өргөдөл гаргагчийн өргөдлийг шийдвэрлэх, Биржийн бүртгэлд өөрчлөлт оруулах, хяналт тавих, бүртгэлээс хасахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 4 сарын 13-ны өдрийн 07/22 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

1.1.2. Энэ журам нь хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор дор дурдсан нөхцөлийг хангахад чиглэнэ. Үүнд:

1.1.2.1. Өргөдөл гаргагч бүртгүүлэх шаардлагыг бүрэн хангасан байх

1.1.2.2. Үнэт цаасыг бүртгэх, арилжих ажиллагааг шударгаар зохион байгуулах

1.1.2.3. Үнэт цаас гаргагчаас хөрөнгө оруулагч болон нийтэд зохих мэдээллийг нээлттэй, тухай бүр хүргэх

1.1.2.4. Хөрөнгө оруулагч болон нийтийн эрх, ашиг сонирхолд нөлөөлж болзошгүй ноцтой хүчин зүйлсийн талаар Үнэт цаас гаргагчаас хөрөнгө оруулагч болон нийтэд бүрэн мэдээлэх

1.1.2.5. Үнэт цаас эзэмшигчдэд шударга, эрх тэгш хандах

1.1.2.6. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд нь хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлыг бүхэлд нь төлөөлөн үйл ажиллагаагаа явуулах

1.1.2.7. Хувьцаа эзэмшигчид өөрөөр харилцан тохиролцсоноос бусад тохиолдолд нэмж гаргаж буй хувьцааг одоогийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжид санал болгох.

1.2. Хамрах хүрээ

1.2.1. Энэ журмыг Бирж болон үнэт цаасны бүртгэлийн ажиллагаанд оролцогчид дагаж мөрдөнө.

1.2.2. Бирж болон үнэт цаасны бүртгэлийн ажиллагаанд оролцогчдын харилцан хүлээсэн эрх, үүрэг нь энэ журмаас гадна дараах баримт бичгүүдээр тодорхойлогдоно. Үүнд:

1.2.2.1. Бүртгэлийн хорооны үйл ажиллагааны журам

1.2.2.2. Бүртгэлийн ажиллагааны удирдамжууд

1.2.2.3. Бүртгэлийн гэрээ

1.2.2.4. Бүртгэлийн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл

1.2.2.5. Бүртгэлийн ажиллагаанд оролцогчдын хооронд байгуулсан гэрээ

1.2.2.6. Биржээс бүртгэлийн ажиллагаанд оролцогчдын хоорондын харилцааг зохицуулахаар баталсан бусад дүрэм, журам, зөвлөмж, удирдамж.

1.3. Хүчин төгөлдөр байдал

1.3.1. Энэ журам, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Биржийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “Биржийн ТУЗ” гэх) баталж, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49.1.4-т заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх) батламжилна.

1.3.2. Хороо өөрөөр шийдвэрлээгүй бол энэ журам нь Хороо энэ журмыг батламжилсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

1.3.3. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол энэ журмын 1.2.2.1-т заасан баримт бичгийг Биржийн ТУЗ, 1.2.2.2-1.2.2.4, 1.2.2.6-д заасан баримт бичгийг Гүйцэтгэх захирал тус тус батална.

1.3.4. Энэ журмаар зохицуулагдаагүй бусад харилцаанд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хорооноос баталсан Үнэт цаасны бүртгэлийн журам, Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам болон холбогдох бусад хууль тогтоомжийг баримтлан зохицуулна.

1.3.5. Бирж, түүний гүйцэтгэх удирдлага энэ журам болон түүнтэй нийцүүлэн гаргасан бусад журам, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

1.3.6. Энэ журмын хавсралтууд журмын салшгүй хэсэг байна.

ХОЁР. БҮРТГЭЛИЙН АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ

2.1. Ерөнхий зүйл

2.1.1. Бүртгэлийн ажиллагаанд оролцогчид нь Бирж, Үнэт цаас гаргагч болон Үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг бүртгэх бүртгэлийн ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх бусад оролцогчдоос бүрдэнэ.

2.1.2. Бирж бүртгэлийн ажиллагааг хэрэгжүүлэхдээ дараах этгээдээр дамжуулан хэрэгжүүлнэ. Үүнд:

2.1.2.1. Биржийн ТУЗ

2.1.2.2. Бүртгэлийн хороо

2.1.2.3. Биржийн Гүйцэтгэх удирдлага

2.1.2.4. Бүртгэл хариуцсан алба

2.1.3. Бүртгэлийн ажиллагаанд оролцож буй Үнэт цаас гаргагч нь дараах хэлбэртэй байж болно. Үүнд:

2.1.3.1. Бүртгэлгүй Үнэт цаас гаргагч

2.1.3.2. Бүртгэлтэй Үнэт цаас гаргагч

2.1.4. Бүртгэлийн ажиллагаанд Үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагууд нь дараах этгээд байна. Үүнд:

2.1.4.1. Андеррайтер эсвэл зуучлагч

2.1.4.2. Нийцүүлэгч

2.1.4.3. Хуулийн үйлчилгээ үзүүлэгч

2.1.4.4. Аудитын үйлчилгээ үзүүлэгч

2.1.4.5. Хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэгч

2.1.4.6. Хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн мэргэжлийн оролцогч

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор нэмсэн/

2.1.4.7. Биржээс шаардлагатай гэж үзсэн бусад

2.2. Бирж, түүний үйл ажиллагаа

2.2.1. Бирж нь бүртгэлийн шаардлага, арга хэлбэр, бүртгэлийн ажиллагааг явуулах үндсэн процессыг тодорхойлох, Үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, хяналт тавих, бүртгэлээс хасах болон үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагааг шударга, зохион байгуулалттай, үр дүнтэй явуулах нөхцөлийг бүрдүүлэх үндсэн чиг үүрэгтэй.

2.2.2. Бирж нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу Хорооноос холбогдох тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр үйл ажиллагаа явуулна.

2.2.3. Энэ журамд Биржийн хэрэгжүүлэхээр заасан аливаа бүрэн эрх, чиг үүргийг Биржийн ТУЗ-ийн хяналтан дор Бүртгэлийн хороо, Биржийн Гүйцэтгэх удирдлага болон Бүртгэл хариуцсан алба хэрэгжүүлнэ.

Биржийн ТУЗ, түүний үйл ажиллагаа

2.2.4. Биржийн ТУЗ нь бүртгэлийн ажиллагааг хэрэгжүүлэх үндсэн журам, зарчмыг батлах, Биржийн бүртгэлийн ажиллагааг хэрэгжүүлж буй Бүртгэлийн хороо болон Биржийн Гүйцэтгэх захирал, Бүртгэл хариуцсан албаны үйл ажиллагаанд хяналт тавих, бүртгэлийн ажиллагааны хэрэгжилт болон бүртгэлийн ажиллагаатай холбогдуулан гаргасан шийдвэрт хяналт тавих үндсэн чиг үүрэгтэй.

2.2.5. Биржийн ТУЗ нь үнэт цаасны бүртгэлтэй холбоотой тодорхой чиг үүргийг өөрөө хэрэгжүүлэхээр шийдвэрлэснээс бусад тохиолдолд Бүртгэлийн хороо үнэт цаасны бүртгэлтэй холбоотой шийдвэрийг гаргана.

2.2.6. Биржийн ТУЗ нь зөвхөн энэ журмын 9.2.1-д заасан асуудлаар Бүртгэлийн хорооны шийдвэрийг хянана. Энэ журмын 9.2.1-д зааснаас бусад асуудлаар гаргасан Бүртгэлийн хорооны шийдвэр эцсийн шийдвэр байна.

Бүртгэлийн хороо, түүний үйл ажиллагаа

2.2.7. Бүртгэлийн хороо нь Биржийн бүртгэлийн ажиллагааг хэрэгжүүлэх үндсэн бүтэц байх бөгөөд Үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг бүртгэх эсэх, тэдгээрийн бүртгэлд өөрчлөлт оруулах, үнэт цаасыг Биржийн бүртгэлээс хасах тухай асуудлыг шийдвэрлэх болон Биржийн бүртгэлийн ажиллагаа хараат бус, хууль журамд бүрэн нийцэж явагдаж байгаа эсэхийг хянах үндсэн чиг үүрэгтэй.

2.2.8. Бүртгэлийн хороо нь Бүртгэлийн журмын хэрэгжилтийг өдөр тутамд хангах үүрэггүй боловч энэ журмаар олгогдсон эрхийнхээ хүрээнд Биржийн Гүйцэтгэх удирдлага болон Бүртгэл хариуцсан албаны гаргасан аливаа шийдвэрийг хэдийд ч өөрийн санаачилгаар хянаж үзэн өөрчлөх, боловсронгуй болгох, хэвээр батлах, хүчингүй болгох тухай зөвлөмж гаргах эрхтэй хяналтын нэгж байна.

2.2.9. Бүртгэлийн хороо нь Биржийн Гүйцэтгэх удирдлага болон Бүртгэл хариуцсан албанд энэ журмаар олгогдсон эрхтэй нь холбогдуулан заавар чиглэл өгөх болон олгогдсон эрхийг нь журамлах, хязгаарлах тухай зөвлөмж гаргах эрхтэй.

2.2.10. Үнэт цаасыг Биржийн бүртгэлд бүртгэх эсэх, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах болон бүртгэлээс хасахтай холбогдуулан гаргасан Бүртгэлийн хорооны шийдвэр нь эцсийн бөгөөд Биржийн шийдвэр гэж тооцогдоно. Бүртгэлийн хорооны шийдвэрийг бүртгэлийн ажиллагаанд оролцогчид заавал дагаж мөрдөнө.

2.2.11. Бүртгэлтэй Үнэт цаас гаргагчийн нэмж гаргаж буй үнэт цаасны хэмжээнээс шалтгаалж түүнийг бүртгэх эсэх тухай шийдвэр гаргах эрхийг Бүртгэлийн хороо Биржийн Гүйцэтгэх удирдлагад шилжүүлж болно. Энэ тохиолдолд Биржийн Гүйцэтгэх удирдлагын шийдвэр эцсийн бөгөөд Биржийн шийдвэр гэж тооцогдоно.

Биржийн Гүйцэтгэх удирдлага, түүний үйл ажиллагаа

2.2.12. Биржийн Гүйцэтгэх удирдлага нь Биржийн ТУЗ болон Бүртгэлийн хорооноос олгогдсон эрхийн дагуу бүртгэлийн ажиллагааны өдөр тутмын хэрэгжилтэд хяналт тавих үндсэн чиг үүрэгтэй.

2.2.13. Биржийн Гүйцэтгэх удирдлага нь Бүртгэлийн хорооны гишүүдийн болон нийцүүлэгчдийн жагсаалтад нэр дэвшигчдийн бүртгэлийг батлах эрхтэй.

Бүртгэл хариуцсан алба, түүний үйл ажиллагаа

2.2.14. Бүртгэл хариуцсан алба нь бүртгэлийн ажиллагааны өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, бүртгэлийн ажиллагаанд оролцогчдыг мэдээллээр хангах, Биржийн ТУЗ, Биржийн Гүйцэтгэх удирдлага болон Бүртгэлийн хороо бүртгэлийн ажиллагаатай холбоотой шийдвэр гаргахад холбогдох үйл ажиллагааг зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй.

2.2.15. Бүртгэл хариуцсан алба нь Биржийн ТУЗ-өөс баталсан бүтэц дэх тухайлсан нэгж байх бөгөөд Бүртгэлийн хороо болон Биржийн Гүйцэтгэх удирдлагын хяналтан дор энэ журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.2.16. Бүртгэл хариуцсан алба нь дараах асуудлыг дангаар шийдвэрлэх эрхтэй. Үүнд:

2.2.16.1. Өргөдөл гаргагчийн өргөдлийг Биржийн бүртгэлийн шалгуурыг хангасан гэж үзсэн тохиолдолд өргөдлийг шийдвэрлүүлэхээр Бүртгэлийн хороо эсхүл Биржийн Гүйцэтгэх удирдлагад танилцуулах, шийдвэрлүүлэх

2.2.16.2. Өргөдөл гаргагчийн өргөдөл нь Биржийн бүртгэлийн шалгуурыг хангаагүй гэж үзвэл өргөдлийг Буцаах шийдвэр гаргах

2.2.16.3. Бүртгэлтэй Үнэт цаас гаргагчийн тогтмол хүлээх үүрэгтэй холбоотой зохих шийдвэрийг гаргах эсхүл Биржийн эрх бүхий этгээдэд мэдэгдэх

2.2.16.4. Бүртгэлийн хорооны гишүүн болон нийцүүлэгчдийг Биржийн нэрийн жагсаалтад бүртгэх ажлыг хариуцан зохион байгуулах

2.2.16.5. Энэ журмын 9 дүгээр бүлэгт заасан хяналтын хурлыг хариуцан зохион байгуулах

2.2.16.6. Бүртгэлийн хорооноос тухай бүр эрх олгосон болон энэ журамд заасан бусад асуудлыг шийдвэрлэх, зохион байгуулах.

2.3. Үнэт цаас гаргагч, түүний үйл ажиллагаа

2.3.1. Үнэт цаас гаргагч нь Биржийн шалгуурыг бүрэн хангасан эсхүл Биржээс олгосон тодорхой хугацаанд багтан бүрэн хангах тухай амлалт өгсний үндсэн дээр үнэт цаас гаргаж, Биржийн бүртгэлийн шалгуурыг тогтмол хангаж ажиллах үүрэгтэй.

2.3.2. Үнэт цаас гаргагч нь аливаа арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй эсэхээс үл хамааран Биржид бүртгүүлэх өргөдлөө Бүртгэл хариуцсан албанд гаргана. Бүртгүүлэх өргөдөл гаргахдаа шаардлагатай тохиолдолд Биржээс шаардсан мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулсан байна.

2.3.3. Үнэт цаас гаргагчийг Биржийн бүртгэлд бүртгэх тохиолдолд Биржтэй Бүртгэлийн гэрээ байгуулж, Үнэт цаас гаргагч нь тухайн гэрээний хэрэгжилтийг тогтмол хангаж ажиллана.

2.4. Мэргэжлийн байгууллагууд, түүний үйл ажиллагаа

2.4.1. Бирж нь бүртгэлийн ажиллагааг илүү үр дүнтэй, шударга хэрэгжүүлэх зорилгоор Үнэт цаас гаргагчийг андеррайтер, нийцүүлэгч, хууль, аудит, хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэгч гэх мэт мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллахыг шаардаж болно.

2.4.2. Мэргэжлийн байгууллагууд нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24-т заасны дагуу Хорооноос тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд байна.

Андеррайтер, түүний үйл ажиллагаа

2.4.3. Андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг Биржийн бүртгэлд бүртгүүлэхэд үнэт цаасны үнийг тогтоох, үнэт цаасны танилцуулгыг боловсруулах, үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох үйл ажиллагааг зохион байгуулах, анхдагч зах зээлд үнэт цаасыг худалдан авах зэрэг мэргэжлийн үйлчилгээг Үнэт цаас гаргагчид үзүүлэх үндсэн чиг үүрэгтэй.

2.4.4. Андеррайтер нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.2-т заасны дагуу Хорооноос тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр үйл ажиллагаа явуулах хуулийн этгээд байх бөгөөд Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр бүртгэлийн ажиллагаанд оролцоно.

2.4.5. Андеррайтер нь олон нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасны бүртгэлийн ажиллагаанд заавал оролцох оролцогч байна.

2.4.6. Андеррайтер нь хууль тогтоомжид зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.4.6.1. Шинээр өргөдөл гаргагчийн бүртгэлийн баримт бичгийг бэлтгэх

2.4.6.2. Энэ журмын Хавсралт 6-т заасан мэдэгдэл гаргахаас өмнө зохих магадлан шинжилгээг бүрэн хийх

2.4.6.3. Энэ журмын 5 дугаар бүлэгт заасан шаардлагын биелэлтийг хангах

2.4.6.4. Үнэт цаас бүртгүүлэхтэй холбоотой Биржээс тавьсан шаардлагыг тухай бүр биелүүлэх

2.4.6.5. Бирж шаардсан тохиолдолд Биржтэй хийх хурал, бусад хэлэлцүүлэгт шинээр өргөдөл гаргагчтай хамт оролцох

2.4.6.6. Энэ журмын Хавсралт 5-т заасны дагуу Биржид өгсөн хараат бус байдлын мэдүүлэгт заасан нөхцөлийг хангаж ажиллах.

Зуучлагч, түүний үйл ажиллагаа

2.4.7. Зуучлагч нь Үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг Биржийн бүртгэлд бүртгүүлэхэд зөвлөмж өгөх, үнэт цаасыг Бирж дээр хаалттай хүрээнд санал болгоход зуучлах үйлчилгээ үзүүлэх үндсэн чиг үүрэгтэй.

2.4.8. Зуучлагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.2-т заасны дагуу Хорооноос тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр үйл ажиллагаа явуулах хуулийн этгээд байх бөгөөд Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр бүртгэлийн ажиллагаанд оролцоно.

2.4.9. Зуучлагч нь Биржийн гишүүн үнэт цаасны компани байх бөгөөд үнэт цаасыг зөвхөн хаалттай хүрээнд үнэт цаас санал болгоход оролцох оролцогч байна.

Нийцүүлэгч, түүний үйл ажиллагаа

2.4.10. Нийцүүлэгч нь Биржид бүртгэгдсэн Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг хууль журамд нийцүүлэх, зөвлөмж өгөх, Биржид ирүүлэх мэдээлэлд хяналт тавих, бүртгэлтэй Үнэт цаас гаргагчийг Хорооноос баталсан Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлж ажиллах, нээлттэй компани болж төлөвшихөд нь туслах мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх үндсэн чиг үүрэгтэй.

2.4.11. Нийцүүлэгч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.15 эсвэл 24.1.17-д заасан үйл ажиллагааг эрхлэх Хорооноос тогтоосон нөхцөл, шаардлагыг ханган, Хороонд бүртгүүлсэн эрх бүхий хуулийн этгээд байх бөгөөд Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр бүртгэлийн ажиллагаанд оролцоно.

2.4.12. Нийцүүлэгч нь үндсэн үйл ажиллагааны чиглэлээс үл хамааран хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн хуульч болон аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аудитортой байна. Нийцүүлэгчид тавигдах тусгай шаардлагыг Бирж тогтоож болно.

2.4.13. Нийцүүлэгчийг дараах чиглэлээр Бирж нийцүүлэгчийн нэрсийн жагсаалтад бүртгэнэ. Үүнд:

2.4.13.1. Хуулийн нийцүүлэгч – Үнэт цаас гаргагчийн олон нийтэд мэдээлэл хүргэх, компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэх болон бусад үйл ажиллагааг хууль журамд нийцүүлэх үндсэн чиг үүрэгтэй.

2.4.13.2. Санхүүгийн нийцүүлэгч – Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагааг хууль журамд нийцүүлэх үндсэн чиг үүрэгтэй.

Хуулийн үйлчилгээ үзүүлэгч, түүний үйл ажиллагаа

2.4.14. Хуулийн үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаас гаргагч, түүний гаргаж буй үнэт цаастай холбоотой хууль зүйн магадлан шинжилгээ хийж, хууль зүйн дүгнэлтийг холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас батлан гаргасан журам, заавар аргачлалын дагуу гаргах, Биржээс шаардсан тохиолдолд гаргасан дүгнэлтээ тайлбарлах үндсэн чиг үүрэгтэй.

2.4.15. Хуулийн үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.15-д заасан үйл ажиллагааг эрхлэх Хорооноос тогтоосон нөхцөл, шаардлагыг ханган, Хороонд бүртгүүлсэн эрх бүхий хуулийн этгээд байх бөгөөд Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр бүртгэлийн ажиллагаанд оролцоно.

2.4.16. Хуулийн үйлчилгээ үзүүлэгч нь олон нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасны бүртгэлийн ажиллагаанд заавал оролцох оролцогч байна.

2.4.17. Хуулийн үйлчилгээ үзүүлэгч нь энэ журмын Хавсралт 9-д заасан мэдэгдлийг гаргана.

Аудитын үйлчилгээ үзүүлэгч, түүний үйл ажиллагаа

2.4.18. Аудитын үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаас гаргагч, түүний гаргаж буй үнэт цаастай холбоотой аудитын хяналт шалгалт хэрэгжүүлж, аудитын дүгнэлтийг холбогдох хууль тогтоомж, аудитын олон улсын стандарт, эрх бүхий байгууллагаас батлан гаргасан журам, заавар арга, аргачлалын дагуу гаргах, Биржээс шаардсан тохиолдолд гаргасан дүгнэлтээ тайлбарлах үндсэн чиг үүрэгтэй.

2.4.19. Аудитын үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.17-д заасан үйл ажиллагааг эрхлэх Хорооноос тогтоосон нөхцөл, шаардлагыг ханган, Хороонд бүртгүүлсэн эрх бүхий хуулийн этгээд байх бөгөөд Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр бүртгэлийн ажиллагаанд оролцоно.

2.4.20. Аудитын үйлчилгээ үзүүлэгч нь олон нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасны бүртгэлийн ажиллагаанд заавал оролцох оролцогч байна.

2.4.21. Аудитын үйлчилгээ үзүүлэгч нь энэ журмын Хавсралт 10-д заасан мэдэгдлийг гаргана.

Хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэгч, түүний үйл ажиллагаа

2.4.22. Хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаас гаргагч, түүний гаргаж буй үнэт цаастай холбоотой хөрөнгийн болон бизнесийн үнэлгээг холбогдох

хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас батлан гаргасан журам, заавар арга, аргачлалын дагуу хийж, үнэлгээний дүгнэлт, тайлан гаргах, Биржээс шаардсан тохиолдолд гаргасан дүгнэлт, тайлангаа тайлбарлах үндсэн чиг үүрэгтэй.

2.4.23. Хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.16-д заасан үйл ажиллагааг эрхлэх Хорооноос тогтоосон нөхцөл, шаардлагыг ханган, Хороонд бүртгүүлсэн эрх бүхий хуулийн этгээд байх бөгөөд Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр бүртгэлийн ажиллагаанд оролцоно.

2.4.24. Хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэгч нь олон нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасны бүртгэлийн ажиллагаанд заавал оролцох оролцогч байна.

2.4.25. Хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэгч нь энэ журмын Хавсралт 11-т заасан мэдэгдлийг гаргана.

Хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн мэргэжлийн оролцогч, түүний үйл ажиллагаа

2.4.26. Хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн мэргэжлийн оролцогч нь Үнэт цаас гаргагч, түүний гаргаж буй хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг анхдагч зах зээлд санал болгож, санхүүгийн хэрэгслээр солих ажиллагааг гүйцэтгэх үндсэн чиг үүрэгтэй.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор нэмсэн/

2.4.27. Хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн мэргэжлийн оролцогч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.2-т заасны дагуу Хорооноос тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр үйл ажиллагаа явуулах хуулийн этгээд байх бөгөөд Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр бүртгэлийн ажиллагаанд оролцоно.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор нэмсэн/

2.4.28. Хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн мэргэжлийн оролцогч нь хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн анхдагч болон хоёрдогч зах зээлийн үнэт цаасны бүртгэлийн ажиллагаанд заавал оролцох оролцогч байна.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор нэмсэн/

2.4.29. Хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн мэргэжлийн оролцогч нь дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

2.4.29.1. Сангийн нэгж эрх шинээр үүсгэх, буцаан худалдахтай холбоотой үйл ажиллагаа явуулах чадвартай хүний нөөц, программ хангамжтай байх

2.4.29.2. Сангийн нэгж эрхийн хөрвөх чадварыг сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх

2.4.29.3. Хадгаламжийн байгууллагатай хамтарч ажиллах боломжтой байх

2.4.29.4. Мэргэжлийн оролцогчийн санхүүгийн хэрэгсэл нь аливаа өмчлөх эрхийн зөрчилгүй байх

2.4.29.5. Хорооны холбогдох журамд заасан бусад.

/Төлөвлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор нэмсэн/

ГУРАВ. БҮРТГЭЛ, ТҮҮНИЙ АРГА ХЭЛБЭР

3.1. Үнэт цаасны талбар

3.1.1. Бирж нь үнэт цаасны төрөл тус бүрээр тухайн үнэт цаасыг бүртгэх талбартай байна.

3.1.2. Бирж нь энэ журмын 5 дугаар бүлэгт заасны дагуу Үнэт цаас гаргагчтай Бүртгэлийн гэрээ байгуулсны үндсэн дээр тухайн Үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг Биржийн үнэт цаасны талбарт бүртгэнэ.

3.1.3. Бирж нь энэ журмын 7 дугаар бүлэгт тухайн үнэт цаас бүрээр тодорхойлсон шаардлагыг хангасан Үнэт цаас гаргагчийг бүртгэнэ.

3.2. Бүртгэлийн арга хэлбэр

3.2.1. Бирж аливаа Үнэт цаас гаргагчийг дараах арга хэлбэрийн аль нэгийг ашиглан бүртгэж болно. Үүнд:

3.2.1.1. Захиалга авахаар санал болгох

3.2.1.2. Өөрийн эзэмшлийн үнэт цаасыг худалдахаар санал болгох

3.2.1.3. Давхар бүртгэл

3.2.1.4. Урвуу нэгдэл

3.2.1.5. Үнэт цаас хаалттай хүрээнд санал болгох

3.2.1.6. Бүртгэл шилжих

3.2.1.7. Холбогдох хууль, журамд заасан бусад.

3.2.2. Бирж бүртгэж буй үнэт цаасны төрөл, Үнэт цаас гаргагч нь арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй эсэхээс хамаарч энэ журмын 3.2.1-д заасан бүртгэлийн арга хэлбэрээс сонгон хэрэглэнэ.

3.2.3. Энэ журмын 3.2.1-д заасан бүртгэлийн арга хэлбэрийн алийг сонгосноос үл хамааран үнэт цаасыг олон нийтэд нээлттэй санал болгох тохиолдолд ижил тооны үнэт цаасыг ижил үнээр захиалсан хөрөнгө оруулагч бүрт эрх тэгш хандах шударга хуваарилалтын зарчмыг баримтална.

3.2.4. Биржид бүртгэгдэж буй Андеррайтер нь Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээнд дагуу үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг олон нийтэд танилцуулах, сурталчлах маркетингийн хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд Хорооны холбогдох журамд заасан арга, хэлбэрээр явуулна.

Захиалга авахаар санал болгох

3.2.5. Захиалга авахаар санал болгох гэдэг нь Үнэт цаас гаргагчийн шинээр гаргаж буй үнэт цаасыг Үнэт цаас гаргагч өөрөө, эсхүл түүний нэрийн өмнөөс өөр этгээд олон нийтэд санал болгох аргыг хэлнэ.

3.2.6. Үнэт цаас гаргахад энэ аргыг хэрэглэх тохиолдолд үнэт цаас гаргах ажиллагаанд андеррайтер бүрэн оролцож баталгаажуулна.

3.2.7. Энэ аргаар үнэт цаасыг санал болгоход Үнэт цаас гаргагч нь энэ журмын 6 дугаар бүлэгт заасан шаардлагыг хангасан бүртгэлийн баримт бичгийг бэлтгэнэ.

Өөрийн эзэмшлийн үнэт цаасыг худалдахаар санал болгох

3.2.8. Өөрийн эзэмшлийн үнэт цаасыг худалдахаар санал болгох гэдэг нь компанийн гаргасан эсхүл гаргахаар зөвшөөрсөн үнэт цаасыг эзэмшигчид, бусад үнэт цаас эзэмшигчид, эсхүл номинал эзэмшигч өөрөө, эсхүл тэдний нэрийн өмнөөс олон нийтэд санал болгохыг хэлнэ.

3.2.9. Энэ аргаар үнэт цаасыг санал болгоход Үнэт цаас гаргагч нь энэ журмын 6 дугаар бүлэгт заасан шаардлагыг хангасан бүртгэлийн баримт бичгийг бэлтгэнэ.

Давхар бүртгэл

3.2.10. Давхар бүртгэл гэдэг нь бүртгэлтэй үнэт цаас гаргагч өөр арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдэх аргыг хэлнэ.

3.2.11. Үнэт цаасаа давхар бүртгүүлэх сонирхолтой этгээдийн үнэт цаасыг бүртгэсэн арилжаа эрхлэх байгууллагын арилжаа, төлбөр, тооцооны систем, технологийн шийдэл, мэдээлэл солилцох боломж, эрх зүйн зохицуулалтыг Бирж судалсны үндсэн дээр давхар бүртгэл хийх боломжтой эсэхийг шийдвэрлэнэ.

3.2.12. Энэ аргаар үнэт цаасыг санал болгоход Үнэт цаас гаргагч нь энэ журмын 6 дугаар бүлэгт заасан шаардлагыг хангасан бүртгэлийн баримт бичгийг бэлтгэнэ.

Урвуу нэгдэл

3.2.13. Урвуу нэгдэл хийх гэдэг нь бүртгэлгүй компани бүртгэлтэй Үнэт цаас гаргагчтай нэгдэх замаар Биржид бүртгэгдэх аргыг хэлнэ.

3.2.14. Урвуу нэгдлийн дүнд бий болсон компани нь Биржийн бүртгэлийн шалгуур, шаардлагыг хангасан байх бөгөөд энэ журмын 5 дугаар бүлэгт заасны дагуу шинээр өргөдөл гаргагчийн адил бүртгэлийн өргөдлийг ирүүлнэ.

3.2.15. Энэ аргаар үнэт цаасыг санал болгоход Үнэт цаас гаргагч нь энэ журмын 6 дугаар бүлэгт заасан шаардлагыг хангасан бүртгэлийн баримт бичгийг бэлтгэнэ.

Үнэт цаас хаалттай хүрээнд санал болгох

3.2.16. Үнэт цаас хаалттай хүрээнд санал болгох гэдэг нь Үнэт цаас гаргагч эсхүл түүний нэрийн өмнөөс өөр этгээд зөвхөн урьдчилан сонгосон эсхүл Биржээс

зөвшөөрөгдсөн этгээдэд зориулан үнэт цаасны захиалга авахаар санал болгох эсхүл өөрийн эзэмшлийн үнэт цаасыг худалдахаар санал болгох аргыг хэлнэ.

3.2.17. Энэ аргаар үнэт цаасыг санал болгоход Үнэт цаас гаргагч нь энэ журмын 6 дугаар бүлэгт заасан шаардлагыг хангасан бүртгэлийн баримт бичгийг бэлтгэнэ. Бүртгэлийн баримт бичгийг хялбаршуулсан хэлбэрээр бэлтгэж болох бөгөөд ингэхдээ Биржээс зөвшөөрөл авна.

Үнэт цаас гаргагчийн бүртгэл шилжих

3.2.18. Үнэт цаас гаргагчийн бүртгэл шилжих гэдэг нь бүртгэлтэй Үнэт цаас гаргагч өөрийн бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагатай байгуулсан бүртгэлийн гэрээгээ цуцалж, бусад арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдэх эсхүл Биржийн нэг талбараас нөгөөд шилжихийг хэлнэ.

3.2.19. Үнэт цаас гаргагч нь энэ аргыг ашиглан Биржид бүртгэгдэх тохиолдолд энэ журмын 4 дүгээр бүлэгт заасан бүртгэлийн шалгуурыг бүрэн хангасан байх шаардлагатай бөгөөд Бүртгэлийн хороо зөвшөөрсөн тохиолдолд зарим бүртгэлийн шаардлагаас чөлөөлөгдөж болно.

3.2.20. Үнэт цаас гаргагч энэ аргыг ашиглан Биржид бүртгэгдэх тохиолдолд энэ журмын 6 дугаар бүлэгт заасан үнэт цаасны танилцуулгыг бэлтгэхгүй байж болох бөгөөд ингэхдээ Биржээс зөвшөөрөл авна.

Бусад

3.2.21. Үнэт цаас гаргагч нь өөрийн гаргасан үнэт цаасыг өөр бусад үнэт цаасаар солих, эсвэл өөр бусад үнэт цаасаар сольж болох хөрвөх үнэт цаас гаргах замаар Биржид бүртгүүлж болно. Үнэт цаасыг хөрвүүлэх гэдэгт дараах аргыг ойлгоно. Үүнд:

3.2.21.1. Опцион, варрант эсхүл үнэт цаас авч болох бусад төрлийн үнэт цаасыг хэрэгжүүлэх

3.2.21.2. Хувьцаанд хөрвөх үнэт цаасыг хөрвүүлэх

3.2.21.3. Хувьцааг хуваах эсвэл нэгтгэх

3.2.21.4. Холбогдох хууль, журамд заасан бусад

3.2.22. Энэ журмын 3.2.21-д заасан аргаар үнэт цаасыг санал болгон Биржид бүртгүүлэх тохиолдолд Хорооны холбогдох журамд заасны дагуу хялбаршуулсан хэлбэрээр бүртгэнэ.

3.2.23. Энэ журмын 3.2.21-д заасны дагуу Үнэт цаас гаргагч Биржид бүртгэгдэх тохиолдолд энэ журмын 6 дугаар бүлэгт заасан үнэт цаасны танилцуулгыг бэлтгэхгүй байж болно.

ДӨРӨВ. БҮРТГЭЛИЙН ШАЛГУУР

4.1. Ерөнхий зүйл

4.1.1. Үнэт цаас гаргагч нь энэ журамд заасан Ерөнхий шалгуур, Засаглалын шалгуур болон Санхүүгийн шалгуурыг энэ журмын 3 дугаар бүлэгт заасан үнэт цаас бүртгүүлэх арга, хэлбэрийн алийг сонгосноос үл хамааран тогтмол хангаж ажиллана.

4.1.2. Үнэт цаас гаргагч нь Бирж Бүртгэлийн шалгууруас чөлөөлсөн эсхүл хөнгөлсөн тухай шийдвэр гаргаснаас бусад тохиолдолд энэ бүлэгт заасан бүх шалгуур, шаардлагыг бүрэн хангах үүрэгтэй.

4.1.3. Энэ бүлэгт заасан бүх шалгуурыг хангасан байх нь үнэт цаасыг шууд бүртгэх үндэслэл болохгүй бөгөөд өргөдөл гаргагчийн бүртгүүлэх өргөдлийг хүлээн авч, үнэт цаасны төрлөөс хамааран Биржийн үнэт цаасны талбарт бүртгэх, бүртгэхээс татгалзахыг Бирж өөрийн бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэнэ.

4.1.4. Бирж шаардлагатай гэж үзвэл энэ бүлэгт заагаагүй нэмэлт шалгуурыг Үнэт цаас гаргагчид тавьж болно.

4.1.5. Бүртгүүлэх өргөдөл гаргагч нь Биржийн бүртгэлийн шалгуурыг хангах эсэхийг урьдчилан тодорхойлох зорилгоор Бүртгэл хариуцсан албанаас албан бус зөвлөмж авч болно. Уг зөвлөмжийг талууд нууцлах үүрэг хүлээнэ.

4.2. Ерөнхий шалгуур

4.2.1. Үнэт цаас гаргагч нь дараах ерөнхий шалгуурыг хангасан байна. Үүнд:

4.2.1.1. Үүсгэн байгуулагдсан улсынхаа холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу зохих ёсоор үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн байх

4.2.1.2. Үүсгэн байгуулагдсан улсынхаа холбогдох хууль тогтоомж болон өөрийн үүсгэн байгуулах баримт бичиг, түүнтэй адилтгах бусад баримт бичгийг зохих ёсоор дагаж мөрддөг байх

4.2.1.3. Бизнесийн үйл ажиллагаа нь Биржид бүртгэхэд тохиромжтой байх

4.2.1.4. Үнэт цаасаа Биржид бүртгүүлэхдээ хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрлийг авсан байх

4.2.1.5. Бүртгүүлэх гэж буй үнэт цаасыг Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагдсан улсын холбогдох хууль тогтоомж болон түүний үүсгэн байгуулах баримт бичигт нийцүүлэн гаргасан байх

4.2.1.6. Үнэт цаас гаргагч өөрийн бизнесийн үйл ажиллагаа, бүртгүүлэхээр гаргаж буй үнэт цаасыг сонирхох хангалттай тооны этгээд байгаа гэдгийг Биржид нотолсон байх

4.2.1.7. Бүртгүүлэх гэж буй үнэт цаасыг худалдан авагч чөлөөтэй захиран зарцуулах боломжтой байх

4.2.1.8. Биржид бүртгэгдэхтэй холбогдуулан маркетингийн хөтөлбөр явуулах тусгайлсан төсөв гаргах боломжтой байх

4.2.2. Үнэт цаас гаргагчтай ойрын хамааралтай этгээд нь дараах хугацаанд бүртгүүлэх гэж буй үнэт цаастай холбоотой аливаа хэлцэл хийхийг хориглоно. Үүнд:

4.2.2.1. Бүртгэлтэй Үнэт цаас гаргагчийн тухайд албан ёсоор өргөдөл ирүүлсэн өдрөөс эхлэн бүртгэхийг зөвшөөрсөн шийдвэр гарах хүртэл

4.2.2.2. Шинээр өргөдөл гаргагчийн тухайд бүртгэлийн баримт бичгийн эцсийн төслийг ирүүлсэн хугацаанаас эхлэн арилжаа эхлэх хүртэл.

4.2.3. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан нь энэ зүйлийн 4.2.2-д заасан хэлцэл хийгдсэн, эсхүл хийгдсэн байж болзошгүй нөхцөл байдлын талаар олж мэдсэн даруйд Биржид мэдэгдэх үүрэгтэй. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл түүний холбогдох этгээд нь тухайн хэлцэлд оролцсон нь тогтоогдвол Бирж бүртгэхээс татгалзаж, бүртгэлийн өргөдлийг Буцаах шийдвэр гаргаж болно.

4.3. Засаглалын шалгуур

4.3.1. Үнэт цаас гаргагч нь дараах засаглалын шалгуурыг хангасан байна. Үүнд:

4.3.1.1. 3 (гурав)-аас доошгүй санхүүгийн жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулсан байх

4.3.1.2. Сүүлийн 3 (гурав) санхүүгийн жилийн хугацаанд удирдлагын багийн дийлэнх нь тогтвортой ажилласан байх

4.3.1.3. Сүүлийн 1 (нэг) санхүүгийн жилийн хугацаанд компанийн гол хувьцаа эзэмшигчид нь өөрчлөгдөөгүй байх

4.3.1.4. Гүйцэтгэх захирал нь Монгол улсад байнга оршин суудаг байх

4.3.1.5. ТУЗ-ийн гишүүнээр томилогдох этгээд нь энэ бүлэгт заасан шаардлагыг хангасан байх

4.3.1.6. Энэ бүлэгт заасан шаардлагыг хангасан ТУЗ-ийн нарийн бичгийн даргатай байх.

4.3.1.7. Үнэт цаас эзэмшигчдийн бүртгэл хөтлөх үүрэг бүхий бүртгэлийн ажилтантай байх эсхүл үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагаар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан байх.

Үнэт цаас гаргагчийн ТУЗ, түүний гишүүд

4.3.2. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүд нь Үнэт цаас гаргагчийн удирдлага, үйл ажиллагааны талаар хамтын хариуцлага хүлээнэ. Үнэт цаас гаргагчийн ТУЗ болон түүний гишүүд нь өөрт ногдсон үүргээ Монгол улсын хууль тогтоомжоор тогтоосон шаардлагын хүрээнд биелүүлэх ба үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална. Үүнд:

4.3.2.1. Компанийн ашиг сонирхлыг бүхэлд нь хангахад чиглэсэн үйл ажиллагааг чин шударгаар, хууль тогтоомжид нийцүүлэн хариуцлагатайгаар гүйцэтгэх

4.3.2.2. Компанийн зорилгын төлөө ажиллах

4.3.2.3. Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн захиран зарцуулалтыг Үнэт цаас гаргагчийн өмнө хариуцах

4.3.2.4. Ашиг сонирхлын зөрчил болон үүргийн давхардлаас ангид байх

4.3.2.5. Аливаа гэрээ, хэлцэлтэй холбоотой өөрийн ашиг сонирхлыг Үнэт цаас гаргагчид шударгаар бүрэн мэдэгдэх

4.3.2.6. ТУЗ-ийн гишүүн байхад шаардлагатай мэдлэг чадвар, ажлын туршлагатай байх

4.3.2.7. Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шалгуурыг хангасан байх.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор нэмсэн/

4.3.3. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүн нь ажил үүргээ хариуцлагатай гүйцэтгэх ба өөрийн мэдлэг чадвараа дайчлан ажиллана. Зөвхөн албан ёсны хурлын үеэр Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд анхаарлаа хандуулахыг ажилдаа хариуцлагатай хандсан гэж үзэхгүй ба Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд анхаарлаа байнгын идэвхитэй хандуулж, түүний бизнесийн үйл ажиллагааны талаар тодорхой мэдлэг, мэдээлэлтэй байх шаардлагатай. ТУЗ-ийн гишүүн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй буюу зөрчсөн тохиолдолд Бирж сахилгын хариуцлага ногдуулах эрхтэй ба тус зөрчил нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу иргэний болон эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болж болно.

4.3.4. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүн нь Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүнд байвал зохих зан чанар, туршлага, хараат бус байдал, ёс зүйн болон бусад шаардлагуудыг хангасан болохоо Биржид нотлох үүрэгтэй. Бирж Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүний болон ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийн мэдлэг, ур чадвар, ажлын туршлага, бусад бизнесийн ашиг сонирхлын талаар нэмэлт мэдээллийг Үнэт цаас гаргагчаас шаардан гаргуулж болно.

4.3.5. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүн нь өөрийн үүргээ зохих журмын дагуу бусдад шилжүүлж болно. Ийнхүү чиг үүргээ шилжүүлэх нь тухайн гишүүнийг холбогдох хариуцлага, түүнд тавигдах шаардлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

4.3.6. Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь дараах шаардлагыг хангана. Үүнд:

4.3.6.1. ТУЗ нь 9 (ес)-өөс доошгүй гишүүнтэй байх

4.3.6.2. Нийт гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байх

4.3.6.3. Нэгээс доошгүй хараат бус гишүүн нь нягтлан бодох бүртгэл, санхүүгийн менежментийн чиглэлээр мэргэшсэн байх

4.3.7. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тоо, мэргэжил, ур чадвар нь энэ журмын 4.3.6-т заасан шаардлагад нийцэхгүй болсон бол Үнэт цаас гаргагч энэ талаар Биржид ажлын 2 (хоёр) хоногийн дотор мэдэгдэх бөгөөд түүний үндэслэл, шалтгааныг тус хугацаанд олон нийтэд мэдээлнэ.

4.3.8. Энэ журмын 4.3.6-т заасан шаардлагыг хангахгүй болсноос хойш 2 (хоёр) сарын дотор Үнэт цаас гаргагч нь уг зөрчлийг арилгаж зохих шаардлага хангасан хараат бус этгээдийг ТУЗ-ийн гишүүнээр томилно.

4.3.9. Хараат бус гишүүний хараат бус байдлыг тогтоохдоо Бирж дор дурдсан хүчин зүйлсийг харгалзан үзнэ. Дараах тохиолдолд Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүнийг хараат байх магадлалтай гэж үзнэ. Үүнд:

4.3.9.1. Үнэт цаас гаргагчийн гаргасан хувьцааны нэгээс дээш хувийг эзэмшиж байгаа бол

Энэ зүйлд заасан нэг хувийн эзэмшлийг тодорхойлохдоо хараат бус гишүүн болон түүнд нэр дэвшигчийн өөрийн шууд бөгөөд эцсийн өмчлөгчийн хувьд эзэмшиж байгаа хувьцаанаас гадна түүний эзэмшлийн опцион, хувьцаанд хөрвөх үнэт цаас болон хувьцаанд хөрвөж болох бусад эрхийг харгалзан үзнэ.

4.3.9.2. Үнэт цаас гаргагч буюу түүнтэй ойрын хамааралтай этгээдээс Үнэт цаас гаргагчийн аливаа төрлийн үнэт цаасыг эзэмших эрхийг бэлгэнд эсвэл бусад санхүүгийн дэмжлэг хэлбэрээр авсан бол

Үнэт цаас гаргагч буюу түүний охин компаниас хувьцаа, бусад үнэт цаас эзэмших эрхийг ТУЗ-ийн гишүүний ажлын хөлсөнд авсан бол энэ зүйлд хамаарахгүй.

4.3.9.3. Хараат бус гишүүнээр томилогдох үедээ, эсхүл томилогдсон өдрөөс өмнөх 1 (нэг) жилийн хугацаанд дор дурдсан этгээдэд мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг буюу үзүүлж байсан этгээдийн ТУЗ-ийн гишүүн, удирдах албан тушаалтан, хувьцаа эзэмшигч, түүнчлэн дээр заасан хугацаанд дор дурдсан этгээдүүдэд мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэхэд оролцож байсан байгууллагын ажилтан бол

a. Бүртгэлтэй Үнэт цаас гаргагч, түүний толгой, охин компани, эсхүл ойрын хамааралтай этгээд;

b. Түүнийг хараат бус гишүүнээр томилогдохоос өмнөх 1 (нэг) жилийн дотор Үнэт цаас гаргагчийн хяналтын багц эзэмшигч, хяналтын багц эзэмшигч байхгүй тохиолдолд түүний гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүн (хараат бус гишүүн хамаарахгүй)-ээр ажиллаж байсан хүн, тэдгээрийн холбогдох этгээд.

4.3.9.4. Үнэт цаас гаргагч, түүний толгой, зэргэлдээ, охин компани болон тэдгээрийн ойрын хамааралтай этгээд бизнесийн үндсэн үйл ажиллагаанд ноцтой ашиг сонирхолтой, түүнчлэн тэдгээрийн аль нэгтэй том хэмжээний бизнесийн гэрээний харилцаанд оролцогч тал бол

4.3.9.5. Үнэт цаас гаргагчийн нийт хувьцаа эзэмшигчдээс зөрүүтэй эрх ашиг бүхий этгээдийн эрх ашгийг хамгаалах зөвлөлийн гишүүн бол

4.3.9.6. Хараат бус гишүүнээр томилогдох үед, эсхүл томилогдохоос өмнөх 2 (хоёр) жилийн хугацаанд Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх захирал, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчтэй хамааралтай этгээд байсан бол

4.3.9.7. Хараат бус гишүүнээр томилогдох үед, эсхүл томилогдохоос өмнөх 2 (хоёр) жилийн хугацаанд Үнэт цаас гаргагч, түүний толгой, зэргэлдээ, охин компанийн, эсхүл Үнэт цаас гаргагчтай нэгдмэл сонирхолтой этгээдийн ТУЗ-ийн гишүүн (хараат бус гишүүн хамаарахгүй), гүйцэтгэх удирдлага байсан бол

4.3.9.8. Үнэт цаас гаргагч, түүний толгой, зэргэлдээ, охин компани, эсхүл Үнэт цаас гаргагчтай ойрын хамааралтай этгээдээс санхүүгийн хувьд хараат бол.

4.3.10. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн хараат бус гишүүн нь Биржид дор дурдсан агуулга бүхий баталгааг бичгээр гаргана. Үүнд:

4.3.10.1. Энэ журмын 4.3.9-д заасан хараат бус байдлын шалгуур нэг бүрийг хангаж байгаа тухай

4.3.10.2. Үнэт цаас гаргагч, түүний охин компанийн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой санхүүгийн болон бусад хувийн ашиг сонирхол өнгөрсөн хугацаанд байсан, эсхүл одоо байгаа бол, түүнчлэн Үнэт цаас гаргагчтай ойрын хамааралтай этгээдтэй аливаа харилцан хамааралтай бол энэ тухай

4.3.10.3. Энэ журмын Хавсралт 13, 14-т заасан мэдүүлэг, амлалт гаргах үед түүний хараат бус байдалд нөлөөлөхүйц бусад хүчин зүйл байгаагүй тухай.

4.3.11. Үнэт цаас гаргагчийн Биржийн бүртгэлийн журмыг дагаж мөрдөөгүйгээс үүдэн гарах хариуцлагыг ТУЗ-ийн гишүүд хамтаар болон дангаар хүлээхийг ТУЗ-ийн гишүүдээр зөвшөөрүүлсэн байна.

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн аудитын хороо

4.3.12. Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь аудитын хороотой байна. Аудитын хороо нь гурваас доошгүй гишүүнтэй байх ба нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүдээс бүрдэнэ. Бүртгэлтэй Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагыг багаар хэрэгжүүлдэг бол гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн нь аудитын хорооны гишүүн байхыг хориглоно.

4.3.13. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байх бөгөөд хараат бус гишүүдийн нэгээс доошгүй нь нягтлан бодох бүртгэл, санхүүгийн чиглэлээр мэргэшсэн байна.

4.3.14. Аудитын хорооны эрх, үүргийг тодорхойлсон журмыг бүртгэлтэй Үнэт цаас гаргагчийн ТУЗ батална.

4.3.15. Аудитын хороо нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдана.

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн цалин, урамшууллын хороо

4.3.16. Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь цалин, урамшууллын хороотой байна. Цалин, урамшууллын хорооны дарга ТУЗ-ийн хараат бус гишүүн байна. Бүртгэлтэй Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагыг багаар хэрэгжүүлдэг бол гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн нь цалин, урамшууллын хорооны гишүүн байхыг хориглоно.

4.3.17. Цалин, урамшууллын хорооны эрх, үүргийг тодорхойлсон журмыг бүртгэлтэй Үнэт цаас гаргагчийн ТУЗ батална.

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

4.3.18. Бүртгэлтэй Үнэт цаас гаргагч нь энэ журмын 4.3.19-д заасан шаардлагыг хангасан этгээдийг ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүрэгт ажилд томилж ажиллуулна.

4.3.19. Бүртгэлтэй Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь мэргэжил, ур чадвар, ажлын туршлагын хувьд дараах шаардлага хангасан байна. Үүнд:

4.3.19.1. Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдсан байх

4.3.19.2. Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Бүртгэлийн журмын талаар зохих мэдлэгтэй байх

4.3.19.3. Мэргэжлээрээ 2 (хоёр)-оос доошгүй жил ажилласан туршлагатай байх

4.3.19.4. Ажил үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад мэдлэг, чадвартай байх.

4.4. Санхүүгийн шалгуур

4.4.1. Үнэт цаас гаргагч нь тухайн гаргаж буй үнэт цаас төрлөөс хамаарч энэ журмын 7 дугаар бүлэгт заасан санхүүгийн шалгуурыг хангана.

4.5. Нэмэлт шалгуур

Уул уурхайн компанид тавигдах нэмэлт шаардлага

4.5.1. Биржид үнэт цаасаа бүртгүүлэх хүсэлтэй Үнэт цаас гаргагч нь уул уурхайн компани байх тохиолдолд дараах нэмэлт шалгуурыг хангасан байна. Үүнд:

4.5.1.1. Ашигт малтмалын үйл ажиллагаа явуулах, үйлдвэрлэл эрхлэх, хөрөнгө эзэмших зэрэг холбогдох тусгай зөвшөөрлийг эрх бүхий байгууллагаас авсан байх

4.5.1.2. Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр судалгаа, хайгуул эсхүл олборлолт хийгдсэн байх

4.5.1.3. Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай батлагдсан болон тооцоолсон нөөцтэй байх

4.5.1.4. Нийт хөрөнгө, орлого, үйл ажиллагааны зардал, татварын дараах цэвэр ашгийн 25 (хорин тав)-аас дээш хувь нь олборлолт эсхүл хайгуулын үйл ажиллагаатай холбоотой байх

4.5.1.5. Уул уурхайн чиглэлээр 5 (тав)-аас доошгүй жил ажилласан туршлагатай, хараат бус ТУЗ-ийн гишүүн хамгийн багадаа 1 (нэг) байх

4.5.1.6. Олборлолт, хайгуул, хөрөнгө эзэмшилтэй холбоотой зардлууд, үйл ажиллагааны зардлыг нөхөх ажлын капиталтай байх, 18 (арван найм) сарын турш хангалттай байх;

4.5.1.7. Олборлолт, хайгуулын ажилд зориулагдах төсөвтэй байх

4.5.1.8. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт (JORC, SAMREC, NI 43-101 гэх мэт)-ын дагуу тайлан гаргаж, эрх бүхий этгээд (Competent person)-ээр баталгаажуулан, олон нийтэд тогтмол тайлагнадаг байх.

Дэд бүтцийн төсөл хэрэгжүүлэгчид тавигдах нэмэлт шаардлага

4.5.2. Дэд бүтцийн төсөл гэж улс, бүс нутгийн эдийн засгийн хөгжилд чухал ач холбогдолтой нийгмийн суурь бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд хүргэхэд шаардлагатай барилга, байгууламж бүтээн байгуулахад чиглэсэн төслийг хэлнэ.

4.5.3. Дэд бүтцийн төсөлд авто зам, гүүр, нүхэн гарц, төмөр зам, транзитийн систем, ус суваг, цахилгаан эрчим хүчний станц, цахилгаан холбооны систем, далайн боомт, онгоцны буудал зэргийг барьж байгуулах төсөл хамаарна.

4.5.4. Дэд бүтцийн төслийг хэрэгжүүлэх Үнэт цаас гаргагч нь дараах нэмэлт шалгуурыг хангасан байна. Үүнд:

4.5.4.1. Дэд бүтцийн төслийн объектыг бүтээн байгуулах, эсхүл бүтээн байгуулсан дэд бүтцийн үйл ажиллагааг хариуцах эрхийг дангаараа буюу бусадтай хамтарч авсан байх. Төслийг өргөдөл гаргагч өөрөө буюу охин, хамтарсан компаниараа дамжуулан хэрэгжүүлж болно. Төслийг санхүүжүүлэгч боловч хэрэгжүүлэх үүрэг хүлээгээгүй компанийн хувьд энэ журмын 4.5.4.1 дахь заалт хамаарахгүй байх

4.5.4.2. Бүртгүүлэх үед холбогдох дэд бүтцийн төсөл хэрэгжүүлэх зөвшөөрөл, гэрээнд заасан үйл ажиллагаанаас өөр ямар нэг бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэггүй байх

4.5.4.3. Дэд бүтцийн төсөл нь засгийн газраас олгосон урт хугацааны (бүртгэл хийлгэснээс хойш 15 (арван тав)-аас доошгүй жил үргэлжлэх) эрх, эсхүл концессын дагуу хэрэгжих, томоохон хэмжээний төсөл байх

4.5.4.4. Томоохон хэмжээний төсөл байх шалгуурыг хангахын тулд өргөдөл гаргагч компанийн зүгээс төсөлд зориулж гаргасан капитал зардлын хэмжээ 500,000,000 (таван зуун сая) төгрөгөөс багагүй байх

4.5.4.5. Өргөдөл гаргагч нэгээс илүү тооны төсөлд оролцож байгаа бол түүний оролцож байгаа төслүүдийн олонх нь барилга угсралтын буюу түүнээс өмнөх шатанд явагдаж байх

4.5.4.6. Үнэт цаас гаргаснаар татан төвлөрүүлэх хөрөнгийн дийлэнх хувийг төслийн барилга угсралтын үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулах ба өр төлбөр эргүүлэн төлөх, эсхүл дэд бүтцийн холбогдолгүй хөрөнгө худалдан авахад зарцуулахгүй байх

4.5.4.7. Бүртгүүлснээс хойш эхний 3 (гурван) жилийн хугацаанд Үнэт цаас гаргагч өөрөө, эсхүл түүний охин буюу хамтарсан компани нь холбогдох дэд бүтцийн төсөл хэрэгжүүлэх зөвшөөрөл, гэрээнд заасан үйл ажиллагааг өөрчлөхөд хүргэх хөрөнгө худалдаж авахгүй байх, түүнчлэн тийм үр дүнд хүргэх бусад үйл ажиллагаанд оролцохгүй байх

4.5.4.8. Өргөдөл гаргагчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон удирдлагын баг нь тухайн төслийг амжилттай хэрэгжүүлж дуусгахад шаардлагатай мэргэжлийн туршлага, техникийн мэдлэг, санхүүгийн чадавхтай байх. Үүнд: ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага нь тухайн салбартаа 3 (гурав)-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх

4.5.4.9. Бизнесийн үнэлгээ, техник эдийн засгийн үндэслэл, мэдрэмжийн шинжилгээ, мөнгөн урсгалын төлөвлөлт зэрэг Биржийн шаардсан мэдээллийг бүртгэлийн баримт бичигт тусгах.

4.6. Бүртгэлийн шалгуураас хөнгөлөх, чөлөөлөх

4.6.1. Үнэт цаас гаргагч нь дараах хэлбэрээр бүртгэлийн шалгуураас хөнгөлөгдөж эсхүл чөлөөлөгдөж болно. Үүнд:

4.6.1.1. Биржийн ТУЗ-өөс олгосон эрхийн дагуу Гүйцэтгэх захирал зөвшөөрсөн тохиолдолд бүртгэлийн өргөдлийн хураамжаас хөнгөлөгдөх, чөлөөлөгдөх

4.6.1.2. Бүртгэлийн хороо зөвшөөрсөн тохиолдолд Биржийн бүртгэлийн шалгуурыг тодорхой хугацааны дотор хангахаар хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх

4.6.1.3. Бүртгэлийн хороо зөвшөөрсөн тохиолдолд зарим бүрдүүлэх бичиг баримтаас чөлөөлөгдөх

4.6.2. Дараах төрлийн Үнэт цаас гаргагч нь бүртгэлийн шалгуураас хөнгөлөгдөж эсхүл чөлөөлөгдөж болно. Үүнд:

4.6.2.1. Арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй, үйл ажиллагаа нь тогтвортой, компанийн засаглалын кодексийг бүрэн хэрэгжүүлж ажиллаж буй бүртгэлтэй Үнэт цаас гаргагч бол

4.6.2.2. Монгол улсын тэргүүлэх эсхүл хөгжүүлэхээр анхаарч буй салбарт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд бол

4.6.2.3. Үйл ажиллагаа дөнгөж эхэлж буй гарааны бизнес бөгөөд цаашид үйл ажиллагаа нь өргөжих бүрэн боломжтой хуулийн этгээд бол

4.6.2.4. Олон улсын болон Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан үйл ажиллагаа явуулж, Монгол улсын ногоон таксономиг мөрдөж ажиллаж буй хуулийн этгээд бол

4.6.2.5. Биржээс дэмжлэг шаардлагатай гэж үзсэн бусад салбарт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд бол.

4.6.3. Үнэт цаас гаргагч нь дор дурдсан шаардлагыг нэгэн зэрэг хангасан гэдгээ нотолсон тохиолдолд энэ журмын 7 дугаар бүлэгт заасан зах зээлийн үнэлгээ/орлогын шалгуурт заасан хугацааны шаардлагыг Бирж багасгаж болно. Үүнд:

4.6.3.1. Шинээр өргөдөл гаргагчийн ТУЗ-ийн гишүүд, удирдлагын баг нь тухайн салбартаа 3 (гурав)-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх. Шинээр өргөдөл гаргагч нь энэ шаардлагыг хангасан болохыг нотолсон мэдээллийг бүртгэлийн баримт бичигт тусгах

4.6.3.2. Сүүлийн 1 (нэг) санхүүгийн жилийн хугацаанд удирдлагын багийн дийлэнх нь тогтвортой ажилласан байх.

4.6.4. Дор дурдсан тохиолдолд Бирж энэ журамд заасан үйл ажиллагаа явуулах хугацаанд тавигдах шаардлага, ашгийн болон бусад санхүүгийн стандарт шаардлагыг өөрчлөх буюу түүнээс чөлөөлж болно. Үүнд:

4.6.4.1. Үнэт цаас гаргагч нь Биржээс тавьсан шаардлагыг хангасан уул уурхайн компани бол

4.6.4.2. Үнэт цаас гаргагч нь шинээр байгуулагдсан төсөл хэрэгжүүлэх компани (томоохон дэд бүтцийн төсөл хэрэгжүүлэх зорилгоор байгуулагдсан компани үүнд хамаарна) бол

4.6.4.3. Үнэт цаас гаргагч, эсхүл түүний нэгдэл нь сүүлийн 2 (хоёр) бүтэн санхүүгийн жил үйл ажиллагаа явуулсан бөгөөд Үнэт цаас гаргагч, түүний гаргасан үнэт цаас нь хөрөнгө оруулагчдын сонирхлыг ихээр татаж байгаа, түүнчлэн хөрөнгө оруулагчид шийдвэр гаргахад хангалттай мэдээллээр хангагдсан гэж Бирж үзсэн бол

4.6.5. Үнэт цаас гаргагч нь бүртгүүлэх өргөдөл гаргахаар төлөвлөсөн хугацаанаас 30 (гуч)-аас доошгүй хоногийн өмнө Биржид энэ журамд заасан бүртгэлийн шалгуур, шаардлагаас чөлөөлүүлэх хүсэлт гаргаж болно.

4.6.6. Энэ журмын 4.6.5-т заасан хүсэлтийг Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл андеррайтер гаргасан байна. Тус хүсэлтэд чөлөөлүүлэхийг хүссэн шаардлага, түүний тайлбар, үндэслэлийг тусгана.

4.6.7. Бирж Үнэт цаас гаргагчийн бүртгэлийн шалгуур, шаардлагаас чөлөөлүүлэх хүсэлтийг 14 (арван дөрөв) хоногийн дотор шийдвэрлэж үнэт цаас гаргагчид шийдвэрийг хүргүүлнэ. Үнэт цаас гаргагч тус шийдвэрт гомдол гаргах эрхгүй.

ТАВ. ҮНЭТ ЦААС БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ ГАРГАХ

5.1. Ерөнхий зүйл

5.1.1. Энэхүү бүлгээр олон нийтэд санал болгон шинээр эсхүл нэмж гаргах үнэт цаасыг Биржид бүртгүүлэх үйл ажиллагаа, түүний үе шат болон бүртгүүлэх өргөдөлд тавигдах шаардлагыг тодорхойлно.

5.1.2. Өргөдөл гаргагч нь бүртгүүлэх өргөдөл анх ирүүлснээс хойш 6 (зургаа) сарын дотор үнэт цаасаа Биржид бүртгүүлээгүй бол дахин шинээр өргөдөл гаргах ба бүртгэлийн хураамж дахин төлнө.

5.1.3. Бүртгүүлэх өргөдөлд үнэт цаас бүртгүүлэх ажлын хуваарийн төслийг тусгана. Ажлын хуваарийн төслийг Бирж, өргөдөл гаргагч нар харилцан тохиролцож эцэслэнэ. Бүртгүүлэх ажиллагаа ажлын хуваариас хоцорсон боловч анх бүртгүүлэх өргөдөл гаргаснаас хойш 6 (зургаа) сар өнгөрөөгүй бол өргөдөл гаргагч нь шинэчилсэн ажлын хуваарийг Биржтэй тохиролцож тогтооно.

5.1.4. Үнэт цаасны зах зээлийн шударга, ил тод, үр ашигтай байдлыг хангах зорилгоор Бирж Ажлын хуваарьт өөрчлөлт оруулах, өргөдлийг буцаах эрхтэй. Бүртгүүлэх өргөдөл, бүртгэлийн баримт бичгийн анхны төсөл, бусад баримт бичигт Бирж аливаа санал, шаардлага гаргахгүйгээр Буцаах шийдвэр гаргасан тохиолдолд бүртгэлийн хураамжийг буцаан олгоно. Буцаах шийдвэр гарснаас хойш 1 (нэг) сараас багагүй хугацааны дараа Үнэт цаас гаргагч бүртгүүлэх өргөдөл, холбогдох баримт бичгийг шинээр үйлдэж дахин ирүүлж болно.

5.1.5. Өргөдөл гаргагч нь хоёр долоо хоног тутамд бүртгүүлэх ажиллагааны явцын талаарх мэдээллийг Биржид цахим шуудан эсвэл албан бичиг ашиглан бичгээр ирүүлнэ.

5.1.6. Бирж шаардлагатай гэж үзвэл өргөдөл гаргагчийг Биржийн бүртгэлийн шалгуурыг хангаж байгаа эсэхийг тодруулах зорилгоор энэ журамд заагаагүй нэмэлт баримт бичиг, мэдээлэл ирүүлэхийг өргөдөл гаргагчаас шаардаж болно.

5.2. Шинээр өргөдөл гаргагч үнэт цаас бүртгүүлэх

5.2.1. Үнэт цаасаа бүртгүүлэхээр шинээр өргөдөл гаргагчийн Биржид үнэт цаасаа бүртгүүлэх үйл ажиллагаа дараах үе шаттайгаар хэрэгжинэ. Үүнд:

5.2.1.1. Андеррайтертай гэрээ байгуулах

5.2.1.2. Бүртгүүлэх өргөдөл анх гаргах, түүнийг хянах

5.2.1.3. Бүртгэлийн баримт бичгийн эцсийн төслийн талаарх урьдчилсан зөвлөгөөн хийх

5.2.1.4. Бүртгэлийн баримт бичгийн эцсийн төслийг холбогдох баримт бичгийн хамт ирүүлэх

5.2.1.5. Бирж өргөдлийг хэлэлцэж шийдвэрлэх

5.2.1.6. Үнэт цаас гаргагч Хорооноос холбогдох зөвшөөрлийг авах

5.2.1.7. Бүртгэлийн баримт бичгийг хэвлэх, батламжлах

5.2.1.8. Бүртгэлийн баримт бичгийг олон нийтэд танилцуулах

5.2.1.9. Анхдагч зах зээлд хуваарилалт хийхээс өмнө

5.2.1.10. Үнэт цаасыг анхдагч зах зээлд хуваарилах

5.2.1.11. Бирж Үнэт цаас гаргагчийн бүртгэлийг батлах, бүртгэлийн гэрээ байгуулах

5.2.1.12. Нийцүүлэгчтэй гэрээ байгуулах

5.2.1.13. Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох

Андеррайтертай гэрээ байгуулах

5.2.2. Шинээр өргөдөл гаргагч андеррайтертай гэрээ байгуулсны үндсэн дээр Биржид үнэт цаас бүртгүүлэх өргөдөл гаргана. Андеррайтертай байгуулах гэрээнд шинээр өргөдөл гаргагчийн дараах асуудлыг тодорхой тусгана. Үүнд:

5.2.2.1. Андеррайтерийг магадлан шинжилгээ бүрэн хийх бүх бололцоог хэрхэн хангах тухай

5.2.2.2. Шинээр өргөдөл гаргахад оролцох бусад этгээд (шинжээч, гуравдагч этгээд зэрэг)-тэй харилцах, тэднээс шаардлагатай мэдээлэл авах, тэдний гаргасан холбогдох дүгнэлт, баримт бичигтэй бүрэн танилцах боломжоор хэрхэн хангах тухай

5.2.2.3. Хууль тогтоомж болон энэхүү журамд заасан үүргийнхээ хүрээнд эрх бүхий этгээдийг шаардлагатай мэдээллээр бүрэн хангахад нь туслалцаа хэрхэн үзүүлэх тухай

5.2.2.4. Хууль тогтоомж болон энэхүү журмын дагуу өмнө өгсөн мэдээлэлд өөрчлөлт орсон бол энэ талаар андеррайтерт ажлын 3 (гурав) хоногийн дотор мэдэгдэх тухай

5.2.2.5. Хууль тогтоомжид заасны дагуу хувьцааны үнийг тогтворжуулах ажиллагааг андеррайтер хийх тохиолдолд нөхцөл, хугацаа, үүрэг, зардлыг харилцан тохиролцсон тухай мэдээлэл

5.2.2.6. Энэ зүйлийн (5.2.1.1) - (5.2.1.4)-т заасан аливаа мэдээллийг олж авахад андеррайтерт шаардлагатай зөвшөөрөл олгох, гуравдагч этгээдээс зөвшөөрөл авах тохиолдолд шаардлагатай туслалцаа үзүүлэх тухай

5.2.2.7. Энэ зүйлийн (5.2.1.2)-т заасны дагуу андеррайтертай харилцах, тэдэнд шаардлагатай мэдээлэл, баримт бичиг гарган өгөх нөхцөлийг шинжээч

бусад гуравдагч этгээдтэй харилцан тохиролцох, тэдэнтэй байгуулах гэрээнд тусгах тухай.

5.2.3. Шинээр өргөдөл гаргагчтай гэрээ байгуулсан андеррайтер нь шинээр өргөдөл гаргагчийн өмнөөс бүртгүүлэх өргөдөл гаргах, бүртгэлийн баримт бичгийг бэлтгэх, боловсруулах, бүрдүүлэх, бүртгэлийн асуудлаар Биржтэй харилцах зэргээр үнэт цаас бүртгүүлэхтэй холбоотой ажиллагааг хариуцна.

5.2.4. Шинээр өргөдөл гаргагч болон түүний эрх бүхий албан тушаалтнууд нь андеррайтерт гэрээ болон хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд нь дэмжлэг үзүүлэх ба өөрийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, холбогдох этгээдээс тэдний үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх боломжоор хангаж ажиллана.

5.2.5. Шинээр өргөдөл гаргагч нэгээс дээш тооны андеррайтертай гэрээ байгуулж болох ба энэ тохиолдолд үнэт цаас бүртгүүлэх өргөдөлтэй холбоотой асуудлаар Биржтэй голлон харилцах үүрэг бүхий нэг андеррайтерийг сонгож, сонгосон андеррайтерийн талаар Биржид бичгээр мэдэгдэнэ.

5.2.6. Шинээр өргөдөл гаргагчийн сонгосон андеррайтер нь хараат бус байх бөгөөд гэрээгээр хүлээсэн үүргээ бусдын нөлөөнд авталгүй, чин шударгаар гүйцэтгэнэ.

5.2.7. Шинээр өргөдөл гаргагчийн сонгосон андеррайтер Үнэт цаас гаргагч зөвшөөрсөн тохиолдолд гэрээний үндсэн дээр нэг болон түүнээс дээш туслах андеррайтертай гэрээ байгуулж, хувьцааг нийтэд санал болгох ажиллагааг хамтран хэрэгжүүлж болно. Энэ тохиолдолд үндсэн андеррайтер нь туслах андеррайтерийн үйл ажиллагааг Бирж болон Үнэт цаас гаргагчийн өмнө бүрэн хариуцна

5.2.8. Бирж нь андеррайтерийн санхүүгийн болон бусад байдлын талаар Үнэт цаас гаргагчаас баримт материал шаардах эрхтэй ба хэрэв андеррайтер нь холбогдох шаардлагыг хангахгүй гэж үзвэл Бирж өргөдлийг буцаах, эсхүл андеррайтерийг солихыг шаардах эрхтэй.

Бүртгүүлэх өргөдөл анх гаргах, түүнийг хянах

5.2.9. Шинээр өргөдөл гаргагч нь бүртгүүлэх өргөдлийг энэ журмын Хавсралт 1-т заасны дагуу гаргана. Шинээр өргөдөл гаргагчийн андеррайтер нь маягтыг Биржид дор дурдсан баримтуудын хамт ирүүлнэ. Үүнд:

5.2.9.1. Энэ журмын 6.2.1-т заасан баримт бичгүүд

5.2.9.2. Бүртгэлийн хураамж төлсөн баримт.

5.2.10. Энэ журмын 6.2.1-т заасан баримт бичиг нь бүртгүүлэх өргөдөл гарснаас хойш эцэслэж тодорхой болохоос бусад хууль тогтоомж болон энэ журамд тусгахаар заасан аливаа мэдээллийг бүрэн агуулсан байна.

5.2.11. Өргөдөл гаргагч нь Биржийн тавьсан шаардлагыг тухай бүр бүрэн биелүүлэх үүрэгтэй ба бүртгүүлэх ажлын хуваарийг Биржтэй харилцан тохиролцож тогтооно.

5.2.12. Өргөдөл гаргагч бүртгүүлэх ажлын хуваарийг бүртгүүлэх өргөдөлд хавсаргах бөгөөд Ажлын хуваарьт дараах үйл ажиллагааны хугацааг тодорхойлсон байна. Үүнд:

5.2.12.1. Өргөдөл анх гаргах

5.2.12.2. Бүртгэлийн баримт бичгийн эцсийн төслийн талаар урьдчилсан зөвлөгөөн хийх

5.2.12.3. Бүртгэлийн баримт бичгийн эцсийн төслийг холбогдох баримт бичгийн хамт ирүүлэх

5.2.12.4. Бирж өргөдлийг хэлэлцэж шийдвэрлэх

5.2.12.5. Үнэт цаасыг Хороонд бүртгүүлэх, анхдагч зах зээлд санал болгох зөвшөөрөл авах

5.2.12.6. Бүртгэлийн баримт бичгийг хэвлэх

5.2.12.7. Бүртгэлийн баримт бичгийг батламжлах

5.2.12.8. Бүртгэлийн баримт бичгийг олон нийтэд танилцуулах

5.2.12.9. Захиалга авах, захиалгыг хаах

5.2.12.10. Захиалга дүгнэх, үнэ тогтоох

5.2.12.11. Хуваарилалт хийх

5.2.12.12. Арилжаалах зөвшөөрөл авах

5.2.12.13. Гэрээ байгуулах

5.2.12.14. Бирж Үнэт цаас гаргагчийн бүртгэлийг батлах.

5.2.13. Бирж нь өргөдөл гаргагч өргөдөл, бүртгэлийн баримт бичгийн анхны төсөл, бусад баримт бичгийн бүрдүүлбэрийг ирүүлснээс хойш 14 (арван дөрөв) хоногийн дотор хянаж, шаардлагатай гэж үзвэл дараах арга хэмжээг авах эрхтэй. Үүнд:

5.2.13.1. Бүртгэлийн баримт бичгийн анхны төсөлд санал өгөх, нэмэлт, өөрчлөлт оруулах талаар шаардлага тавих

5.2.13.2. Өргөдөл гаргагчаас нэмэлт тайлбар, тодруулга авах, уулзалт зохион байгуулах

5.2.13.3. Анхан шатны баримт бичиг, эрх бүхий албан тушаалтны шийдвэр, хурлын тэмдэглэл зэрэг нэмэлт баримт бичиг гаргуулах

5.2.13.4. Бүртгэлийн баримт бичгийн анхны төсөл, бусад баримт бичигт заасан мэдээллийн дэлгэрэнгүй болон түүнийг нотлох баримтыг шаардах

5.2.13.5. Эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас лавлагаа гаргуулах

5.2.13.6. Хөндлөнгийн шинжээч томилох, хууль зүйн болон аудитын дүгнэлт, хөрөнгийн үнэлгээг эргэлзээтэй гэж үзвэл өөр этгээдээр дүгнэлт, тайлан гаргуулахыг шаардах

5.2.13.7. Шаардлагатай гэж үзвэл биечлэн үзлэг, шалгалт хийх, үзлэг, шалгалт хийх нөхцөлөөр хангахыг шаардах

5.2.13.8. Бүртгүүлэх ажлын хуваарийг тохирох

5.2.13.9. Өргөдлийг буцаах

5.2.13.10. Шаардлагатай бусад арга хэмжээ.

Бүртгэлийн баримт бичгийн эцсийн төслийн талаарх урьдчилсан зөвлөгөөн хийх

5.2.14. Бирж нь энэ журамд заасны дагуу өргөдөл гаргагчаас бүртгэлийн баримт бичигт өөрчлөлт оруулахыг шаардаж, тухайн өөрчлөлтийн талаар хэлэлцэх, бүртгэлийн баримт бичгийг Бүртгэлийн хороонд шилжүүлэхтэй холбогдуулан бүртгэлийн баримт бичгийг бүрэн эсэхийг эцсийн байдлаар нягтлах зорилгоор Бүртгэлийн баримт бичгийн эцсийн төслийн талаарх урьдчилсан зөвлөгөөн зохион байгуулна.

5.2.15. Тохиролцсон бүртгэлийн ажлын хуваарийн дагуу эцсийн төслийн талаарх урьдчилсан зөвлөгөөнд Үнэт цаас гаргагч Биржийн тавьсан санал, шаардлагыг бүртгэлийн баримт бичгийн төсөл болон бусад баримт бичигт бүрэн тусгасан байх үүрэгтэй.

5.2.16. Өргөдөл гаргагч нь энэ журмын 5.2.15-д заасан шаардлагыг бүрэн хангасан гэж үзвэл Бирж бүртгэлийн баримт бичгийн эцсийн төслийг ирүүлэхийг зөвшөөрнө. Тус шаардлага хангагдаагүй гэж үзсэн эсхүл Биржээс нэмэлт санал, шаардлага тавьсан бол тэдгээрийг бүрэн тусгахыг өргөдөл гаргагчид үүрэг болгох ба харилцан тохиролцож Ажлын хуваарьт өөрчлөлт оруулж болно.

Бүртгэлийн баримт бичгийн эцсийн төслийг холбогдох баримт бичгийн хамт ирүүлэх

5.2.17. Бүртгэлийн баримт бичгийн эцсийн төслийг Бирж өргөдөл хэлэлцэхээр товлосон өдрөөс ажлын 5 (тав) хоногийн өмнө ирүүлнэ.

5.2.18. Өргөдөл гаргагч нь бүртгэлийн баримт бичгийн эцсийн төсөлд Биржээс гаргасан санал, шаардлагыг бүрэн гүйцэд тусгасан байна. Энэ шаардлагыг хангаагүй тохиолдолд түүнийг эцсийн төсөл гэж үзэхгүй ба энэ тохиолдолд Бирж өргөдлийг хэлэлцэхгүй.

5.2.19. Бүртгэлийн баримт бичгийн эцсийн төсөлд шинээр өргөдөл гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд, үүнд төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч, мөн андаррейтерийн гүйцэтгэх захирал гарын

үсэг зурж, тамга дарж баталгаажуулсан байна.

5.2.20. Бүртгэлийн баримт бичгийн эцсийн төсөлд энэ журмын 6.2.2-д заасан баримт бичгийг хавсарган Биржид ирүүлнэ.

Бирж өргөдлийг хэлэлцэж шийдвэрлэх

5.2.21. Биржийн санал, шаардлагыг бүрэн тусгасан бүртгэлийн баримт бичгийн эцсийн төсөл болон бусад баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 14 (арван дөрөв) хоногийн дотор Бирж өргөдлийг хэлэлцэж үнэт цаасыг бүртгэх эсэх шийдвэр гаргана.

5.2.22. Бүртгэлийн хороо дараах тохиолдолд өргөдөл хэлэлцэх хугацааг сунгаж болно. Үүнд:

5.2.22.1. Бүртгэлийн баримт бичигт тамга тэмдэг, гарын үсэг дутуу гэх мэт техникийн шинж чанартай өөрчлөлт орох бол ажлын 5 (тав) хүртэл хоногоор сунгах

5.2.22.2. Эрсдэлийн үнэлгээ болон тооцоололтой холбоотой бүртгэлийн баримт бичигт өөрчлөлт орох, Бүртгэлийн хороо нь төсөвлөсөн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт, ирээдүйн бизнес төлөвлөгөөнд хуулийн дүгнэлт нэмэлтээр бэлтгэж ирүүлэхийг шаардах тохиолдолд ажлын 10 (арав) хүртэл хоногоор сунгах

5.2.22.3. Аудитын дүгнэлт, хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ, хуулийн дүгнэлтэд өөрчлөлт орох шаардлагатай тохиолдолд дүгнэлтүүдийг бүрэн ирүүлтэл ажлын 20 (хорь) хүртэл хоногоор сунгах.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

5.2.23. Бирж дараах тохиолдолд үнэт цаас бүртгүүлэх өргөдлийг буцаах, бүртгэлийн ажиллагааг зогсоох, бүртгэхээс татгалзах бүрэн эрхтэй. Үүнд:

5.2.23.1. Үнэт цаасыг худалдан авах эрэлт байхгүй гэж үзэх

5.2.23.2. Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах тухай холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг хангаагүй гэж үзэх

5.2.23.3. Өргөдөл гаргагч нь Биржид бүртгэгдэхэд тохиромжгүй этгээд гэж үзэх

5.2.23.4. Энэ журмын 5.2.22-т заасан хугацаанаас дээш хугацаагаар сунгах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд бүртгэхээс татгалзах.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор нэмсэн/

Үнэт цаасыг Хороонд бүртгүүлэх

5.2.24. Бирж өргөдлийг хэлэлцэн үнэт цаасыг бүртгэх шийдвэр гаргасан тохиолдолд Биржийн бүртгэлд бүртгэсэн болон холбогдох бэлтгэлийг хангасан тухай тодорхойлолтын хамт Үнэт цаас гаргагч холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэт цаасыг Хороонд бүртгүүлж, анхдагч зах зээлд санал болгох зөвшөөрөл авна.

5.2.25. Өргөдөл гаргагч нь гаргаж байгаа үнэт цаасыг Хороонд бүртгүүлэх тухай хүсэлт болон Биржид бүртгүүлэх өргөдлийг нэгэн зэрэг хүргүүлж болно.

Бүртгэлийн баримт бичгийг хэвлэх, батламжлах

5.2.26. Үнэт цаасыг бүртгэж, анхдагч зах зээлд санал болгохыг зөвшөөрсөн Хорооны шийдвэр гарснаар Үнэт цаас гаргагч нь бүртгэлийн баримт бичгийн эцсийн төслийн хэвлэхэд зориулсан эх бэлтгэлийг энэ журмын 6.2.3-т заасан баримт бичгийн хамт Биржид ирүүлнэ. Хорооны шийдвэрээр бүртгэлийн баримт бичгийн эцсийн төсөлд орсон нэмэлт, өөрчлөлтийг энэ журамд заасны дагуу Биржид мэдэгдэнэ.

5.2.27. Бирж бүртгэлийн баримт бичгийн эх бэлтгэлийг өмнө ирүүлсэн эцсийн төсөл болон Хорооны шийдвэртэй тулган хянаж бүртгэлийн баримт бичгийг хэвлэх эсэхийг шийдвэрлэнэ.

5.2.28. Бирж бүртгэлийн баримт бичгийг хэвлэх зөвшөөрөл олгосны дагуу хэвлэсэн бүртгэлийн баримт бичгийг Бирж болон Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд, мөн андеррайтерийн гүйцэтгэх захирал батламжилна.

Бүртгэлийн баримт бичгийг олон нийтэд танилцуулах

5.2.29. Хороо болон Биржээс олон нийтэд танилцуулахыг зөвшөөрсөн бөгөөд хэвлэмэл хэлбэрээр батламжилсан бүртгэлийн баримт бичгийг энэ журмын 6 дугаар бүлэгт заасан хэлбэрээр олон нийтэд танилцуулна.

5.2.30. Хороо болон Биржид бүртгэл хийгдээгүй үнэт цаасны бүртгэлийн баримт бичгийг олон нийтэд танилцуулахыг хориглоно.

Анхдагч зах зээлд хуваарилалт хийхээс өмнө

5.2.31. Андеррайтер нь Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний дагуу захиалга авах, хаах, захиалга дүгнэх, үнэ тогтоох, хуваарилалт хийх, арилжаалах зөвшөөрөл авах, холбогдох гэрээг байгуулахдаа хууль тогтоомж болон Биржийн баталсан тусгайлсан журмын дагуу хэрэгжүүлнэ.

Бирж Үнэт цаас гаргагчийн бүртгэлийг батлах

5.2.32. Бирж хууль тогтоомж, бусад дүрэм журамд заасны дагуу Үнэт цаас гаргагчийн гаргасан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдсан гэж үзвэл Үнэт цаас гаргагчийн бүртгэлийг батална.

Үнэт цаасыг анхдагч зах зээлд хуваарилах

5.2.33. Үнэт цаасыг санал болгох хугацаа дуусгавар болсны дараа Бирж энэхүү үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, бусад дүрэм журамд заасны дагуу явагдсан эсэхэд хяналт тавьж, холбогдох дүгнэлтийг гаргаж, андеррайтер болон үнэт цаас гаргагчид хүргүүлнэ.

Бүртгэлийн гэрээ байгуулах

5.2.34. Бирж Бүртгэлийн гэрээг Хорооны гаргасан үнэт цаас арилжаалах зөвшөөрөл болон энэ журмын 5.2.33-д заасны дагуу анхдагч зах зээлийн арилжаа явагдсаны дараа Үнэт цаас гаргагчтай байгуулна. Үнэт цаас гаргагч Бүртгэлийн гэрээ байгуулахыг зөвшөөрсөн эрх бүхий этгээдийн шийдвэрийн хуулбарыг хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэхээс өмнө Биржид ирүүлнэ.

5.2.35. Үнэт цаас гаргагчийн бүртгэлийн гэрээний маягтыг Биржийн Гүйцэтгэх удирдлага батална.

5.2.36. Бүртгэлийн гэрээгээр хүлээсэн үүргээ чанд биелүүлэх нь үнэт цаасны зах зээлийг шударга, зохион байгуулалттай, үр ашигтай явуулахад чухал ач холбогдолтой бөгөөд хөрөнгийн зах зээлд оролцогчдыг шаардлагатай мэдээллээр нэгэн зэрэг хангах боломжийг бүрдүүлнэ. Үнэт цаас гаргагч нь дотоод мэдээлэл эзэмшигч этгээдийг дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцохгүй байх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.

5.2.37. Бирж Үнэт цаас гаргагчийг үүрэг хүлээлгэх нөхцөлтэйгөөр бүртгэлийн гэрээний нөхцөлөөс хөнгөлж, чөлөөлж болно.

5.2.38. Үнэт цаас гаргагч бүртгэлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, бүртгэлийн гэрээний нөхцөлүүд, эсвэл энэ журамд заасан нэмэлт мэдээлэл ирүүлэх шаардлагыг хангаагүй тохиолдолд арилжааг түр зогсоох, үнэт цаасны бүртгэлийг цуцлах хүртэлх арга хэмжээ авна.

5.2.39. Бирж бүртгэлийн гэрээний нөхцөл болон холбогдох асуудлуудад шаардлагатай үед өөрчлөлт оруулж болно. Уг өөрчлөлтийг оруулахдаа Үнэт цаас гаргагчтай харилцан тохиролцох ба тухайн өөрчлөлт орсон маягтын дагуу бүртгэлийн гэрээг шинээр байгуулахыг шаардаж болно.

Нийцүүлэгчтэй гэрээ байгуулах

5.2.40. Үнэт цаас гаргагч бүртгэл хийгдсэнээс хойш 1 (нэг) жилийн хугацаанд Биржийн дүрэм, журамд өөрийн үйл ажиллагааг нийцүүлэх зорилгоор санхүүгийн болон хуулийн нийцүүлэгчтэй гурвалсан гэрээ байгуулж хамтран ажиллах үүрэг хүлээх бөгөөд гэрээ байгуулсантай холбогдон гарах зардлыг Үнэт цаас гаргагч хариуцна.

5.2.41. Үнэт цаас гаргагч нь Биржийн Үндсэн талбарын 1 дүгээр ангилалд бүртгэгдэх тохиолдолд Нийцүүлэгчтэй гэрээ байгуулан ажиллахыг Бирж шаардахгүй.

5.2.42. Үнэт цаас гаргагч нь тус бүр нэг хуулийн болон санхүүгийн нийцүүлэгчтэй хамтран ажиллах шаардлагатай бөгөөд Үнэт цаас гаргагчтай зөвшилцсөний үндсэн дээр Бирж нийцүүлэгчдийг томилно. Үнэт цаас гаргагч өөрөө хүсэлт гаргасан тохиолдолд нэг ижил чиглэлээр нэгээс дээш нийцүүлэгчтэй гэрээ байгуулан ажиллаж болно. Энэ тохиолдолд аль нэг нийцүүлэгчийг үндсэн нийцүүлэгч байхаар сонгоно.

5.2.43. Нийцүүлэгчтэй байгуулах гурвалсан гэрээ нь Үнэт цаас гаргагч, нийцүүлэгч болон Биржийн хооронд хийгдэх бөгөөд нийцүүлэгч нь энэ журмын 5.2.44-т заасан үүргээ хэрэгжүүлэх баталгааг шинээр өргөдөл гаргагчийн бүртгүүлэх өргөдлийн хамт Хавсралт 12-т заасны дагуу гаргаж Биржид ирүүлнэ.

5.2.44. Нийцүүлэгч дор дурдсан үүргийг Биржийн өмнө хүлээнэ. Үүнд:

5.2.44.1. Энэ журам болон түүнтэй нийцүүлэн гаргасан баримт бичгүүдийг дагаж мөрдөх

5.2.44.2. Биржээс ирүүлсэн асуултад хурдан шуурхай, үнэн зөв, нээлттэй хариу өгөх, шаардсан баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд (эх хувиар нь, эсхүл хуулбараар) цаг алдалгүй гаргаж өгөх, холбогдох хурал, зөвлөгөөнд оролцох зэргээр Биржээс хэрэгжүүлж байгаа хянан шалгах ажиллагаанд цаг тухайд нь туслалцаа үзүүлэх

5.2.44.3. Бүртгэлтэй Үнэт цаас гаргагчид өгсөн зөвлөмж, зааварчилгаа болон Биржид ирүүлсэн мэдэгдэл, баримт бичиг, мэдээллийн үнэн зөвийг бүрэн хариуцах.

5.2.45. Энэ журмын 5.2.40-т заасан гэрээний хугацаанд Үнэт цаас гаргагч дараах тохиолдолд заавал нийцүүлэгчид хандаж зөвлөгөө, зааварчилгаа авсан байна. Үүнд:

5.2.45.1. Олон нийтэд зар мэдээ, зарлал гаргах, хувьцаа эзэмшигчдэд зар хүргүүлэх, санхүүгийн тайланг нийтлэх бол

5.2.45.2. Хийхээр төлөвлөсөн хэлцэл нь мэдэгдвэл зохих, эсхүл харилцан хамааралтай хэлцэл байж болзошгүй бол (үүнд хувьцаа гаргах, хувьцаагаа эргүүлэн худалдаж авах хэлцэл хамаарна)

5.2.45.3. Үнэт цаасаа нийтэд санал болгож татан төвлөрүүлсэн хөрөнгийг бүртгэлийн баримт бичигт зааснаас өөр зориулалтаар зарцуулах санал гаргасан, эсхүл бүртгэлтэй Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа, түүний явц, үр дүн нь урьдчилан гаргасан таамаглал, тооцоо болон бүртгэлийн баримт бичигт заасан бусад мэдээллээс гажсан бол

5.2.45.4. Биржийн шаардсан лавлагаанд хариу өгөх тохиолдолд.

5.2.46. Нийцүүлэгч Үнэт цаас гаргагчийн өмнө дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

5.2.46.1. Бүртгэлийн журам, холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн ажиллахыг бүртгэлтэй Үнэт цаас гаргагчид зөвлөх, зааварлах

5.2.46.2. Бирж шаардсан тохиолдолд Биржтэй хийх хуралд Үнэт цаас гаргагчийн хамт оролцох

5.2.46.3. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны хэрэгжилт бизнесийн зорилгод нийцсэн эсэх, санхүүгийн нөхцөл болон бүртгэлийн баримт бичигт заасан үнэт цаас гаргах хэлбэр, түүний хэрэгжилттэй холбоотой асуудлаар зөвлөх, зааварлах

5.2.46.4. Энэ журамд заасан шаардлагаас чөлөөлөгдсөн нөхцөлийг хангахад нь зааварчилгаа өгөх

5.2.46.5. Бүртгэлтэй Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа бүртгэлийн баримт бичигт тусгасан ашгийн таамаглал, тооцоонд нийцэж байгаа эсэх, эсхүл нийцэх эсэхийг зөвлөлдөх

5.2.46.6. Бирж болон олон нийтэд мэдэгдэл, зар хүргэх үүргээ хэрэгжүүлэхэд нь Үнэт цаас гаргагчид туслалцаа үзүүлэх

5.2.46.7. Бүртгэлтэй байх хугацаанд Үнэт цаас гаргагч болон түүний ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагааг энэ журамд нийцүүлэх, хэрвээ нийцэхгүй байгаа тохиолдолд Үнэт цаас гаргагчийн ТУЗ-д энэ талаар танилцуулж цаашид авах шаардлагатай арга хэмжээний талаар зөвлөмж өгөх, шаардлагатай тохиолдолд Биржид мэдээлэх

5.2.46.8. Энэ журмын 5.2.45.4-т заасан асуудлаар Бирж нийцүүлэгчид хандсан тохиолдолд тухайн асуудлыг шийдвэрлэх, Биржийг холбогдох мэдээллээр хангах

5.2.46.9. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-д шинээр томилогдож буй гишүүдийн мэргэжил, ур чадвар холбогдох шаардлага хангаж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах, шаардлага хангахгүй байгаа тохиолдолд энэ талаар ТУЗ-д танилцуулж, тэдгээрийг сургалтад хамруулах зэргээр цаашид авах шаардлагатай арга хэмжээний талаар зөвлөмж, зааварчилгаа өгөх.

5.2.47. Нийцүүлэгч өөрийн гаргасан мэдэгдэл, түүнчлэн Үнэт цаас гаргагчид өгсөн зөвлөмж, зааварчилгаа, Биржид ирүүлсэн мэдээлэл, баримт бичгийн үнэн зөв байдлыг хариуцах ба үүргээ цаг тухайд нь чанартай гүйцэтгэнэ.

5.2.48. Үнэт цаас гаргагчийн нийцүүлэгчтэй байгуулсан гэрээ цуцлагдсанаар түүний үүрэг дуусгавар болно. Нийцүүлэгчтэй байгуулсан гэрээг зөвхөн дараах тохиолдолд Үнэт цаас гаргагчийн санаачлагаар цуцална. Үүнд.

5.2.48.1. Нийцүүлэгчийн зөвлөмж, зааварчилгаа зохих шаардлагад нийцээгүй болохыг Бирж хүлээн зөвшөөрөх

5.2.48.2. Нийцүүлэгч гэрээний үүргээ ноцтой зөрчсөн.

5.2.49. Нийцүүлэгчтэй байгуулсан гэрээ цуцлагдсанаас хойш 1 (нэг) сарын дотор бүртгэлтэй Үнэт цаас гаргагч өөр этгээдийг нийцүүлэгчээр сонгож гэрээ

байгуулна.

5.2.50. Нийцүүлэгчийн үүрэг дуусгавар болсон тохиолдолд бүртгэлтэй Үнэт цаас гаргагч ажлын 3 (гурав) хоногийн дотор энэ тухай нийтэд мэдэгдэж шинэ нийцүүлэгчийг сонгох ажлыг эхлүүлнэ. Үнэт цаас гаргагч шинэ нийцүүлэгчтэй гэрээ байгуулсан даруйд энэ тухайгаа Бирж болон олон нийтэд мэдэгдэнэ.

5.2.51. Нийцүүлэгч нь дор дурдсан нөхцөл байдал бий болсон бол энэ тухай үйлчилгээ үзүүлдэг Үнэт цаас гаргагчид ажлын 3 (гурав) хоногийн дотор мэдэгдэх үүрэгтэй:

5.2.51.1. Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүчингүй болсон, түдгэлзсэн бол

5.2.51.2. Холбогдох байгууллагад бүртгүүлсэн бүртгэл хүчингүй болсон, түдгэлзсэн бол

5.2.51.3. Холбогдох мэргэжилтэн, албан тушаалтны мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, гэрчилгээ хүчингүй болсон, түдгэлзсэн бол

5.2.51.4. Бусад нөхцөл байдлын улмаас үйл ажиллагаагаа эрхлэх боломжгүй болсон бол.

5.2.52. Бирж энэ журмын 5.2.40-д заасан хугацаа дууссанаас хойш шаардлагатай тохиолдолд дахин нийцүүлэгчтэй гэрээ байгуулан ажиллахыг Үнэт цаас гаргагчаас шаардаж болно. Энэ тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Биржийн шаардсан нөхцөл, хугацааны дагуу тогтоосон үүргийн хүрээнд нийцүүлэгчтэй гэрээ байгуулж ажиллана. Нийцүүлэгчээс зөвлөмж, зааварчилгаа авах шаардлагатай нөхцөл байдал болон нийцүүлэгчийн гүйцэтгэх үүргийг Бирж тодорхойлно.

5.2.53. Энэ журмын 5.2.52-т заасан шаардлагатай тохиолдолд дараах тохиолдлуудыг авч үзнэ. Үүнд:

5.2.53.1. Үнэт цаас гаргагчийн комплайнсын тогтолцооны эрсдэлээс шалтгаалан байгууллагад хор хохирол учирсан

5.2.53.2. Үнэт цаас гаргагч өөрийн хариуцлагагүй байдлаас үүдэн тогтмол биелүүлэх үүргээ хангалтгүй биелүүлсэн

5.2.53.3. Үнэт цаасны танилцуулгад оруулсан үнэлгээ, засаглал, санхүүгийн төсөөлөлтэй холбоотой мэдээлэлд их хэмжээний өөрчлөлт орсон.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох

5.2.54. Бүртгэлтэй Үнэт цаас гаргагч нь түүнийг төлөөлж Биржтэй харилцах чиг үүрэг бүхий байнгын хоёр итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилж ажиллуулна. Бирж өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд итгэмжлэгдсэн төлөөлөгчид нь Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга байна.

5.2.55. Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь дор дурдсан үүрэг хүлээнэ. Үүнд:

5.2.55.1. Үнэт цаас гаргагчийн Биржид бүртгэлтэй байх хугацаанд Бирж болон Үнэт цаас гаргагч хоорондын харилцааг хангах

5.2.55.2. Өөрийн гэрийн болон ажлын хаяг, гар болон бусад утасны дугаар, цахим шуудангийн хаяг, холбоо барих бусад хаяг (бүртгэлтэй ажлын байран дээрээ байрлахгүй байгаа тохиолдолд), факсын дугаар, Биржээс шаардлагатай гэж үзсэн бусад холбоо барих хаягийн мэдээллээ өөрчлөх бүрт Биржид бичгээр мэдэгдэх

5.2.55.3. Итгэмжлэгдсэн төлөөлөгч гадаад улс руу зорчих зэргээр Биржтэй харилцах боломжгүй болох тохиолдолд өөрийн үүргийг түр орлон хэрэгжүүлэх этгээдийг томилж Биржид мэдэгдэх, түр орлох этгээдийн гэрийн болон ажлын хаяг, утасны дугаар, факсын дугаар зэрэг холбоо барих хаягийн мэдээллийг Биржид бичгээр мэдэгдэх

5.2.55.4. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлөгдөх тохиолдолд чөлөөлөгдөх болсон үндэслэл, шалтгааныг тодорхой заасан мэдэгдлийг Биржид хүргүүлэх

5.2.55.5. Үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх талаар Биржид мэдэгдэх хүртэл итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үүрэгт ажлаа үргэлжлүүлэн гүйцэтгэх.

5.2.56. Бүртгэлтэй Үнэт цаас гаргагч нь итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй холбоотойгоор дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

5.2.56.1. Онцгой нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд шинээр итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох хүртэл тухайн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг үүрэгт ажлаас нь чөлөөлөхгүй байх. Энэ зүйлд заасны дагуу шинээр итгэмжлэгдсэн төлөөлөгч томилогдохоос өмнө итгэмжлэгдсэн төлөөлөгчийг үүрэгт ажлаас нь чөлөөлсөн бол ийнхүү чөлөөлөх болсон үндэслэл, шалтгааныг тодорхой заасан мэдэгдлийг ажлын 3 (гурав) хоногийн дотор Биржид хүргүүлэх

5.2.56.2. Шинээр томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн талаар Биржид ажлын 3 (гурав) хоногийн дотор мэдэгдэх.

5.2.57. Итгэмжлэгдсэн төлөөлөгч үүргээ хангалтгүй биелүүлсэн гэж Бирж үзвэл итгэмжлэгдсэн төлөөлөгчөө нэн даруй солихыг бүртгэлтэй Үнэт цаас гаргагчаас шаардах эрхтэй.

5.3. Бүртгэлтэй Үнэт цаас гаргагч үнэт цаас бүртгүүлэх

5.3.1. Бүртгэлтэй Үнэт цаас гаргагч нь үнэт цаас бүртгүүлэх өргөдлөө энэ журмын Хавсралт 1-т заасны дагуу гаргаж, үнэт цаас гаргах хураамж төлсөн баримтын хамт Биржид ирүүлнэ. Өргөдөлд Үнэт цаас гаргагчийн эрх бүхий этгээд, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурсан байна.

5.3.2. Бүртгэлтэй Үнэт цаас гаргагч нь Биржид бүртгэгдээгүй үнэт цаас шинээр гаргах тохиолдолд энэ журмын 5 дугаар бүлэгт заасны дагуу бүртгүүлнэ. Бүртгэлийн баримт бичигт шаардсан зарим мэдээллийг ирүүлэх үүргээс чөлөөлүүлэх хүсэлт Биржид гаргаж болно. Энэ тохиолдолд Бирж дараах асуудлуудыг заавал нягталсны үндсэн дээр шийдвэр гаргана. Үүнд:

5.3.2.1. Үнэт цаас гаргагчийн бизнес, мэдээллийн ил тод байдал нь Монгол улсад мөрдөгдөж буй холбогдох стандартуудыг хангасан эсэх

5.3.2.2. Үнэт цаас нь бүртгэгдсэн гадаад улсын хууль тогтоомж, хяналт зохицуулалтын агуулга, хүрээ.

5.4. Өргөдөл гаргах явцад өөрчлөгдсөн мэдээлэл хүргүүлэх

5.4.1. Биржид хүргүүлсэн баримт бичигт өөрчлөлт оруулсан бол өөрчлөлт орсон хувилбарыг өмнө ирүүлсэнтэй адил тоогоор Биржид ирүүлнэ. Ийнхүү ирүүлэхдээ оруулсан өөрчлөлтийн талаар товъёог бэлтгэж ирүүлнэ.

5.4.2. Бүртгэлийн баримт бичгийн эцсийн төслийг Бирж баталсны дараа түүнд өөрчлөлт оруулах зайлшгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд Үнэт цаас гаргагч энэ тухай Биржид нэн даруй мэдэгдэж өөрчлөлт орсон хувилбарыг өмнө ирүүлсэнтэй адил хувиар ирүүлнэ.

5.4.3. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны арилжаа эхлэхээс өмнө дараах нөхцөл байдал үүссэнийг мэдсэн даруй Биржид мэдэгдэнэ. Үүнд:

5.4.3.1. Бүртгэлийн баримт бичигт тусгасан мэдээлэлд өөрчлөлт орох

5.4.3.2. Бүртгэлийн баримт бичгийг гаргасны дараа түүнд зайлшгүй тусгавал зохих чухал мэдээлэл бий болох

5.4.3.3. Дээрх заалт дахь чухал мэдээлэл гэдгийг энэ журмын 7.3.9-д заасан асуудлаар үндэслэл бүхий дүгнэлтэд хүргэх мэдээллийг ойлгох. Бирж дээрх нөхцөл байдалд тохирох арга хэмжээ болон тухайн шинээр үүссэн асуудал, өөрчлөлтийг олон нийтэд мэдээлэх шаардлагатай эсэхэд хяналт тавих.

5.4.4. Андеррайтерийн үйлчилгээ үзүүлж байх хугацаанд энэ журмын Хавсралт 4-т заасан андеррайтерийн хараат бус байдлын мэдүүлэгт заасан нөхцөл байдал өөрчлөгдсөн бол шинээр өргөдөл гаргагч болон андеррайтер энэ тухай Биржид ажлын 3 (гурав) хоногийн дотор мэдэгдэнэ.

5.4.5. Шинээр өргөдөл гаргагчийн бүртгүүлэх өргөдлийг гаргах явцад буюу энэ талаар Биржийн шийдвэр гарахаас өмнө андеррайтерийн үйлчилгээний гэрээ цуцлагдсан бол шинээр өргөдөл гаргагч болон андеррайтер энэ талаар Биржид ажлын 3 (гурав) хоногийн дотор мэдэгдэх ба мэдэгдэлд гэрээ цуцлах болсон шалтгааныг тусгана. Гэрээ цуцлагдсан талаар Биржид мэдэгдсэнээр андеррайтерийн үүрэг дуусгавар болсон гэж үзнэ.

5.4.6. Биржид бүртгүүлэх өргөдөл гаргасан эсэхээс үл хамааран андеррайтерийн үйлчилгээний гэрээ цуцлагдсан бол андеррайтер гэрээ цуцлах болсон үндэслэл шалтгааныг тайлбарласан мэдэгдлийг Биржид ажлын 5 (тав) хоногийн дотор бичгээр ирүүлнэ.

ЗУРГАА. БҮРТГЭЛИЙН БАРИМТ БИЧИГ

6.1. Ерөнхий зүйл

6.1.1. Өргөдөл гаргагч нь үнэт цаасыг бүртгүүлэх бүртгэлийн баримт бичгийг энэ бүлэгт заасан шаардлагын дагуу бэлтгэнэ. Бүртгэлийн баримт бичиг нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хорооны холбогдох журам болон энэ журамд нийцсэн байна.

6.1.2. Шинээр өргөдөл гаргагч нь бүртгэлийн баримт бичгээ хамгийн сүүлийн санхүүгийн тайлант хугацаа дууссанаас хойш 6 (зургаа) сарын дотор гаргасан байна.

6.1.3. Өргөдөл гаргагч нь бүртгүүлэх өргөдөл гаргахдаа бүртгэлийн баримт бичигт шаардлагатай бүх мэдээлэл, баримт бичиг орсон талаар баталгаа гаргана.

6.1.4. Хууль тогтоомж, дүрэм журамд заасан тохиолдолд өргөдөл гаргагчийн Биржид ирүүлсэн баримт бичгийг Бирж Хороонд хүргүүлж болно.

6.1.5. Шаардлагатай тохиолдолд өргөдөл гаргагч бүртгэлийн баримт бичигтэй холбоотой нэмэлт баримтыг Биржийн шаардсан тоо, хэлбэр загварын дагуу Биржид ирүүлнэ.

6.1.6. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд эсхүл Баталгаат үнэт цаас гаргах тохиолдолд баталгаат Үнэт цаас гаргагч болон баталгаа гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд нь бүртгэлийн баримт бичигт тусгасан мэдээллийн үнэн зөвийг хариуцна. Тухайн этгээдүүд санаатайгаар хуурамч баримт бичиг үйлдсэн, худал баталгаа гаргасан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол энэ журамд заасан холбогдох хариуцлагыг хүлээлгэнэ.

6.1.7. Бүртгэлийн баримт бичгийн эцсийн төсөлд Биржийн зөвшөөрөлгүйгээр агуулгын өөрчлөлт оруулахыг хориглоно.

6.2. Бүртгэлийн баримт бичигт тавигдах шаардлага

6.2.1. Биржид бүртгүүлэх өргөдөл анх гаргахдаа Үнэт цаас гаргагч дараах баримт бичгийг бүртгэлийн өргөдөлд хавсаргана. Үүнд:

6.2.1.1. Бүртгэлийн баримт бичгийн анхны төсөл хэвлэмэл хэлбэрээр 1 (нэг) хувь, цахим хэлбэрээр 1 (нэг) хувь

6.2.1.2. Энэ журмын Хавсралт 5-ийн дагуу гаргасан андеррайтерийн хараат бус байдлын мэдүүлэг

6.2.1.3. Бүртгэлийн баримт бичгийн анхны төсөлд тусгасан мэдээлэл үнэн зөв, бүрэн гүйцэд бөгөөд төөрөгдүүлсэн шинжтэй мэдээлэл агуулаагүй болохыг баталсан шинээр өргөдөл гаргагчийн эрх бүхий албан тушаалтан бүрээс бичгээр гаргасан баталгаа

6.2.1.4. Эрх бүхий албан тушаалтны дараах асуудлаар бичгээр гаргасан амлалт, баталгаа:

a. Энэ заалтын (1)-т заасан бүртгэлийн баримт бичгийн анхны төсөлд тусгасан эрх бүхий албан тушаалтны намтар, хувийн мэдээлэл үнэн зөв, бүрэн гүйцэд болох тухай баталгаа, түүнчлэн арилжаа эхлэхээс өмнө уг мэдээлэлд өөрчлөлт орвол энэ тухай Биржид нэн даруй мэдэгдэхийг амласан амлалт

b. Эрх бүхий албан тушаалтнаас энэ журмын 6.2.2.4-д заасан амлалт, баталгааг зохих хугацаанд Биржид гаргаж өгөхийг амласан амлалт. Бүртгүүлэх өргөдлийг Биржид ирүүлсний дараа томилогдсон эрх бүхий албан тушаалтан энэхүү заалтад заасан амлалт, баталгааг томилогдсон даруйдаа Биржид хүргүүлэх үүрэгтэй.

6.2.1.5. Бүртгэлийн баримт бичгийн анхны төсөлд тусгасан ашгийн таамаглалын хамарсан хугацаатай адил хугацааг хамарсан ТУЗ-ийн ашгийн таамаглал, түүнчлэн бүртгэлийн баримт бичгийг нийтэд танилцуулахаар төлөвлөсөн өдрөөс хойших 12 (арван хоёр) сараас багагүй хугацааг хамарсан мөнгөн гүйлгээний таамаглал болон эдгээр таамаглалыг гаргахад баримталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, тооцооллын аргачлал

6.2.1.6. Шинээр өргөдөл гаргагчийн улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнтэй адилтгах баримт бичгийн нотариат, түүнтэй адилтгах этгээдээс баталгаажуулсан хуулбар

6.2.1.7. Бүртгэлийн баримт бичигт ажлын капиталын хүртээмжийн талаар мэдэгдэл тусгагдсан бол уг мэдэгдэл нь зохих баримтад тулгуурлаж гаргасан үндэслэлтэй мэдэгдэл болохыг нотолсон андеррайтерийн албан бичиг

6.2.1.8. Шинээр өргөдөл гаргагчийн үүсгэн байгуулах баримт нь үүсгэн байгуулагдсан улсынхаа холбогдох хууль тогтоомж, Бүртгэлийн журам болон Биржээс тавьсан шаардлагад нийцэж байгаа тухай хуулийн дүгнэлт

6.2.1.9. Бүртгэлийн баримт бичигтэй холбоотойгоор шинээр өргөдөл гаргагч, түүний хувьцаа эзэмшигч болон бусад холбогдох талуудаас Биржид бичгээр өгөх баталгаа, амлалт

6.2.1.10. Шинээр өргөдөл гаргагчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээдийн мэдээлэл

6.2.1.11. Үнэт цаас гаргахыг зөвшөөрсөн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, тэмдэглэл эсхүл эрх бүхий этгээдийн шийдвэр

6.2.1.12. Үнэт цаас гаргахыг зөвшөөрсөн тухай шинээр өргөдөл гаргагчийн ТУЗ, түүнтэй адилтгах эрх бүхий байгууллага, эсхүл тэдгээрээс эрх олгосон

этгээд (энэ тохиолдолд итгэмжлэл, эсхүл эрх шилжүүлсэн тухай шийдвэрийг хавсаргана)- ийн шийдвэр

6.2.1.13. Энэ журмын Хавсралт 6-ийн дагуу гаргасан андеррайтерийн мэдэгдэл

6.2.1.14. Энэ журмын Хавсралт 7, 8-ийн дагуу гаргасан андеррайтерийн баталгаа, мэдүүлэг

6.2.1.15. Биржид бүртгэгдэхтэй холбогдуулан маркетингийн хөтөлбөр явуулах ажлын төлөвлөгөө

6.2.1.16. Бүртгүүлэх өргөдөлтэй холбоотой холбогдох хууль тогтоомж болон Биржээс шаардсан бусад баримт бичиг.

6.2.2. Биржээс Үнэт цаас гаргагчийн өргөдлийг хэлэлцэхээр товлосон өдрөөс ажлын 5 (тав) хоногийн өмнө дараах баримт бичгийг Биржид ирүүлнэ. Үүнд:

6.2.2.1. Бүртгэлийн баримт бичгийн эцсийн төсөл хэвлэмэл хэлбэрээр 2 (хоёр) хувь, цахим хэлбэрээр 1 (нэг) хувь

6.2.2.2. Бүртгэлийн баримт бичигт ажлын капиталын хүртээмжийн талаар мэдэгдэл тусгагдсан бол уг мэдэгдэл нь зохих баримтад тулгуурлаж гаргасан үндэслэлтэй мэдэгдэл болохыг тухайн өдрийн байдлаар нотолсон андеррайтерийн албан бичиг

6.2.2.3. Шинээр өргөдөл гаргагчийн эрх бүхий албан тушаалтнаас гаргасан Үнэт цаасны хууль тогтоомж, Бүртгэлийн журмыг дагаж мөрдөхийг баталсан амлалт, баталгааг энэ журмын Хавсралт 15-ийн дагуу гаргаж жилийн хураамжийн хамт

6.2.2.4. Шинээр өргөдөл гаргагчийн эрх бүхий албан тушаалтан бүрээс энэ журмын Хавсралт 15, 16-ийн дагуу бичгээр гаргасан мэдэгдэл, амлалт

6.2.2.5. Бүртгэлийн баримт бичгийг нийтэд танилцуулах, бүртгэлийн гэрээнд гарын үсэг зурахыг тус тус зөвшөөрсөн тухай шинээр өргөдөл гаргагчийн ТУЗ, түүнтэй адилтгах эрх бүхий байгууллага, эсхүл тэдгээрээс эрх олгосон этгээд (энэ тохиолдолд итгэмжлэл, эсхүл эрх шилжүүлсэн тухай шийдвэрийг хавсаргана)- ийн шийдвэр

6.2.2.6. Биржээс шаардсан бусад мэдээлэл.

6.2.3. Бүртгэлийн баримт бичгийг хэвлэхээс өмнө дараах баримт бичгийг Биржид ирүүлнэ. Үүнд:

6.2.3.1. Бирж болон Хорооноос баталсан бүртгэлийн баримт бичгийн хэвлэхэд бэлэн эх бэлтгэл

6.2.3.2. Хорооноос бүртгэлийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол тухайн нэмэлт, өөрчлөлтийн товьёог

6.2.3.3. Энэ журмын 6 дугаар бүлэгт заасан зарлалын эцсийн төсөл.

6.2.4. Анхдагч зах зээлд арилжихын өмнө дараах баримт бичгийг Биржид ирүүлнэ. Үүнд:

6.2.4.1. Үнэт цаас гаргагчийг анхдагч зах зээлд арилжихыг зөвшөөрсөн Хорооны шийдвэрийн баталгаажсан хуулбар

6.2.4.2. Үнэт цаас хуваарилах тухай шинээр өргөдөл гаргагчийн ТУЗ, түүнтэй адилтгах эрх бүхий байгууллага, эсхүл тэдгээрээс эрх олгосон этгээд (энэ тохиолдолд итгэмжлэл, эсхүл эрх шилжүүлсэн тухай шийдвэрийг хавсаргана)-ийн шийдвэр

6.2.4.3. Энэ журмын Хавсралт 12-т заасны дагуу гаргасан нийцүүлэгчийн мэдэгдэл, баталгаа.

6.3. Бүртгэлийн баримт бичгийн агуулга

6.3.1. Шинээр өргөдөл гаргагч нь бүртгэлийн баримт бичгийг энэ журмын Хавсралт 19 хэсэгт заасны дагуу бэлтгэнэ.

6.3.2. Бүртгэлтэй Үнэт цаас гаргагч нь нэмэлт үнэт цаас гаргаж байгаа тохиолдолд бүртгэлийн баримт бичгийг энэ журмын Хавсралт 21-д заасны дагуу бэлтгэнэ.

6.3.3. Хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжид худалдахаар нэмэлт үнэт цаас гаргаж байгаа тохиолдолд энэ журмын Хавсралт 21-ийн 7, 19, 21, 23, 24, 26 –т заасан мэдээллүүдийг бүртгэлийн баримт бичигт оруулахгүй.

6.3.4. Бүртгэлийн баримт бичигт энэ журамд заасан мэдээлэл, баримт бичгээс гадна Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, хөрөнгө, өр төлбөр, санхүүгийн байдал, удирдлага, ирээдүйн төлөвлөгөө, түүний ашиг алдагдал, тухайн үнэт цаасанд дагалдах эрх зэрэг хөрөнгө оруулагчид дүгнэлт хийж шийдвэр гаргахад шаардлагатай бусад бүх мэдээлэл, баримт бичгийг тусгана.

6.3.5. Шинээр өргөдөл гаргагчийн хяналтын багц эзэмшигч нь шинээр өргөдөл гаргагчийн бизнесийн үйл ажиллагаатай шууд болон шууд бусаар өрсөлддөг, эсхүл өрсөлдөхүйц бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг компанийн ТУЗ-ийн гишүүн (ТУЗ-ийн хараат бус гишүүн хамаарахгүй), захирал, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, эсхүл ийм үйл ажиллагаа эрхэлдэг нөхөрлөлийн гишүүн (өрсөлдөх бизнес) бол шинээр өргөдөл гаргагчийн бүртгэлийн баримт бичигт дараах мэдээллийг заавал тусгана. Үүнд:

6.3.5.1. Шинээр өргөдөл гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа нь өрсөлдөх бизнесээс ангид гэж үзэж байгаа шалтгаан

6.3.5.2. Өрсөлдөх бизнес, түүний удирдлагын тухай танилцуулга зэрэг хөрөнгө оруулагчдыг тухайн бизнесийн онцлог, цар хүрээ, хэмжээг үнэлэх боломжоор хангахад шаардлагатай бусад мэдээлэл, түүнчлэн тухайн бизнес нь өргөдөл гаргагчийн бизнестэй хэрхэн өрсөлдөж болох талаар

тайлбар

6.3.5.3. Өргөдөл гаргагч нь өрсөлдөх бизнесээс үл хамааран бие дааж бизнесээ явуулах боломжтой гэдгийг нотолсон тайлбар

6.3.5.4. Хяналтын багц эзэмшигч нь өрсөлдөх бизнесийг ирээдүйд Үнэт цаас гаргагчийн бизнестэй нэгтгэх зорилт тавьж байгаа эсэх, нэгтгэхээр төлөвлөж байгаа бол уг ажиллагааг хийхээр төлөвлөсөн хугацаа. Бүртгэл хийгдсэний дараа энд заасан мэдээлэл өөрчлөгдсөн бол өргөдөл гаргагч нь энэ тухай мэдсэнээс хойш 7 (долоо) хоногийн дотор энэ журмын 8.4.1-т заасныг баримтлан нийтэд мэдээлэх үүрэгтэй

6.3.5.5. Бирж шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

6.3.6. Өргөдөл гаргагч нь үнэт цаасны бүртгэл хийгдсэний дараа өрсөлдөх бизнесийг бүхэлд нь болон хэсэгчлэн худалдан авахаар төлөвлөсөн бол уг ажлын үр дүнд бий болох өргөдөл гаргагчийн нэгдэл нь энэ журмын 4.3.1-т заасан үйл ажиллагааны хугацаанд тавигдах шаардлагыг хангах үүрэгтэй.

6.3.7. Шинээр өргөдөл гаргагчийн эрх бүхий албан тушаалтан нь шинээр өргөдөл гаргагчийн бизнесийн үйл ажиллагаатай шууд болон шууд бусаар өрсөлддөг, эсхүл өрсөлдөхүйц бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг компанийн ТУЗ-ийн гишүүн (ТУЗ-ийн хараат бус гишүүн хамаарахгүй), захирал, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, эсхүл ийм үйл ажиллагаа эрхэлдэг нөхөрлөлийн гишүүн бол

6.3.7.1. Энэ журмын 6.3.5.2, 6.3.5.3-т заасан мэдээлэл болон Биржээс шаардлагатай гэж үзсэн бусад мэдээллийг энэ зүйлийн зохицуулалтад хамаарах эрх бүхий албан тушаалтан тус бүрээр нь бэлтгэж бүртгэлийн баримт бичигт тусгах

6.3.7.2. Бүртгэл хийгдсэний дараа Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан (үүнд бүртгэл хийгдсэний дараа томилогдсон эрх бүхий албан тушаалтан хамаарна) нь энэ журмын 6.3.7.1-д заасан мэдээллийг өргөдөл гаргагчийн жил бүрийн тайланд тусгах

6.3.7.3. Өргөдөл гаргагчийн бүртгэлийн баримт бичиг, жилийн тайланд тусгасан мэдээлэлд өөрчлөлт орсон бол холбогдох эрх бүхий албан тушаалтан нь уг өөрчлөлтийн талаар дараагийн жилийн тайланд тусгах.

6.3.8. Бирж энэ журмын 6.3.5, 6.3.6, 6.3.7-д заасан нөхцөл байдал үүссэн үед хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлыг хангах зорилгоор ТУЗ-д хараат бус гишүүн нэмж томилохыг Үнэт цаас гаргагчаас шаардаж болно.

6.3.9. Шинээр өргөдөл гаргагч нь бүртгэлийн баримт бичигт ажлын капиталын талаар мэдэгдэл тусгана. Шинээр өргөдөл гаргагч болон түүний охин компанийн ажлын капитал нь бүртгэлийн баримт бичгийг танилцуулснаас хойш 12 (арван хоёр) сарын хугацаанд үйл ажиллагаагаа явуулахад хангалттай хүрэлцэхүйц гэдгийг зохих баримтад тулгуурлаж тогтоосны үндсэн дээр уг мэдэгдлийг гаргана. Шинээр өргөдөл гаргагчийн андеррайтер нь дараах баталгааг Биржид бичгээр

ирүүлнэ. Үүнд:

6.3.9.1. Бүртгэлийн баримт бичгийг нийтэд танилцуулснаас хойш 12 (арван хоёр) сарын хугацаанд үйл ажиллагаагаа явуулахад хангалттай хэмжээний ажлын капиталтай талаар баталгааг шинээр өргөдөл гаргагчаас бичгээр гаргуулж авсан тухай баталгаа

6.3.9.2. Шинээр өргөдөл гаргагчаас гаргасан ажлын капиталын хүртээмжийн талаар мэдэгдэл нь зохих баримтад тулгуурлаж гаргасан, үндэслэлтэй мэдэгдэл болох түүнчлэн холбогдох санхүүжилт олгож байгаа этгээд нь энэ талаар бичгээр баталгаа гаргасан болохыг нотолсон тухай баталгаа.

6.3.10. Дор дурдсан тохиолдолд Бирж санхүүгийн үйлчилгээ үзүүлэх үндсэн үйл ажиллагаа эрхэлдэг шинээр өргөдөл гаргагчаас ажлын капиталын мэдэгдэл гаргахыг шаардахгүй. Үүнд:

6.3.10.1. Ажлын капиталын мэдэгдэл гаргасан ч хөрөнгө оруулагчдад ач холбогдолтой мэдээлэл байж чадахгүй гэж Бирж үзсэн бол

6.3.10.2. Шинээр өргөдөл гаргагчийн төлбөрийн чадвар, капиталын чадамжийн байдалд өөр зохицуулалттай этгээд нарийн хяналт тавьдаг бол.

6.3.11. Уул уурхайн компани, гадаадын өргөдөл гаргагч, хөрөнгө оруулалтын компаниудын гаргах бүртгэлийн баримт бичгийн хувьд Бирж нэмэлт шалгуур тогтоож болно.

6.3.12. Бүртгэлийн баримт бичигт оруулахаар энэ журамд заасан мэдээлэл, баримт бичиг нь тухайн Үнэт цаас гаргагчид хамааралгүй байх тохиолдолд энэ тухай мэдэгдлийг бүртгэлийн баримт бичигт тухай бүр тусгана.

6.3.13. Бирж шаардлагатай гэж үзсэн тохиолдолд нэмэлт баримт бичиг, мэдээлэл гаргаж өгөхийг Үнэт цаас гаргагчаас шаардаж болно. Бирж тодорхой тохиолдолд зарим шаардлагыг бууруулах болон түүнээс чөлөөлөх эрхтэй байна.

6.4. Мэдэгдэл

6.4.1. Бүртгэлийн баримт бичгийн нүүрэн хэсэг, эсхүл нүүрэн хэсгийн дотор талд доорх мэдэгдлийг хүмүүст уншигдахуйц байдлаар тусгасан байна. Үүнд:

Улаанбаатар Үнэт Цаас Бирж нь энэхүү баримт бичигт агуулагдсан аливаа мэдээлэл, баримт бичиг, материалын агуулга, тэдгээрийн үнэн зөв, бүрэн гүйцэд эсэх асуудлаар ямар нэг хариуцлага хүлээхгүй бөгөөд энэ баримт бичгийн агуулгын улмаас үүссэн аливаа хохирол, үр дагаврыг Үнэт цаас гаргагч хариуцна.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 4 сарын 13-ны өдрийн 07/22 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

6.5. Хэл

6.5.1. Бүртгэлийн баримт бичгийг Монгол хэл дээр бэлтгэнэ. Шаардлагатай тохиолдолд бүртгэлийн баримт бичгийг өөр хэл дээр бэлтгэж болно.

6.5.2. Гадаад улсад бүртгэлтэй Үнэт цаас гаргагч нь бүртгэлийн баримт бичгийг Англи хэл дээр бэлтгэн ирүүлэхээс гадна Монгол хэл дээрх орчуулгыг хамтатган ирүүлнэ. Монгол болон Англи хэл дээр бэлтгэсэн Бүртгэлийн баримт бичигт утга, агуулгын зөрүү гарвал Англи хэл дээр бэлтгэсэн эх хувийг хүчинтэйд тооцно.

6.6. Зураг, график

6.6.1. Бүртгэлийн баримт бичигт загвар болон утгын хувьд төөрөгдөлд оруулахааргүй зураг, графикаар илэрхийлсэн мэдээлэл оруулахыг зөвшөөрнө.

6.7. Ашгийн урьдчилсан таамаглал

6.7.1. Өргөдөл гаргагч нь ашгийн таамаглалыг бэлтгэж бүртгэлийн баримт бичигт тусгана. Албан ёсны ашгийн таамаглалаас бусад байдлаар Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны төсөөлөлд үндэслэсэн ирээдүйн ашиг, ногдол ашиг зэргийн албан бус тооцооллыг бүртгэлийн баримт бичигт оруулахыг хориглоно.

6.7.2. Ашгийн таамаглалыг бэлтгэхэд дараах шаардлагыг баримтална:

6.7.2.1. Үнэт цаас гаргагчийн ТУЗ ашгийн таамаглалыг баталсан байх

6.7.2.2. Хоёрдмол утгагүй тодорхой илэрхийлэгдсэн байх

6.7.2.3. Үнэт цаас гаргагчийн хэрэглэдэг нягтлан бодох бүртгэлийн бодлогод тулгуурлан бэлтгэсэн байх

6.7.2.4. Өргөдөл гаргагчийн андеррайтер нь ТУЗ-ийн баталсан ашгийн таамаглалыг сайтар нягталсны үндсэн дээр шаардлага хангаж байгаа талаар мэдэгдэл гаргасан байх

6.7.3. Ашгийн таамаглалыг хөрөнгө оруулагчид түүнийг үндэслэлтэй эсэхийг мэдэж болохуйц баримт материалд тулгуурлан гаргана. Таамаглалыг нь нарийвчилсан, тодорхой байдлаар хийнэ.

6.8. Төсөвлөсөн санхүүгийн мэдээлэл

6.8.1. Шинээр өргөдөл гаргагч, бүртгэлтэй Үнэт цаас гаргагч нь бүртгүүлэх өргөдөл гаргах үеэр бизнес болон компани худалдаж авсан, эсхүл худалдаж авахаар төлөвлөсөн бол тухайн хэлцлийн үр дүнд бий болсон (бий болох) компанитай холбоотойгоор төсөвлөсөн санхүүгийн мэдээлэл гаргаж бүртгэлийн баримт бичигт тусгана.

6.8.2. Төсөвлөсөн санхүүгийн мэдээллийн загварыг Бирж батална.

6.8.3. Бирж шаардлагатай гэж үзвэл санхүүгийн зөвлөхийн үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд, эсхүл төсөвлөсөн санхүүгийн мэдээлэл бэлтгэсэн этгээдтэй Үнэт цаас гаргагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч (бүртгэлтэй Үнэт цаас гаргагчийн хувьд), андеррайтер (шинээр өргөдөл гаргагчийн хувьд)-аар дамжуулан харилцаж, нэмэлт тайлбар, тодруулга гаргуулах, анхан шатны баримт бичиг, журналтай танилцах, холбогдох баримт бичиг шаардан гаргуулах эрхтэй.

6.9. Бизнесийн болон хөрөнгийн үнэлгээ

6.9.1. Үнэт цаас гаргагч нь бүртгэлийн баримт бичигт хөрөнгийн үнэлгээг хавсаргах ба шаардлагатай тохиолдолд бизнесийн үнэлгээг хийлгэж болно.

6.9.2. Бизнесийн болон хөрөнгийн үнэлгээг Монгол Улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Олон улсын хөрөнгийн үнэлгээний стандартад нийцүүлэн гүйцэтгэнэ.

6.9.3. Үнэт цаас гаргагч нь хөрөнгийн үнэлгээний тайлан бэлтгэх явцад үл хөдлөх хөрөнгийг үнэлэхдээ хуульд зааснаас гадна Бүртгэлийн баримт бичгийг боловсруулахад мөрдөх удирдамжид заасны дагуу үнэлнэ.

6.9.4. Бизнесийн болон хөрөнгийн үнэлгээг бүртгэлийн баримт бичиг ирүүлэхээс өмнөх 1 (нэг) жилийн дотор хийлгэсэн байна.

6.9.5. Бизнесийн болон хөрөнгийн үнэлгээг хараат бус, мэргэшсэн үнэлгээчнээр гүйцэтгүүлнэ.

6.9.6. Хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээд нь Үнэт цаас гаргагчийн толгой компани, зэргэлдээ компани, охин компани байх, эсхүл үнэлгээ хийх хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан нь Үнэт цаас гаргагч, түүний толгой компани, зэргэлдээ компани, охин компани, бусад холбогдох компанийн ажилтан, эрх бүхий албан тушаалтан, эсхүл тэдгээрийн аль нэгд удирдах албан тушаал эрхлэхээр нэрээ дэвшүүлсэн этгээд тохиолдолд хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэгчийг хараат гэж үзнэ.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

6.9.7. Дор дурдсан шалгуурыг хангасан этгээдийг мэргэшсэн хөрөнгийн үнэлгээчин гэж үзнэ. Үүнд:

6.9.7.1. Монгол Улсад байрладаг хөрөнгийг үнэлэхэд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл эзэмшдэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан журмын дагуу Хороонд бүртгүүлж, үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх эрх авсан, Монгол Улсад үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагааг тогтвортой эрхэлдэг хуулийн этгээд бол

6.9.7.2. Гадаад улсад байрладаг хөрөнгийг үнэлэхэд тухайн хөрөнгө байрладаг улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу тухайн төрлийн хөрөнгийг

үнэлэх тусгай зөвшөөрөл эзэмшдэг, тухайн чиглэлээрээ мэргэжлийн дадлага туршлагатай хөрөнгийн үнэлгээчин бол.

6.9.8. Үнэт цаас гаргагч бүртгэлийн баримт бичиг гаргахаас өмнөх 6 (зургаа) сарын дотор нэгээс илүү бизнесийн болон хөрөнгийн үнэлгээ хийлгэсэн бол тухайн үнэлгээний тайлан бүрийг бүртгэлийн баримт бичигт хавсаргана.

6.9.9. Бирж гадаад улсад байрладаг хөрөнгийн тухайд тухайн улсын хууль тогтоомжийн дагуу хийгдсэн, хүчин төгөлдөр хөрөнгийн үнэлгээг хүлээн зөвшөөрнө. Гадаад улсад байрладаг хөрөнгийн үнэлгээ нь энэ зүйлд заасан шаардлагыг хангасан гэдгийг Үнэт цаас гаргагч Биржид нотлох үүрэгтэй.

6.10. Бүртгэлийн баримт бичигт өөрчлөлт оруулах

6.10.1. Биржээс баталсан бүртгэлийн баримт бичгийн эцсийн төсөлд Хорооны зөвшөөрөлтэйгээр өөрчлөлт орсон тохиолдолд Биржид нэн даруй мэдэгдэнэ.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

6.11. Бүртгэлийн баримт бичгийн талаар олон нийтэд мэдээлэх

6.11.1. Бүртгэлийн баримт бичгийг Бирж болон Хорооны зөвшөөрлийг үндэслэн, холбогдох журмын дагуу Бирж, Хороонд мэдэгдсэнээр олон нийтэд танилцуулна.

6.11.2. Үнэт цаасыг нийтэд нээлттэй санал болгосон бол дараах мэдээллийг агуулсан зарлалыг бүртгэлийн баримт бичгийг танилцуулсан өдөр нийтэд гаргана. Үүнд:

6.11.2.1. Үнэт цаас гаргагчийн нэр, түүний үүсгэн байгуулагдсан буюу үйл ажиллагаа явуулдаг улсын нэр эсхүл Баталгаат үнэт цаас гаргах тохиолдолд баталгаа гаргагчийн нэр, байгуулагдсан, эсвэл үйл ажиллагаа явуулдаг улсын нэр

6.11.2.2. Бүртгүүлэхээр гаргасан үнэт цаасны тоо ширхэг, төрөл, үнийн дүн

6.11.2.3. Бүртгэлийн баримт бичигтэй хэрхэн танилцах, хэвлэмэл болон цахим хэлбэрээр авч болох тухай заавар

6.11.2.4. Бүртгэлийн баримт бичгийг байршуулсан цахим хуудасны мэдээлэл

6.11.2.5. Бүртгэлийн баримт бичгийн хуулбарыг авч болох газрын хаяг

6.11.2.6. Зарлал гарсан он сар өдөр

6.11.2.7. Үнэт цаасны арилжааг эхлүүлэхээр төлөвлөсөн он, сар, өдөр

6.11.2.8. Андеррайтер байгаа бол түүний нэр, хаяг

6.11.2.9. Үнэт цаасыг бүртгүүлэх болон арилжих зөвшөөрөл авахаар Биржид

өргөдөл гаргасан тухай мэдэгдэл

6.11.2.10. Энэхүү зарлал нь зөвхөн мэдээлэл өгөх зорилготой бөгөөд үнэт цаасыг худалдах, захиалга авах санал, саналын дуудлага биш болохыг баталсан мэдэгдэл.

6.11.3. Үнэт цаас гаргагч Хавсралт 17-д заасан зарлалын загварыг ашиглана.

6.11.4. Зарлалыг сонинд нийтлэх бол 12х16 см2-ээс багагүй хэмжээтэй нийтэлнэ.

6.11.5. Энэ журмын 6.11.2-т заасан зарлал гаргахаар шаардсан аргаар үнэт цаас санал болгосон Үнэт цаас гаргагч нь бүртгэлийн баримт бичгийг олон нийтийн хэрэгцээг бүрэн хангахуйц тоогоор хувилж зарлал нийтлэгдсэн өдрөөс эхлэн үнэт цаасыг санал болгох хугацаа дуусах хүртэл хугацаанд 6.11.2.5-д заасан газарт байрлуулж олон нийт үнэ төлбөргүй, чөлөөтэй авах нөхцөлөөр хангана.

6.12. Бүртгэлийн баримт бичгийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр танилцуулах

6.12.1. Шинээр өргөдөл гаргагч нь бүртгэлийн баримт бичгийг хэвлэмэл хэлбэрээр танилцуулна.

6.12.2. Холбогдох хууль тогтоомж болон шинээр өргөдөл гаргагчийн үүсгэн байгуулах баримт бичигт зөвшөөрсөн бол бүртгэлийн баримт бичиг, үнэт цаас захиалах, худалдан авах захиалгын хуудсыг хэвлэн танилцуулахаас гадна цахим хэлбэрээр нийтэд тарааж болно.

6.12.3. Энэ журмын 6.12.2-т заасны дагуу бүртгэлийн баримт бичгийг цахим хэлбэрээр гаргах бол шинээр өргөдөл гаргагч нь дараах шаардлагыг хангана. Үүнд:

6.12.3.1. Бүртгэлийн баримт бичгийн хэвлэмэл болон цахим хэлбэрийн агуулга нь ижил болохыг баталсан мэдэгдэл оруулах

6.12.3.2. Бүртгэлийн баримт бичгийг цахим хэлбэрээс гадна хэвлэмэл хувилбараар авах боломжтой талаар мэдэгдэл оруулах. Уг мэдэгдэлд бүртгэлийн баримт бичгийн хэвлэмэл хувилбарыг авах боломжтой газрын хаяг, байршлыг заах

6.12.3.3. Бүртгэлийн баримт бичигт өөрчлөлт оруулсан, эсхүл бүртгэлийн баримт бичигт нэмэлтээр баримт бичиг хавсаргасан бол уг өөрчлөлт болон нэмэлт баримт бичгийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр гаргах.

6.13. Үнэт цаас танилцуулсны дараа олон нийтэд мэдээлэл хүргэх

6.13.1. Энэ журмын 3 дугаар бүлэгт заасан аль аргаар үнэт цаас бүртгүүлснээс үл хамааран үнэт цаасыг худалдах саналын үр дүн, үнэт цаас хуваарилах үндэслэл, түүнчлэн үлдэгдэл үнэт цаасыг захиалах, худалдан авах захиалгын хуудас хүлээн авах үндэслэлийн талаар мэдээллийг дор дурдсан үйл явдлын аль түрүүлж тохиохоос 30 (гуч)-аас доошгүй минутын өмнө энэ журамд заасныг баримтлан нийтэд зарласан байна. Үүнд:

6.13.1.1. Өглөөний арилжаа нээх

6.13.1.2. Үнэт цаас хуваарилах тухай албан бичиг болон холбогдох бусад баримт бичгийг хүргүүлсний дараагийн ажлын өдрийн өглөөний арилжааны өмнөх нэмэлт арилжаа нээх.

6.14. Бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн ирүүлэх баримт бичиг

6.14.1. Бирж шаардлагатай гэж үзвэл энэ журамд заасны дагуу бүртгэлийн нэмэлт баримт бичиг, мэдээлэл гаргаж өгөхийг Үнэт цаас гаргагчаас шаардаж болно. Тухайлбал, үнэт цаас нь бүртгэлтэй гадаад улсын хууль тогтоомж, тухайн арилжаа эрхлэх байгууллагын шалгуур шаардлагын хураангуйг бүртгэлийн баримт бичигт оруулахыг шаардаж болно.

6.14.2. Бүртгэлтэй үнэт цаасаа бүртгүүлэх сонирхолтой этгээд энэ журмын 6 дугаар бүлэгт заасны дагуу бүртгэлийн баримт бичиг бүрдүүлэхээс гадна дараах тохируулга, тайлбар, нэмэлт мэдээллийг ирүүлнэ:

6.14.2.1. Бүртгэлийн журмын Хавсралт 19, 20, 21-д заасан зарим мэдээллийг ирүүлэх боломжгүй тохиолдолд уг мэдээлэлтэй адилтгах мэдээллийг тохируулга, тайлбарын хамт ирүүлэх

6.14.2.2. Үнэт цаас гаргагчийн дүрэм, бүтцэд Төлөөлөн удирдах зөвлөл байхгүй бол Бүртгэлийн журмын Хавсралт 19, 20, 21-д заасан мэдэгдлийг Үнэт цаас гаргагчийн адилтгах түвшний албан тушаалтан гарган, тохируулга тайлбарын хамт ирүүлэх

6.14.2.3. Үнэт цаас нь бүртгэгдсэн гадаад улсын хууль тогтоомж, дүрэм журмын дагуу нийтэд хүргэх үүрэгтэй мэдээллийг тайлбарын хамт ирүүлэх

6.14.2.4. Хорооны Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх журмын 3 дугаар бүлгийн 3.4-д заасны дагуу үнэт цаасны танилцуулгад оруулах шаардлагатай нэмэлт материалыг хамт ирүүлэх.

6.14.3. Гадаад улсын болон дотоодын арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийн шалгууруар Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан үнэт цаасны олон нийтийн эзэмшилд байх хувь хэмжээг Биржийн шалгууруас доогуур хувь хэмжээгээр тогтоосон тохиолдолд зах зээлийн үнэлгээ өндөр бөгөөд Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа хэвийн явагдах боломжтой гэж Бирж үзвэл бүртгэлийн шалгуурын холбогдох заалтаас чөлөөлж болно.

6.14.4. Бүртгэлтэй үнэт цаасаа бүртгүүлэх сонирхолтой этгээдийн үйл ажиллагаанд хийгдэх хууль зүйн болон аудитын дүгнэлт, хөрөнгийн үнэлгээний тайланг олон улсад нэр хүнд бүхий мэргэжлийн байгууллагаар Англи хэл дээр хийлгэж болно. Энэ тохиолдолд дүгнэлт, тайланг Монгол хэл дээр хөрвүүлэн Англи хэл дээрх эх хувийн хамт Биржид ирүүлнэ. Англи хэл дээр бэлтгэсэн болон Монгол хэл дээрх

орчуулгын хооронд утга, агуулгын зөрүү гарвал Англи хэл дээр бэлтгэсэн эх хувийг хүчинтэйд тооцно.

6.14.5. Монгол улс болон гадаад улсад үнэт цаасаа бүртгүүлэх сонирхолтой этгээдийн үнэт цаасыг бүртгэсэн гадаад улс хоорондын хууль, эрх зүйн зохицуулалтын ялгаатай байдлаас шалтгаалан Үнэт цаас гаргагч нь Бүртгэлийн баримт бичигт багтсан мэдээллийн нэр томьёо, утга агуулгын талаар нэмэлт тайлбар, тодруулга, тохируулга хийж болно.

ДОЛОО. БҮРТГЭХ ҮНЭТ ЦААС

7.1. Ерөнхий зүйл

7.1.1. Бирж нь Бүртгэлийн шалгуурыг хангасан Үнэт цаас гаргагчийн гаргасан дараах үнэт цаасыг бүртгэнэ. Үүнд:

7.1.1.1. Хувьцаа

7.1.1.2. Өрийн хэрэгсэл

7.1.1.3. Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, нэгж эрх

7.1.1.4. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

7.1.1.5. Варрант

7.1.1.6. Хувьцаанд хөрвөх нөхцөлтэй үнэт цаас

7.1.1.7. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хорооны журамд заасан бусад.

7.1.2. Энэ бүлэгт үнэт цаас гаргагчийн гаргаж буй үнэт цаасны төрлөөс хамааруулан хөнгөлөх, чөлөөлөх болон биелүүлбэл зохих нэмэлт шалгуур, шаардлагыг тодорхойлсон болно.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

7.2. Хувьцаа

Үнэт цаасны талбар

7.2.1. Үнэт цаас гаргагчийн гаргасан хувьцааг Үндсэн болон Хөгжлийн талбарт бүртгэх бөгөөд Үндсэн талбар нь 1 болон 2 дугаар ангилалтай байна. Үндсэн талбарт бүртгэгдсэн хувьцааны 1 болон 2 дугаар ангилал болон Хөгжлийн талбарт бүртгэгдсэн хувьцааг Хорооны журамд харгалзах 1, 2 болон 3-р ангилалтай дүйцүүлэн ойлгоно.

7.2.2. Бирж дор дурдсан Үнэт цаас гаргагчийг Хөгжлийн талбарт бүртгэнэ. Үүнд:

7.2.2.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хорооноос баталсан холбогдох журамд заасан бүртгэлийн шалгуур, шаардлагыг хангасан ч энэ журмын дагуу Биржээс тавьсан Үнэт цаас гаргагчид тавигдах засаглалын эсхүл санхүүгийн шалгуурыг хангаж чадаагүй бөгөөд түүнийг тодорхой хугацаанд хангахаар хүсэлт гаргаж, Бирж түүнийг зөвшөөрсөн бол

7.2.2.2. Энэ журамд заасны дагуу нэмэлт шаардлага хангах шаардлагатай хуулийн этгээд бөгөөд түүнийг хангаж чадаагүй, тодорхой хугацаанд

хангахаар хүсэлт гаргаж, Бирж түүнийг зөвшөөрсөн бол.

7.2.3. Хөгжлийн талбараас Үндсэн талбарт шилжихтэй холбоотой харилцааг Биржээс баталсан Бүртгэлийн гэрээний Тусгай нөхцөлд заасны дагуу зохицуулна.

Бүртгэлийн арга хэлбэр

7.2.4. Үнэт цаас гаргагч нь дараах бүртгэлийн арга хэлбэрийн аль нэгийг ашиглан хувьцааг Биржид бүртгүүлж болно. Үүнд:

7.2.4.1. Захиалга авахаар санал болгох

7.2.4.2. Өөрийн эзэмшлийн үнэт цаасыг худалдахаар санал болгох арга

7.2.4.3. Давхар бүртгэл хийгдэх

7.2.4.4. Урвуу нэгдэл хийх

7.2.4.5. Үнэт цаас хаалттай хүрээнд санал болгох

7.2.4.6. Үнэт цаас гаргагчийн бүртгэл шилжих

7.2.4.7. Холбогдох хууль, журамд заасан бусад

<u>Захиалга авахаар санал болгох арга</u>

7.2.5. Үнэт цаас гаргагч нь нэмэлт хөрөнгө оруулалт татах, ногдол ашиг хувьцаагаар тараах, болон компаниа өөрчлөн байгуулах зорилгоор үнэт цаас гаргахад энэ аргыг ашиглана. Энэ аргыг хэрэглэхдээ дараах хэлбэрүүдээс сонгоно. Үүнд:

7.2.5.1. Нээлттэй санал болгох - Энэ тохиолдолд хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжид санал болгохгүйгээр нийтэд санал болгох

7.2.5.2. Тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хувь тэнцүүлэн эдлүүлэх - Үнэт цаас гаргагч өөрийн хувьцаа эзэмшигчдэд тэдний эзэмшиж буй хувьцааны тоотой хувь тэнцүүлэн шинээр гаргах хувьцааг худалдан авах эрхийг хэрэгжүүлэх зорилгоор санал болгох

7.2.5.3. Тэргүүн ээлжид худалдан авах эрхийг нээлттэй саналаар эдлүүлэх - Үнэт цаас гаргагч өөрийн хувьцаа эзэмшигчдэд тэдгээрийн эзэмшлийн тоонд хувь тэнцүүлэхгүйгээр нээлттэй санал болгох.

7.2.6. Энэ журмын 7.2.5.2, 7.2.5.3-т заасны дагуу тэргүүн ээлжид худалдаж авах нөхцөлтэйгөөр гаргасан үнэт цаас нь Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны тоо, эсхүл Үнэт цаас гаргагчийн зах зээлийн үнэлгээг 50-иас дээш хувиар өсгөхөөр бол (сүүлийн 12 сарын хугацаанд гаргасан хувьцааны нийлбэр) хувьцаа эзэмшигчдийн хурлыг хийхэд дараах нэмэлт журмыг баримтална. Үүнд:

7.2.6.1. Хяналтын багц эзэмшигч, түүний холбогдох этгээд, хяналтын багц эзэмшигч байхгүй тохиолдолд Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал болон тэдгээрийн холбогдох этгээдүүд үнэт цаас

гаргах эсэхийг шийдвэрлэх хувьцаа эзэмшигчдийн хуралд дэмжсэн санал өгөх эрхгүй байх.

7.2.7. Үнэт цаас гаргагч нь хувьцааг тэргүүн ээлжид худалдах нөхцөлтэйгөөр үнэт цаас гаргаж байгаа зорилго болон татан төвлөрүүлэх хөрөнгийн нийт дүн, тухайн хөрөнгийн зарцуулалтын задаргааг хувьцаа эзэмшигчдэд өгөх мэдэгдэлд нэмэлтээр тусгана.

7.2.8. Энэ журмын 7.2.5.2, 7.2.5.3-т заасны дагуу хувьцааг тэргүүн ээлжид худалдаж авах нөхцөлтэйгөөр нэмэлт хувьцаа гаргаж байгаа тохиолдолд дараах этгээдүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлын үнэт цаас гаргахтай холбогдох асуудалд дэмжсэн санал өгөхгүй байхыг Бирж шаардаж болно. Үүнд:

7.2.8.1. Үнэт цаас гаргах шийдвэрийг ТУЗ-өөс гаргах үед Үнэт цаас гаргагчийн хяналтын багц эзэмшигч байсан этгээд болон түүний холбогдох этгээд

7.2.8.2. Үнэт цаас гаргах шийдвэрийг ТУЗ-өөс гаргах үед Үнэт цаас гаргагчид хяналтын багц эзэмшигч байхгүй байсан бол тухайн үед ТУЗ-ийн гишүүн (ТУЗ-ийн хараат бус гишүүн хамаарахгүй), гүйцэтгэх захирал байсан этгээдүүд болон тэдгээрийн холбогдох этгээд.

7.2.9. Энэ журмын 7.2.10-т зааснаас бусад тохиолдолд шинээр өргөдөл гаргагчийн үнэт цаасыг арилжиж эхэлснээс хойш 12 (арван хоёр) сарын дотор тэргүүн ээлжид худалдан авах нөхцөлтэйгөөр нэмж үнэт цаас гаргахыг хориглоно.

7.2.10. Үнэт цаас гаргагчийн хяналтын багц эзэмшигч, түүний холбогдох этгээд, хяналтын багц эзэмшигч байхгүй тохиолдолд Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал болон тэдгээрийн холбогдох этгээдүүд тэргүүн ээлжид худалдан авах нөхцөлтэйгөөр үнэт цаас гаргах эсэхийг шийдвэрлэх хувьцаа эзэмшигчдийн хуралд дэмжсэн санал өгөх эрхгүйгээр хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон бол энэ журмын 7.2.9 заалт хамаарахгүй.

7.2.11. Тэргүүн ээлжид худалдан авах нөхцөлтэйгөөр үнэт цаас гаргахад үнэт цаас худалдах саналыг ажлын 10 (арав) хоногоос доошгүй хугацаанд нээлттэй байлгана. Үнэт цаас гаргагч нь олон тооны хувь эзэмшигчидтэй байх тохиолдолд санал нээлттэй байх доод хугацааг Бирж 15 (арван тав) хоног болгон нэмэгдүүлж болно.

7.2.12. Тэргүүн ээлжид худалдан авах эрхээ хэрэгжүүлээгүй үлдсэн хувьцааг нээлттэй санал болгож болно.

<u>Өөрийн эзэмшлийн хувьцааг санал болгох</u>

7.2.13. Үнэт цаас гаргагчийн хяналтын багц эзэмшигч, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны 5 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний өөрийн эзэмшлийн хувьцааг Хорооны холбогдох журамд заасны дагуу олон нийтэд санал болгож болно.

Үнэт цаас хаалттай хүрээнд санал болгох арга

7.2.14. Бүртгэлтэй Үнэт цаас гаргагч нь энэ аргыг хэрэглэх тохиолдолд Биржээс зөвшөөрсөн тохиолдолд 6 дугаар бүлэгт заасан шалгууруудыг хангасан бүртгэлийн баримт бичгийг бэлтгэхгүй байж болно.

7.2.15. Үнэт цаас гаргагч нь энэ аргыг хэрэглэх тохиолдолд дараах нэмэлт шалгуурын хангасан байна. Үүнд:

7.2.15.1. Дараах этгээдэд хувьцаа санал болгохдоо Биржээс урьдчилан зөвшөөрөл авах

a. Үнэт цаас гаргагчийн үндсэн андеррайтерын холбогдох этгээд

b. Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагууд, одоогийн хувьцаа эзэмшигчид, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд

7.2.15.2. Үнэт цаасыг хаалттай хүрээнд санал болгох тухай шийдвэр гарсан өдөр энэ тухай зарлалыг ажлын 2 (хоёр) өдөрт багтаан олон нийтэд мэдээлэх

7.2.15.3. Үнэт цаас байршуулж дууссан тухай болон түүний үр дүнг зарлахдаа худалдан авагчийн товч танилцуулга, худалдан авсан хэмжээний талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх

Бүртгэл шилжих арга

7.2.16. Үнэт цаас гаргагч нь энэ журмын 3 дугаар бүлэгт заасан бүртгэл шилжих аргыг ашиглан Биржид бүртгэгдэх тохиолдолд дараах нэмэлт шалгуурыг хангасан байна. Үүнд:

7.2.16.1. Бүртгэлтэй Үнэт цаас гаргагч нь арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдсэнээс хойш 1 (нэг) жилийн хугацаа өнгөрсөн байх

Давхар бүртгэгдэх арга

7.2.17. Үнэт цаасаа давхар бүртгүүлэх сонирхолтой Үнэт цаас гаргагч нь дараах нэмэлт шаардлагыг хангасан байна. Үүнд:

7.2.17.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 18 дугаар бүлгийн 18.4-д заасны дагуу Хорооны баталсан жагсаалт дахь гадаад улсын болон дотоодын арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаас нь бүртгэгдсэн байх

7.2.17.2. Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагын зөвлөмж, стандарт, Монгол улсын хууль тогтоомж, Хороо болон Биржийн дүрэм журмыг дагаж мөрдөхөө хүлээн зөвшөөрсөн байх

7.2.18. Үнэт цаас гаргагч нь гадаад улсад бүртгэлтэй Үнэт цаас гаргагч байх тохиолдолд түүнийг Монгол улсад төлөөлөх эрхийг зөвхөн нэг этгээдэд олгоно.

7.2.19. Энэ журмын 7.2.17-д заасан Үнэт цаас гаргагч нь үнэт цаасаа Биржид бүртгэлтэй байх хугацаанд түүнийг Монгол улсад төлөөлөх этгээдийг томилох

үүрэгтэй бөгөөд төлөөлөх этгээдийг томилсон, томилгоог хүчингүй болгосон шийдвэрийг дараах мэдээллийн хамт тухай бүр Биржид ирүүлнэ. Үүнд:

7.2.19.1. Төлөөлөх этгээдийн Монгол Улсад үйл ажиллагаа явуулах оффисын хаяг

7.2.19.2. Төлөөлөх этгээдийн Монгол Улсад оршин суух гэрийн хаяг

7.2.19.3. Төлөөлөх этгээдийн оффисын болон гэрийн утас, гар утас

7.2.19.4. Төлөөлөх этгээдийн и-мэйл хаяг, факсын дугаар

7.2.19.5. Дээрх мэдээллүүдэд орсон аливаа өөрчлөлт.

Бүртгэлийн шалгуур

7.2.20. Шинээр өргөдөл гаргагч нь үнэт цаасаа олон нийтэд санал болгох тохиолдолд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.21-т заасны дагуу 50 (тавь)-аас доошгүй этгээдэд санал болгоно.

7.2.21. Үнэт цаас гаргагч нь олон нийтэд нээлттэй хувьцаа санал болгох тохиолдолд дараах нэмэлт шалгуурыг хангасан байна. Үүнд:

7.2.21.1. Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан үнэт цаасны 25 (хорин тав)-аас доошгүй хувийг олон нийт эзэмшиж байх

7.2.21.2. Үнэт цаас гаргагч нь бүртгүүлэх гэж буй үнэт цааснаас гадна нэг ба түүнээс дээш төрлийн үнэт цаастай бол бүртгүүлэх үед түүний Бирж болон бусад зохицуулалттай зах зээл дээр гаргасан нийт үнэт цаасны 25 (хорин тав)-аас доошгүй хувь нь олон нийтийн эзэмшилд байх.

7.2.22. Бирж тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалан олон нийтийн эзэмшилд байх үнэт цаасны доод хэмжээг түр хугацаагаар багасгаж болно. Уг хугацаа дуусахад олон нийтийн эзэмшилд байх хувьцааны тоог журамд заасан хэмжээнд байлгах үүргийг Үнэт цаас гаргагч хүлээнэ.

7.2.23. Зах зээлийн үйл ажиллагаа хэвийн явагдах боломжтой гэж Бирж үзвэл 2,000,000,000 (хоёр тэрбум) төгрөгөөс дээш зах зээлийн үнэлгээтэй Үнэт цаас гаргагчийн олон нийтийн эзэмшилд байх үнэт цаасны доод хувь хэмжээг 10 (арав) – 25 (хорин тав) хувиар тогтоож болно. Энэ тохиолдолд бүртгэлийн баримт бичигт олон нийтийн эзэмшилд байх хувь хэмжээг багаар тогтоосон тухай мэдээллийг тусгана.

7.2.24. Үнэт цаас гаргагч нь нээлттэй хувьцаат компани болох зорилгоор гол хувьцаа эзэмшигчид болон гүйцэтгэх удирдлага өөрчлөгдсөн тохиолдолд Бирж зөвшөөрсөн бол энэ журмын 4.3.1.2, 4.3.1.3-т заасан шалгуураас чөлөөлөгдөж болно.

7.2.25. Үнэт цаас гаргагч нь Биржийн Үндсэн талбарын 1 дүгээр ангилалд бүртгэгдэх бол энэ журмын 7.2.26-д заасан шалгуурыг хангах шаардлагагүй бөгөөд дараах

шалгууураас дорж хаяж 2 (хоёр) шалгуурыг хангасан байна. Үүнд:

7.2.25.1. Сүүлийн нэг жилийн хувьцаа эзэмшигчдэд хуваарилсан буюу хуваарилж болох байсан ашгийн хэмжээ нь 3,000,000,000 (гурван тэрбум) төгрөгөөс багагүй байх

7.2.25.2. Бүртгүүлэх үеийн зах зээлийн үнэлгээ нь 50,000,000,000 (тавин тэрбум) төгрөгөөс багагүй байх

7.2.25.3. Хамгийн сүүлийн аудитлагдсан санхүүгийн тайланд тусгасан орлогын хэмжээ 10,000,000,000 (арван тэрбум) төгрөгөөс багагүй байх.

7.2.26. Үнэт цаас гаргагч нь Биржийн Үндсэн талбарын 2 дугаар ангилалд бүртгэгдэх бол дараах шалгууураас дорж хаяж 2 (хоёр) шалгуурыг хангасан байна. Үүнд:

7.2.26.1. Сүүлийн нэг жилийн хувьцаа эзэмшигчдэд хуваарилсан буюу хуваарилж болох байсан ашгийн хэмжээ нь 200,000,000 (хоёр зуун сая) төгрөгөөс багагүй байх эсхүл сүүлийн нэг жилээс өмнөх хоёр жилийн хувьцаа эзэмшигчдэд хуваарилсан буюу хуваарилж болох байсан ашгийн нийлбэр нь 200,000,000 (хоёр зуун сая) төгрөгөөс багагүй байх

7.2.26.2. Бүртгүүлэх үеийн зах зээлийн үнэлгээ нь 3,000,000,000 (гурван тэрбум) төгрөгөөс багагүй байх

7.2.26.3. Хамгийн сүүлийн аудитлагдсан санхүүгийн тайланд тусгасан орлогын хэмжээ 500,000,000 (таван зуун сая) төгрөгөөс багагүй байх.

Бүртгүүлэх өргөдөл гаргах

7.2.27. Шинээр өргөдөл гаргагч нь олон нийтэд нээлттэй хувьцаа санал болгох тохиолдолд энэ журмын 5 дугаар бүлэгт заасны дагуу Биржид бүртгүүлэх өргөдөл гаргана.

7.2.28. Бүртгэлтэй Үнэт цаас гаргагч нь нэмэлт хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэхгүйгээр Биржид бүртгэгдэх тохиолдолд энэ журмын 5.2.1.2-5.2.1.6, 5.2.1.10 дэх үе шатуудыг баримтлан бүртгүүлэх өргөдөл гаргана.

Бүртгэлийн баримт бичиг

7.2.29. Шинээр өргөдөл гаргагч олон нийтэд нээлттэй хувьцаа санал болгох тохиолдолд энэ журмын 6 дугаар бүлэгт заасан бүртгэлийн баримт бичгийг бэлтгэн Биржид ирүүлнэ.

7.2.30. Бүртгэлтэй Үнэт цаас гаргагч нь нэмэлт хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэхгүйгээр Биржид бүртгэгдэх тохиолдолд Биржтэй тохиролцсоны үндсэн дээр бүртгэлийн баримт бичгийг хялбаршуулсан хэлбэрээр ирүүлж болно.

7.2.31. Бүртгэлтэй Үнэт цаас гаргагчийн нэмж гаргах хувьцааны тоо нь түүний нийт гаргасан хувьцааны 5 (тав) хувиас бага бол бүртгэлийн баримт бичиг

шаардахгүй.

7.2.32. Бүртгэлтэй Үнэт цаас гаргагч Биржид хувьцаа бүртгүүлэх тохиолдолд дор дурдсан баримт бичгүүдийг бүртгүүлэх өргөдлийн хамт ирүүлнэ. Үүнд:

7.2.32.1. Үнэт цаас гаргагчийг дахин хөрөнгөжүүлэх зорилгоор бүртгүүлэх гэж буй үнэт цаасны тухайд холбогдох шүүхийн шийдвэр

7.2.32.2. Бусад шаардлагатай баримт бичиг.

7.3. Өрийн хэрэгсэл

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 4 сарын 13-ны өдрийн 07/22 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

Үнэт цаасны талбар

7.3.1. Үнэт цаас гаргагчийн гаргасан өрийн хэрэгслийг үндсэн 1 талбарт бүртгэнэ.

Бүртгэлийн арга хэлбэр

7.3.2. Үнэт цаас гаргагч нь дараах арга хэлбэрийн аль нэгийг ашиглан өрийн хэрэгслийг Биржид бүртгүүлж болно. Үүнд:

7.3.3.1. Захиалга авахаар санал болгох

7.3.3.2. Биржээс зөвшөөрсөн бусад.

Бүртгэлийн шалгуур

7.3.3. Үнэт цаас гаргагч нь олон нийтэд нээлттэй өрийн хэрэгсэл гаргах тохиолдолд дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

7.3.3.1. Үнэт цаас гаргагч болон баталгаат өрийн хэрэгсэл гаргах тохиолдолд баталгаа гаргагчийн өөрийн хөрөнгийн хэмжээ 1,000,000,000 (нэг тэрбум) төгрөгөөс багагүй, бүртгүүлэх өрийн хэрэгслийн номинал хэмжээ 500,000,000 (таван зуун сая) төгрөгөөс багагүй байна. Үнэт цаас гаргагч нь хувьцаанд хөрвөх нөхцөл бүхий өрийн хэрэгсэл гаргаж болно.

7.3.3.2. Үнэт цаас гаргагч нь хөрвөх нөхцөл бүхий өрийн хэрэгсэл гаргасан тохиолдолд Компанийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан шаардлагыг бүрэн хангасан байх.

7.3.4. Өрийн хэрэгсэл гаргаж буй үнэт цаас гаргагч нь хувьцааны бүртгэлийн Үндсэн талбарын 2 дугаар ангиллын шалгуурыг хангах бөгөөд Биржээс зөвшөөрсөн тохиолдолд засаглал болон санхүүгийн шалгуурыг хэсэгчлэн хангаж болно.

7.3.5. Биржид бүртгэлтэй Үнэт цаас гаргагч өрийн хэрэгсэл нэмж гаргахад 7.3.3-т заасан өөрийн хөрөнгийн болон өрийн хэрэгслийн номинал хэмжээнд тавигдах хязгаарлалт хамаарахгүй.

7.3.6. Үнэт цаас гаргагчийн гаргаж буй шинэ өрийн хэрэгсэл нь хөрөнгө оруулагчдын сонирхлыг ихээр татаж байгаа тохиолдолд Бирж номинал хэмжээний доод хязгаарыг бууруулж болно.

7.3.7. Үнэт цаас гаргагч нь дотоодын эсхүл олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагаар санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгосон бол үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгож эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийг барьцаалахгүй байж болно.

Бүртгүүлэх өргөдөл гаргах

7.3.8. Өргөдөл гаргагч нь олон нийтэд нээлттэй өрийн хэрэгсэл гаргах тохиолдолд энэ журмын Хавсралт 4-т заасны дагуу Биржид бүртгүүлэх өргөдөл гаргана.

Бүртгэлийн баримт бичиг

7.3.9. Өмнө гаргасан өрийн хэрэгсэл эзэмшигчдэд шинэ төрлийн өрийн хэрэгсэл санал болгох тохиолдолд шинээр өргөдөл гаргагч, эсвэл бүртгэлтэй Үнэт цаас гаргагчийн бүртгэлийн өргөдөл болон бүртгэлийн баримт бичигт тавигдах шаардлагуудаас гадна баталгаат үнэт цаас гаргах бол баталгаа гаргагчийн бизнесийн үйл ажиллагааны чиглэл, гаргах гэж буй өрийн хэрэгсэлтэй холбоотой ашиг алдагдал, тухайн өрийн хэрэгсэлд дагалдах эрх болон үйл ажиллагаа, хөрөнгө ба өр төлбөр, санхүүгийн байдал, удирдлага ба ирээдүйн төлөвлөгөөнд үнэлэлт дүгнэлт хийх боломцоог хөрөнгө оруулагчдад олгох зорилгоор тодорхой тайлан болон мэдээллийг тусгана.

7.3.10. Үнэт цаас гаргагч нь өрийн хэрэгсэл бүртгүүлэх өргөдөл гаргахад дараах баримт бичгийг Биржид нэмж ирүүлнэ. Үүнд:

7.3.10.1. Өрийн хэрэгсэл захиалах, худалдан авах захиалгын хуудсын төсөл 1 (нэг) хувь

7.3.10.2. Өрийн хэрэгсэл гаргах хөтөлбөр хэрэгжүүлэх тохиолдолд анхдагч зах зээлд санал болгохоос 10-аас доошгүй өдрийн өмнө дараах баримт бичгийг Биржид ирүүлнэ. Үүнд:

a. Санал болгож буй өрийн хэрэгслийн захиалга авч эхлэх огноо, үргэлжлэх хугацаа, хэмжээ, үнэ

b. Санал болгох арга, хэлбэр

c. Өмнөх улирлын санхүүгийн үзүүлэлт

d. Хөтөлбөрийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, мэдээлэл

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 4 сарын 13-ны өдрийн 07/22 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

7.3.10.3. Өрийн хэрэгслийн эргэн төлөлтийн үүргийн гүйцэтгэлийн баталгаа болох барьцаа, баталгаа, хөрөнгө барьцаалахгүй тохиолдолд дотоодын

эсхүл олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагаар санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгосон тухай тайлан, мэдээ

7.3.10.4. Ногоон бонд гаргах этгээд нь хөндлөнгийн мэргэжлийн баталгаажуулалтын байгууллагыг томилж, дүгнэлт гаргуулсан бол уг этгээдийн тухай мэдээлэл.

7.4. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх

Үнэт цаасны талбар

7.4.1. Үнэт цаас гаргагчийн сангийн нэгж эрхийг үндсэн 1 талбарт бүртгэнэ.

Бүртгэлийн арга хэлбэр

7.4.2. Үнэт цаас гаргагч нь энэ журмын 3.2.1-т заасан бүртгэлийн арга хэлбэрээс сонгож сангийн нэгж эрхийг Биржид бүртгүүлж болно.

Бүртгэлийн шалгуур

7.4.3. Үнэт цаас гаргагч нь нээлттэй, хаалттай болон биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сан хэлбэртэй байж болох бөгөөд энэхүү хэлбэрээс үл хамаарч дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

7.4.3.1. Холбогдох хууль болон Хорооны журамд заасан шаардлага, шалгуурыг хангаж байх

7.4.3.2. Хөрөнгө хадгалах болон хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулсан байх

7.4.3.3. Сангийн цэвэр хөрөнгийг үнэ цэнийг тооцоолох хүний нөөцийн болон техникийн чадамжтай байх

7.4.3.4. Сангийн активыг Хорооны журамд заасны дагуу бүрдүүлэх.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

7.4.4. Хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сан нь дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

7.4.4.1. Сангийн нэгж эрхийг анхдагч зах зээлд бусад санхүүгийн хэрэгслээр солих

7.4.4.2. Сангийн активын багцыг хөрвөх чадвар сайтай санхүүгийн хэрэгслээр бүрдүүлэх

7.4.4.3. Зах зээлийн нөхцөл байдал, санхүүгийн чадавх, активын багцыг бүрдүүлэх санхүүгийн хэрэгслийн хөрвөх чадвар хангалтгүй нөхцөлд сангийн хөрөнгийн 30 (гуч) хүртэл хувийг мөнгөн хөрөнгөөр

худалдаалах

7.4.4.4. Хоёрдогч зах зээлийн арилжаанд Хорооны холбогдох журамд зааснаас багагүй тооны мэргэжлийн оролцогчтой гэрээ байгуулж ажиллах

7.4.4.5. Сангийн активыг гуравдагч этгээдийн өмнө үүргийн гүйцэтгэлийг хангуулах болон өмчлөх эрхийн зөрчилгүй санхүүгийн хэрэгслээр бүрдүүлэх

7.4.4.6. Сангийн цэвэр активын үнэлгээг Хороо болон Биржээс тогтоосон хугацаанд өөрийн цахим хуудсаар мэдээллэх боломжтой байх

7.4.4.7. Сангийн хөрөнгийг бусдад мөнгөн хэлбэрээр зээлэхгүй байх.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор нэмсэн/

7.4.5. Хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг анхдагч зах зээлд олон нийтэд танилцуулах ажиллагааг хэрэгжүүлэхгүй. Хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн хувьд анхдагч зах зээлийн арилжаанд сангийн нэгж эрхийг анхдагч зах зээлд бусад санхүүгийн хэрэгслээр солих ажиллагааг хэрэгжүүлэх ба Биржийн "Арилжааны журам"-ын 7 дугаар бүлгийн 7.1 - 7.7 дахь заалтууд хамаарахгүй.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор нэмсэн/

7.4.6. Энэхүү журмын 7.4.4.2-т заасан сангийн активын багцыг бүрдүүлэхдээ эрх бүхий зохицуулах байгууллагаас авсан тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй арилжаа эрхлэх байгууллагаас гаргадаг индексэд багтсан санхүүгийн хэрэгслээр бүрдүүлнэ. Сангийн активын багцыг 3 (гурав)-аас илүүгүй индексэд багтсан санхүүгийн хэрэгслүүдээр бүрдүүлж болно.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор нэмсэн/

7.4.7. Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж гаргах тохиолдолд хөтөлбөрийн буюу үе шаттайгаар гаргахыг хориглоно.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор нэмсэн/

7.4.8. Биржээс шаардаагүй тохиолдолд үнэт цаас гаргагч нь энэ журмын 4 дүгээр бүлэгт заасан бүртгэлийн шаардлага, шалгуурыг хангах шаардлагагүй.

Бүртгүүлэх өргөдөл гаргах

7.4.9. Өргөдөл гаргагч нь энэ журмын Хавсралт 2-т заасны дагуу Биржид бүртгүүлэх өргөдөл гаргана.

Бүртгэлийн баримт бичиг

7.4.10. Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх бүртгүүлэх өргөдөл гаргахад энэ журмын 6.2.1.1-6.2.1.4, 6.2.1.6, 6.2.1.8-6.2.1.14, 6.2.1.16, 6.2.2.1, 6.2.2.3-6.2.2.4, 6.2.3, 6.2.4-д зааснаас гадна дараах баримт бичгийг Биржид нэмж ирүүлнэ. Үүнд:

7.4.10.1. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулгын төсөл (Хавсралт 19)

7.4.10.2. Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг, хөрөнгө оруулах санхүүгийн хэрэгслийн мэдээлэл

7.4.10.3. Хадгаламжийн байгууллагатай байгуулсан гэрээний хуулбар

7.4.10.4. Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний гэрээний хуулбар

7.4.10.5. Хөрөнгө итгэмжлэн удирдах менежментийн компанийн дүрмийн хуулбар

7.4.10.6. Андеррайтертай хамтран ажиллах тохиолдолд байгуулсан гэрээ болон холбогдох амлалт, мэдэгдэл, баталгаа

7.4.10.7. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх гаргах ажиллагаанд оролцож байгаа мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаа, удирдлага, бүтэц зохион байгуулалт, гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, шаардлагатай журам, гэрээний төсөл

7.4.10.8. Хөрөнгө оруулалтын санг бусад төрлийн сантай харьцуулсан судалгаа

7.4.10.9. Хөрөнгө оруулалтын менежментийн компанид төлөх хөлс, урамшууллын бодлого

7.4.10.10. Учирч болох эрсдэл, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө

7.4.10.11. Гадаад улсад бүртгэлтэй ХОС-г Биржид бүртгүүлэх тохиолдолд Хорооны журамд ирүүлэхээр заасан баримт бичиг

7.4.10.12. Сангийн нэгж эрхийг үнэлэх, олон нийтэд мэдээлэл хүргэх болон холбогдох хууль, журамд заасан бусад журмуудын хуулбар

7.4.10.13. Хорооны холбогдох журамд заасан шаардлагуудыг хангаж буйг нотлох баримт бичиг

7.4.10.14. Энэ журамд заасан шаардлагыг хангаж буйг нотлох зорилгоор Биржээс шаардсан бусад баримт бичиг.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан/

7.4.11. Хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг бүртгүүлэхэд энэ журмын 7.4.10-д зааснаас гадна дараах баримт бичгийг

Биржид нэмж ирүүлнэ. Үүнд:

7.4.11.1. Сангийн нэгж эрхийг солих санхүүгийн хэрэгслийн жагсаалт, үнэ, тоо хэмжээ, өмчлөх эрхийн зөрчилгүй тухай баталгаа

7.4.11.2. Хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн мэргэжлийн оролцогчидтой байгуулсан гэрээний хуулбар

7.4.11.3. Мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааны нарийвчилсан журам, программ хангамжтай холбоотой мэдээлэл

7.4.11.4. Сан болон мэргэжлийн оролцогчийн хооронд нэгж эрхийг анхдагч болон хоёрдогч зах зээлд тогтмол солилцоход хадгаламжийн байгууллагаас өмчлөх эрхийг шилжүүлэх, тухайлсан бүртгэлийг хөтлөхтэй холбоотой нарийвчилсан харилцааг зохицуулсан журмын төсөл.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор нэмсэн/

7.4.12. ХОС-г нэгтгэх, нийлүүлэх замаар өөрчлөн байгуулах тохиолдолд Хорооны журамд заасан баримт бичгийг ирүүлэх ба Бирж нэмэлт баримт бичиг шаардахгүй.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор нэмсэн/

7.4.13. Үнэт цаас гаргагч нь түүний өргөдлийг Бүртгэлийн хороо хэлэлцэхээс өмнө бүх баримт бичгүүдийн эцсийн төслийг ирүүлсэн байна.

Хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн хөрвөх чадвар

7.4.14. Хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хөрвөх чадварыг үндсэн 3 үзүүлэлтээр хэмжинэ. Үүнд:

7.4.14.1. Сангийн нэгж эрхийн хөрвөх чадварын үзүүлэлт

a. Сангийн нэгж эрхийн арилжааны дүн

b. Сангийн нэгж эрхийн авах, зарах захиалгын үнийн зөрүү

c. Сангийн нэгж эрхийн нээлттэй захиалгын дүн

7.4.14.2. Суурь үнэт цаасны хөрвөх чадварын үзүүлэлт

a. Суурь үнэт цаасны эргэц

b. Суурь үнэт цаасны багцын арилжааны дүн

c. Суурь үнэт цаасны багцын авах, зарах захиалгын үнийн зөрүү

7.4.14.3. Сангийн нэгж эрхийн болон суурь үнэт цаасны багцын харьцуулсан

үзүүлэлтүүд

a. Арилжааны дүнгийн харьцуулсан үзүүлэлт

b. Авах, зарах захиалгын үнийн зөрүүг харьцуулсан үзүүлэлт

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор нэмсэн/

7.4.15. Сангийн нэгж эрхийн арилжааны дүн гэж тухайн сангийн нэгж эрх нь Биржийн арилжааны хуваарийн дагуу хоёрдогч зах зээлд арилжигдсан нийт хэмжээ, үнийн дүнг хэлнэ. Бирж энэхүү үзүүлэлтийг олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор нэмсэн/

7.4.16. Сангийн нэгж эрхийн авах, зарах захиалгын үнийн зөрүү гэж зах зээлд оролцогчдын ирүүлсэн хамгийн сайн авах болон зарах захиалгын үнийн зөрүүг хэлнэ. Бирж энэхүү үзүүлэлтийг олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор нэмсэн/

7.4.17. Сангийн нэгж эрхийн нээлттэй захиалгын дүн гэж Биржийн арилжааны хуваарийн дагуу явагдаж буй хоёрдогч зах зээлийн арилжааны үеэрх нээлттэй захиалгын нийт хэмжээ, үнийн дүнг хэлнэ. Бирж энэхүү үзүүлэлтийг зөвхөн арилжаанд оролцогчдод мэдээлнэ.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор нэмсэн/

7.4.18. Суурь үнэт цаасны эргэц гэж тухайн сангийн нэгж эрхийг солилцсон суурь үнэт цаас тус бүрийн арилжигдсан үнийн дүнг, гаргасан үнэт цаасны тоонд харьцуулсан үзүүлэлтийг хэлнэ. Сангийн нэгж эрхийн бүртгэлтэй байх хугацаанд түүний суурь үнэт цаасны эргэцийн талаарх мэдээллийг мэргэжлийн оролцогч тогтмол Биржид ирүүлнэ. Суурь үнэт цаасны эргэцийг дараах томьёог ашиглан тооцно. Үүнд:

$$[\text{Үнэт цаасны эргэц} = \frac{\text{Өгсөн хугацаанд арилжсан үнэт цаасны тоо ширхэг}}{\text{Нийт гаргасан үнэт цаасны тоо ширхэг}}]$$

Энэ харьцаа өндөр байх тусам хөрвөх чадвар сайтай байна гэж үзнэ.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор нэмсэн/

7.4.19. Суурь үнэт цаасны багцын арилжааны дүн гэж тухайн багцыг бүрдүүлж буй нийт үнэт цаасны Биржийн арилжааны хуваарийн дагуу хоёрдогч зах зээлд арилжигдсан нийт хэмжээ, үнийн дүнг хэлнэ.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот

тогтоолоор нэмсэн/

7.4.20. Суурь үнэт цаасны багцын авах, зарах захиалгын үнийн зөрүү гэж тухайн багцыг бүрдүүлж буй нийт үнэт цаасны хувьд зах зээлд оролцогчдын ирүүлсэн хамгийн сайн авах болон зарах захиалгын үнийн зөрүүний дунджийг хэлнэ.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор нэмсэн/

7.4.21. Арилжааны дүнгийн харьцуулсан үзүүлэлт гэж сангийн нэгж эрхийн арилжааны дүнг суурь үнэт цаасны багцад байгаа нийт үнэт цаасны арилжааны дүнд харьцуулсан харьцааг хэлнэ.

$$[\text{Арилжааны дүнгийн харьцуулсан үзүүлэлт} = \frac{\text{Сангийн арилжааны дүн}}{\text{Суурь үнэт цаасны багцын арилжааны дүн}}]$$

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор нэмсэн/

7.4.22. Авах, зарах захиалгын үнийн зөрүүг харьцуулсан үзүүлэлт нь сангийн нэгж эрх болон суурь үнэт цаасны багцад байгаа нийт үнэт цаасны авах, зарах үнийн зөрүүг харуулдаг.

[Үнийн зөрүү харьцуулсан үзүүлэлт = Сангийн нэгж эрхийн авах, зарах үнийн зөрүү - Суурь үнэт цаасны багцын авах, зарах үнийн зөрүү]

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор нэмсэн/

7.5. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

Үнэт цаасны талбар

7.5.1. Үнэт цаас гаргагчийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг үндсэн 1 талбарт бүртгэнэ.

Бүртгэлийн арга хэлбэр

7.5.2. Үнэт цаас гаргагч нь энэ журмын 3.2.1-д заасан бүртгэлийн арга хэлбэрээс сонгож хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Биржид бүртгүүлж болно.

Бүртгэлийн шалгуур

7.5.3. Үнэт цаас гаргагч нь барьцаат болон баталгаат хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргаж болох бөгөөд энэхүү үнэт цаасны төрлөөс үл хамаарч дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

7.5.3.1. Холбогдох хууль болон Хорооны журамд заасан шаардлага, шалгуурыг хангаж байх

7.5.3.2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас эзэмшигчдийн эрх ашгийг илэрхийлэх хамгаалах тогтолцоо, бүтэцтэй байх эсхүл энэ чиглэлээр мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах

7.5.3.3. Холбогдох хууль болон Хорооны журамд заасны дагуу Үйлчилгээ үзүүлэх гэрээ, Хөрөнгө итгэмжлэгдсэн удирдах гэрээ зэрэг бүхий л шаардлагатай гэрээг байгуулан ажиллах

7.5.3.4. Баталгаа гаргаж буй үнэт цаас нь хувьцаа байх тохиолдолд тухайн хувьцаа аль нэг арилжаа эрхлэх байгууллагад нээлттэй арилжигддаг байх

7.5.3.5. Хорооноос шаардсан аливаа хязгаарлалтыг дагаж мөрддөг байх.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

7.5.4. Биржээс шаардаагүй тохиолдолд үнэт цаас гаргагч нь энэ журмын 4 дүгээр бүлэгт заасан бүртгэлийн шаардлага, шалгуурыг хангах шаардлагагүй.

7.5.5. Баталгаат үнэт цаас гаргах тохиолдолд хөтөлбөрийн буюу үе шаттайгаар гаргахыг хориглоно.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор нэмсэн/

Бүртгүүлэх өргөдөл гаргах

7.5.6. Өргөдөл гаргагч нь энэ журмын Хавсралт 3-т заасны дагуу Биржид бүртгүүлэх өргөдөл гаргана.

Бүртгэлийн баримт бичиг

7.5.7. Үнэт цаас гаргагч нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас бүртгүүлэх өргөдөл гаргахад энэ журмын 6.2.1.1-6.2.1.4, 6.2.1.6, 6.2.1.8-6.2.1.14, 6.2.1.16, 6.2.2.1, 6.2.2.3-6.2.2.4, 6.2.3, 6.2.4-д зааснаас гадна дараах баримт бичгийг Биржид нэмж ирүүлнэ. Үүнд:

7.5.7.1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны танилцуулгын төсөл

7.5.7.2. Хөрөнгийн хэмжээ, бүтэц, төрөл

7.5.7.3. Хөрөнгийн гарал үүсэл, биет хөрөнгө тохиолдолд түүний байршлыг нотлох баримт бичиг

7.5.7.4. Холбогдох хууль болон Хорооны журамд заасны дагуу байгуулсан гэрээний хуулбар

7.5.7.5. Хорооны журамд заасны дагуу төлөх төлбөрүүдийн жагсаалт, хэмжээ, төлөх хугацаа

7.5.7.6. Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах, үнэт цаас эзэмшигч болон олон нийтэд мэдээлэл хүргэх, эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх журам болон холбогдох хууль, журамд заасан бусад журмуудын хуулбар

7.5.7.7. Хорооны холбогдох журамд заасан шаардлагуудыг хангаж буйг нотлох баримт бичиг

7.5.7.8. Энэ журамд заасан шаардлагыг хангаж буй нотлох зорилгоор Биржээс шаардсан бусад баримт бичиг.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан/

7.5.8. Барьцаат үнэт цаас гаргагч нь энэ журмын 7.5.7 дахь заалтад зааснаас гадна дараах баримт бичгийг Биржид нэмж ирүүлнэ. Үүнд:

7.5.8.1. Гуравдагч этгээд баталгаа гаргаж буй тохиолдолд баталгаа гаргагчийн ерөнхий болон санхүүгийн мэдээлэл

7.5.8.2. Сүүлийн 1 (нэг) жилийн хугацааны үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан

7.5.8.3. Гурван жилийн бизнес төлөвлөгөө

7.5.8.4. Нэмж барьцаат үнэт цаас гаргаж байгаа тохиолдолд өмнөх гаргасан үнэт цаасны үлдэгдэл, эргэн төлөлт болон хөрөнгийн талаарх мэдээлэл

7.5.8.5. Хөрөнгийн багцыг бүрдүүлж буй хөрөнгийн жагсаалт, одоогийн үнэ, хөрөнгө эрсдэлд орсон тохиолдолд түүнийг солих нөхцөл

7.5.8.6. Хөрөнгийг барьцааны бүртгэл, түүнийг тооцоолсон баланс, орлогын мэдүүлэг.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор нэмсэн/

7.5.9. Баталгаат үнэт цаас гаргагч нь энэ журмын 7.5.7 дахь заалтад зааснаас гадна дараах баримт бичгийг Биржид нэмж ирүүлнэ. Үүнд:

7.5.9.1. Тусгай зориулалтын компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэр

7.5.9.2. Хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны орлогоос бүрдсэн тухай болон гарал үүслийн талаарх нотлох баримт бичиг, хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд ногдох мөнгөн хөрөнгийг өөрийн харилцагч банкны дансанд байршуулсан талаарх банкны тодорхойлолт, бусад баталгаа

7.5.9.3. Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцож байгаа мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаа, удирдлага, бүтэц зохион байгуулалт, гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, туршлагын тухай мэдээлэл

7.5.9.4. Үнэт цаас гаргагч болон мэргэжлийн байгууллагуудын холбоо хамаарал, нэгдмэл сонирхол болон бизнесийн харилцаа холбоотой эсэх мэдээлэл

7.5.9.5. Мэргэжлийн байгууллагуудын тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар, туршлага, байгуулсан гэрээний хуулбар

7.5.9.6. Ангилалтай үнэт цаас гаргах тохиолдолд ангилал тогтоохтой холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл

7.5.9.7. Хөрөнгийн багцыг бүрэлдэхүүнд орсон хөрөнгийн дүн, холбоотой санхүүгийн тооцоолууд, шалгуур үзүүлэлт

7.5.9.8. Учирч болох эрсдэл, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө

7.5.9.9. Санхүүжих чадварын зэрэглэл тогтоолгосон бол зэрэглэл, зэрэглэл тогтоосон байгууллагын мэдээлэл, зэрэглэлийн тайлан.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор нэмсэн/

7.5.10. Үнэт цаас гаргагч нь түүний өргөдлийг Бүртгэлийн хороо хэлэлцэхээс өмнө бүх баримт бичгүүдийн эцсийн төслийг ирүүлсэн байна.

7.6. Бусад үнэт цаас

7.6.1. Компанийн хадгаламжийн бичиг, варрант зэрэг дээрхээс бусад үнэт цаас бүртгүүлэхэд энэ журамд зааснаас гадна Биржийн баталсан тусгайлсан журмаар тогтоосон нэмэлт шаардлагыг хангасан байна.

7.6.2. Опцион, варрант болон тэдгээртэй адилтгах бусад эрхийг бүртгүүлэхэд үнэт цаасанд тавигддаг шаардлагаас гадна холбогдох бусад журамд заасан опцион, варрант, болон тэдгээртэй адилтгах бусад эрхийг бүртгүүлэхэд тавигдах шаардлагыг давхар хангасан байна.

7.6.3. Тодорхой төрлийн үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл гаргасан тохиолдолд дараах журам үйлчилнэ. Үүнд:

7.6.3.1. Өмнө нь бүртгүүлж байгаагүй үнэт цаасны тухайд бүртгүүлэх өргөдлийг тухайн төрлийн гаргасан болон гаргахаар төлөвлөсөн бүх үнэт цаасанд хамаатуулж гаргах

7.6.3.2. Зарим хэсэг нь өмнө бүртгэгдсэн үнэт цаасны тухайд бүртгүүлэх өргөдлийг тухайн төрлийн шинээр гаргасан болон гаргахаар төлөвлөсөн бүх үнэт цаасанд хамаатуулж гаргах.

Аймаг, нийслэлийн үнэт цаас

7.6.4. Аймаг, нийслэлийн Засаг даргын гаргаж буй өрийн хэрэгсэл нь Өрийн удирдлагын тухай хуульд заасан шалгуурыг бүрэн хангасан байна. Энэ журмын 7.3.3-7.3.7-д заасан шалгуур нь Аймаг, нийслэлийн Засаг даргын гаргаж буй өрийн хэрэгсэлд хамаарахгүй.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 4 сарын 13-ны өдрийн 07/22 тоот тогтоолоор нэмсэн/

7.6.5. Аймаг, нийслэлийн Засаг даргын гаргаж буй өрийн хэрэгслийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 2 дугаар бүлэгт заасны дагуу бүртгэнэ.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 4 сарын 13-ны өдрийн 07/22 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

7.6.6. Аймаг, нийслэлийн Засаг даргын үнэт цаасыг бүртгүүлэхэд аливаа нэмэлт шаардлага тавигдахгүй бөгөөд Хорооны өрийн хэрэгсэл бүртгэхтэй холбоотой журмыг үндсэн шалгуур болгоно.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 4 сарын 13-ны өдрийн 07/22 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

7.6.7. Биржээс шаардсан тохиолдолд аймаг, нийслэлийн Засаг даргын өрийн хэрэгсэл гаргах бүртгэлийн баримт бичигт дараах нэмэлт мэдээллийг тусгана. Үүнд:

7.6.7.1. Аймаг, нийслэлийн нарийвчилсан мэдээлэл

7.6.7.2. Үнэт цаас гаргагчид хамаарах эдийн засгийн байдлын дараах мэдээлэл

a. Ерөнхий мэдээлэл

b. Сүүлийн 2 (хоёр) жилийн үйлдвэрлэлийн хэмжээ салбараар

c. Сүүлийн 2 (хоёр) жилийн үнэ, цалин хөлс, ажил эрхлэлтийн мэдээлэл

d. Сүүлийн 2 (хоёр) жилийн экспорт, импортын мэдээлэл

e. Төлбөрийн тэнцэл

f. Алт болон гадаад валютын нөөц

g. Орлогын үндсэн эх үүсвэрийн мэдээлэл.

7.6.7.3. Санхүү

a. Сүүлийн 2 (хоёр) жилийн орлого, зарлага болон дараагийн 3 (гурав) жилийн төсвийн таамаглал

b. Сүүлийн 2 (хоёр) жилийн дотоодын өрийн хэмжээ.

7.6.8. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь Хавсралт 26-д заасан албан мэдэгдэл эсхүл үнэт цаасны танилцуулга бэлтгэж болно.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 4 сарын 13-ны өдрийн 07/22 тоот тогтоолоор нэмсэн/

7.6.9. Аймаг, нийслэлийн Засаг дарга Үнэт цаасны танилцуулга бэлтгэх тохиолдолд энэ журмын Хавсралт 20-ийн 2, 4-6, 8, 10-11, 14, 17-52, 56-59-д заасан мэдээллийг Биржид ирүүлэхгүй байж болно. Эдгээр заалтаас гадна Бирж тохиромжтой гэж үзвэл тодорхой мэдээллийг ирүүлэх шаардлагаас чөлөөлж болно.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 4 сарын 13-ны өдрийн 07/22 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

7.6.10. Аймаг, нийслэлийн Засаг дарга тодорхой заалтаас чөлөөлөгдөх хүсэлтэй бол Биржтэй нэн даруй зөвлөлдөнө. Энэ журмын Хавсралт 20-д заасан мэдээллийн зарим нь аймаг, нийслэлийн үйл ажиллагаатай хамааралгүй тохиолдолд тухайн мэдээлэлтэй адилтгах мэдээллийг ирүүлэхийг Бирж шаардаж болно.

7.6.11. Аймаг, нийслэлийн Засаг даргын гаргаж буй үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгохоос өмнө Засаг дарга эсвэл андеррайтерийн компанитай хамтран ажиллах гэрээ байгуулсан тохиолдолд андеррайтер нь стратегийн болон мэргэжлийн хөрөнгө оруулагчдад үнэт цаасны талаар танилцуулж, санал болгож болно.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 4 сарын 13-ны өдрийн 07/22 тоот тогтоолоор нэмсэн/

7.6.12. Аймаг, нийслэлийн Засаг дарга татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт болон эргэн төлөлтийн улирлын тайланг энэ журмын 8 дугаар бүлэгт заасны дагуу дараа сарын 10-ны өдрийн дотор Бирж болон олон нийтэд мэдээлнэ.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 4 сарын 13-ны өдрийн 07/22 тоот тогтоолоор нэмсэн/

7.6.13. Бирж аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгслийг бүртгэхтэй холбоотой хяналтын үйл ажиллагааг ажлын 15 өдрийн дотор гүйцэтгэх ба өрийн хэрэгслийг бүртгэсэн шийдвэр гарсанаас хойш ажлын 2 өдрийн дотор бүртгэлийн баримт бичгийн эцсийн төслийн хамт Хороонд хүргүүлнэ.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 4 сарын 13-ны өдрийн 07/22 тоот тогтоолоор нэмсэн/

НАЙМ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТОГТМОЛ ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

8.1. Ерөнхий зүйл

8.1.1. Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор Монгол Улс дахь мэдээллийн ил тод байдлыг хангуулах чиглэлээр холбогдох нарийвчилсан зохицуулалт болон Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд Үнэт цаас гаргагчид тавигдах тогтмол хүлээх үүргийн нэмэлт заалтуудыг Бирж Бүртгэлийн гэрээнд тусгана.

8.1.2. Үнэт цаас гаргагч нь Бүртгэлийн гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу Үнэт цаас гаргагчийн тогтмол хүлээх үүргийн хэрэгжилтийг тогтмол хангаж ажиллах бөгөөд энэ журам болон Бүртгэлийн гэрээнд заасан мэдээллийг тогтмол Биржид ирүүлнэ.

8.1.3. Үнэт цаас гаргагч болон баталгаат үнэт цаас гаргах тохиолдолд баталгаа гаргагч нь цаашид тогтмол хүлээх үүргийг хүлээн зөвшөөрч Биржээс гаргасан загварын дагуу Бүртгэлийн гэрээ байгуулна. Энэхүү тогтмол хүлээх үүргүүд нь үнэт цаас эзэмшигчдийг шаардлагатай мэдээллээр бүрэн хангахад чиглэгдэнэ.

8.1.4. Биржээс шаардлагатай тохиолдолд Үнэт цаас гаргагчийг нийтэд нэмэлт мэдээлэл хүргэхийг шаардаж болно. Бирж Үнэт цаас гаргагчид нэмэлт шаардлага тавихаас өмнө тайлбар хийх боломжийг олгоно. Үнэт цаас гаргагч нь нэмэлт шаардлагыг биелүүлж чадаагүй тохиолдолд Бирж энэ тухай мэдээллийг нийтэд ил болгоно.

8.2. Мэдээлэл ирүүлэх

8.2.1. Бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь дараах мэдээллийг ажлын 2 (хоёр) өдөрт багтаан эсвэл Биржээс тогтоосон хугацаанд, эсвэл нөхцөл байдлаас хамааран үүнээс бага хугацаанд нэн даруй Биржид хүргүүлнэ. Үүнд:

8.2.1.1. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээдийн мэдээлэлд өөрчлөлт орсон бол тэр тухай мэдээ, мэдэгдэл

8.2.1.2. Биржээс хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах буюу зах зээлийн хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай гэж үзсэн бүх төрлийн мэдээлэл

8.2.1.3. Бүртгэлийн журмыг зөрчсөн байж болзошгүй үйлдлийг шалгах болон тус журмыг дагаж мөрдүүлэх зорилгоор Биржээс шаардсан бусад мэдээлэл, тайлбар

8.2.1.4. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль Хорооны холбогдох журамд тухай бүр мэдээлэх, тогтмол тайлагнахаар заасан бусад мэдээлэл.

8.2.2. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх гаргагч нь дараах мэдээллийг нэн даруй Биржид хүргүүлнэ. Үүнд:

8.2.2.1. Хамтын биржээр арилжаалагддаг сангийн хувьд хоёрдогч зах зээлд сангийн нэгж эрх шинээр үүсгэх, буцаан худалдахад солилцох санхүүгийн хэрэгслийн нэр, тоо хэмжээ

8.2.2.2. Сангийн нөлөө бүхий болон эрх бүхий этгээдүүд өөрчлөгдсөн тухай мэдээлэл

8.2.2.3. Сангийн дүрэм, үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт өөрчлөгдсөн тухай мэдээлэл

8.2.2.4. Мэргэжлийн байгууллагууд өөрчлөгдсөн тохиолдолд тэдгээрийн шалтгаан, мэдээлэл

8.2.2.5. Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлын мэдээлэл, төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын мэдээлэл, хурлаас гарсан шийдвэрүүд

8.2.2.6. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон Хорооны журамд тухай бүр мэдээлэхээр заасан сангийн нэгж эрхтэй холбоотой мэдээлэл.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор нэмсэн/

8.2.3. Бирж энэ журмын 8.2.1-т заасан үнэт цаас гаргагчийн ирүүлсэн мэдээллийг тухай бүр олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

8.3. Мэдээлэл, баримт бичиг хүргүүлэх

8.3.1. Бирж шаардлагатай гэж үзвэл энэ журмаар Биржид ирүүлэхээр заасан баримт бичгийг түүнд зааснаас олон, эсхүл цөөн хувиар ирүүлэхийг Үнэт цаас гаргагчаас шаардаж болно.

8.3.2. Бирж шинээр өргөдөл гаргагч, эсхүл бүртгэлтэй Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээллийг дор дурдсан зорилгоор өөрийн цахим хуудаст байрлуулах буюу бусад хэлбэрээр нийтэлж болно. Үүнд:

8.3.2.1. Тухайн мэдээлэлтэй саадгүй танилцах боломжийг олон нийтэд олгох

8.3.2.2. Биржийн үйл ажиллагааг сурталчлах

8.3.2.3. Бүртгэлтэй Үнэт цаас гаргагч болон шинээр өргөдөл гаргагчийн нэгдсэн статистик мэдээллийг гаргах

8.3.2.4. Хөрөнгө оруулагчдад мэдлэг олгох

8.3.2.5. Зах зээлийн нэр хүнд, нэгдмэл байдлыг хадгалах

Хувьцаа эзэмшигчийн нэр Регистрийн дугаар Гэрийн хаяг Үнэт цаас гаргагч эсхүл толгой компанийн хувьцааг эзэмшиж байгаа эсэх Эзэмшлийн хувь хэмжээ	_____ _____ _____ _____ _____ _____

ТАВ. НЭМЭЛТ МЭДЭЭЛЛҮҮД

1. Сүүлийн 3 жилийн орлого, ашгийн мэдээлэл

	Орлого (мянган төгрөг)	Ашиг (мянган төгрөг)
_____ он		
_____ он		
_____ он		

2. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөөний талаарх мэдээлэл

3. Үнэт цаас гаргахад мэргэжлийн зөвлөгөө үзүүлсэн шинжээчдийн мэдээлэл

Шинжээчийн нэр Шинжээчийн төрөл (хуульч, аудитор гэх мэт) Шинжээчийн үйлдсэн баримт, огноо	

Шинжээчийн нэр Шинжээчийн төрөл (хуульч, аудитор гэх мэт) Шинжээчийн үйлдсэн баримт, огноо	

1. Бүртгэлийн хураамж _____ төгрөгийг Биржийн _____ банкны _____тоот дансанд урьдчилан төлсөн болно. Бүртгэлийн журамд хураамжийг буцаан олгохоор зааснаас бусад тохиолдолд тус хураамжийг буцаан олгохгүй болохыг хүлээн зөвшөөрч байна.
2. Өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргав.

   (1) _____

   (2) _____

   (3) _____

Үнэт цаас гаргагчийг төлөөлж өргөдөл гаргасан:

Албан тушаал:	
Овог нэр:	
Гарын үсэг:	

АНДЕРРАЙТЕРИЙН ҮҮРГИЙН БОЛОН ХАРААТ БУС БАЙДЛЫН МЭДҮҮЛЭГ

Хэнд:	“УЛААНБААТАР ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ” ХК-Д
Огноо:	
Андеррайтерийн бүтэн нэр:	

Манай байгууллага нь _____ *(үнэт цаас гаргагчийн нэр)*-д гэрээний үндсэн дээр андеррайтерийн үйлчилгээ үзүүлж байгаа ба Бүртгэлийн журмын 2.4.6.6-д заасны дагуу дараах үүргийн болон хараат бус байдлын мэдүүлгийг гаргаж байна.

(1) Бид хууль тогтоомж, гэрээний дагуу андеррайтерийн үүргээ хууль тогтоомжийн хүрээнд, бусдын нөлөөнд авталгүй, хариуцлагатай гүйцэтгэхээ баталж байна. Тухайлбал:

(i) Үнэт цаасыг бүртгүүлэхтэй холбоотойгоор Хороо болон Биржид зөвхөн үнэн зөв, бүрэн бодитой, төөрөгдөлд оруулахааргүй мэдээлэл, баримт бичгийг хүргүүлнэ. Хэрэв тус мэдээлэл, баримт бичгийн үнэн, зөв, бүрэн бодит байдалд эргэлзээ төрүүлэхүйц нөхцөл байдал үүссэн тохиолдолд энэ тухай Бирж болон Хороонд ажлын 3 хоногийн дотор мэдэгдэнэ.

(ii) Үнэт цаасыг бүртгүүлэх ажиллагааг хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд явуулах ба тэдгээр хууль тогтоомж, дүрэм журмыг зөрчвөл зохих хариуцлагыг бүрэн хүлээнэ.

(iii) Биржийн тавьсан асуултад хурдан шуурхай, үнэн зөв, нээлттэй хариу өгөх, Биржээс зохион байгуулах хурал, уулзалтад оролцох зэргээр Бирж болон Хорооноос хийх хяналт, шалгалттай холбоотой үйл ажиллагаанд идэвхтэй, хариуцлагатай оролцоно.

(iv) Бирж үнэт цаасыг бүртгэх шийдвэр гарахаас өмнө андеррайтерийн үүрэг дуусгавар болсон тохиолдолд энэ талаар болон үүрэг дуусгавар болсон шалтгааныг Биржид ажлын 3 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

(2) Бүртгэлийн журамд заасны дагуу андеррайтер нь үнэт цаас гаргагчаас хараат эсэхээ дараах байдлаар тодорхойлж байна *(өөрт тохирох хэсгийг дугуйлна уу):*

(i) Хараат бус

(ii) Хараат

[хэрэв хараат бол шалтгааныг дор бичнэ үү]

_____
_____
_____
_____

(3) Үнэт цаасыг бүртгүүлэх явцад үнэт цаас гаргагч хууль тогтоомж, дүрэм журмыг ноцтой зөрчсөнийг андеррайтер олж мэдсэн, андеррайтерийн хараат бус байдалд өөрчлөлт орсон тохиолдолд Биржид нэн даруй бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

Албан тушаал:	
Овог нэр:	
Гарын үсэг:	

АНДЕРРАЙТЕРИЙН МЭДЭГДЭЛ

Хэнд: “УЛААНБААТАР ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ” ХК-Д

Огноо:

Андеррайтерийн бүтэн нэр:

Манай байгууллага нь _____ *(үнэт цаас гаргагчийн нэр)*-д гэрээний үндсэн дээр андеррайтерийн үйлчилгээ үзүүлж байгаа ба Бүртгэлийн журмын 6.2.1.2-т заасны дагуу дараах мэдэгдлийг гаргаж байна:

(1) Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Бүртгэлийн журам болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан үнэт цаасыг бүртгүүлэхэд шаардлагатай бүх баримт бичгийг өргөдлийн хамт Биржид хүргүүлсэн болно (Биржээс чөлөөлөхийг зөвшөөрсөн баримт бичиг үүнд хамаарахгүй).

(2) Бид үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл гаргахтай холбоотой зохих судалгаа шинжилгээг үндэслэлтэй, бүрэн гүйцэд хийсний үндсэн дээр дараах баталгааг гаргаж байна:

(a) Үнэт цаас гаргагч нь Бүртгэлийн журамд заасан шаардлагыг бүрэн хангасан болно (Биржээс чөлөөлөхийг зөвшөөрсөн шаардлага үүнд хамаарахгүй).

(b) Үнэт цаас гаргагч нь өөрийн үйл ажиллагаа, хөрөнгө, өр төлбөр, санхүүгийн байдал, удирдлага, ашиг, алдагдал зэрэг хөрөнгө оруулагчид дүгнэлт хийж, шийдвэр гаргахад шаардлагатай бүх мэдээлэл, баримт бичгийг бүртгэлийн баримт бичигт оруулсан болно.

(c) Бүртгэлийн баримт бичигт заасан мэдээлэл нь үнэн зөв, бүрэн бөгөөд төөрөгдөлд оруулсан эсвэл худал мэдээлэл агуулаагүй болно.

(d) Үнэт цаас гаргагчийн ТУЗ болон эрх бүхий албан тушаалтнуудын хууль тогтоомжид заасан үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай нөхцөлийг үнэт цаас гаргагч бүрдүүлсэн болно.

(e) Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын санхүүгийн байдал, үйл ажиллагааны хэтийн төлөвийг бодитоор тооцоолох боломжийг хангахуйц үйл ажиллагааны болон хяналтын тогтолцоо (нягтлан бодох бүртгэлийн болон менежментийн тогтолцоо хамаарна)-г үнэт цаас гаргагч бүрдүүлсэн болно.

(f) Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд нь үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагааг удирдан хэрэгжүүлж ажиллах зохих туршлага, мэдлэг, ур чадвартай бөгөөд Бүртгэлийн журамд заасан шаардлага (Биржээс чөлөөлөхийг зөвшөөрсөн шаардлага үүнд хамаарахгүй)-ыг бүрэн хангасан болно. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд нь Бүртгэлийн журам, бусад холбогдох хууль тогтоомжид заасан үүрэг, хариуцлагаа бүрэн ухамсарласан бөгөөд үүргээ хэрэгжүүлэх эрх зүйн чадамжтай.

(3) Бид шинжээчийн дүгнэлтэд тусгагдсан мэдээлэл нь бүрэн бус, худал, төөрөгдүүлсэн, эсхүл ач холбогдолтой мэдээлэл, үйл баримтыг орхигдуулсан гэж үзэх бодитой үндэслэл илрүүлээгүй бөгөөд ийм үндэслэл илэрвэл Биржид нэн даруй мэдэгдэнэ.

(4) Шинжээчид нь үнэт цаас гаргагч болон түүний эрх бүхий албан тушаалтнуудаас хараат бус болно.

Албан тушаал:	
Овог нэр:	
Гарын үсэг:	

АНДЕРРАЙТЕРИЙН БАТАЛГАА

Хэнд:	“УЛААНБААТАР ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ” ХК-Д
Огноо:	
Андеррайтерийн бүтэн нэр:	

Манай байгууллага нь _____ *(үнэт цаас гаргагчийн нэр)*-д гэрээний үндсэн дээр андеррайтерийн үйлчилгээ үзүүлж байгаа ба гаргаж буй үнэт цаасыг Биржид бүртгүүлэхтэй холбоотойгоор дараах баталгааг гаргаж байна:

(1) Үнэт цаасыг 50 (тавь)-аас дээш тооны этгээдэд санал болгоно.

(2) Үнэт цаас гаргагчийг бүртгэх үед Бүртгэлийн журмын 7.2.21.1 дахь заалтын дагуу үнэт цаас гаргагчийн нийт гаргасан үнэт цаасны 25 (хорин тав)-аас доошгүй хувийг олон нийтэд эзэмшүүлэх арга хэмжээг авна.

(3) Бүртгэлийн журмын 11.2 дугаар зүйлд заасны дагуу Үнэт цаас гаргагч, түүний ТУЗ-ийн гишүүн болон одоогийн хувьцаа эзэмшигчдийн үнэт цаас захиалах, худалдах, худалдан авахад тавих хязгаарлалтын нөхцөлийг бүрэн хангана.

(4) Үнэт цаасыг Биржид бүртгүүлэхтэй холбоотой Бүртгэлийн журамд заасан бүхий л урьдчилсан нөхцөлийг хангасан болно.

Албан тушаал:	
Овог нэр:	
Гарын үсэг:	

АНДЕРРАЙТЕРИЙН МЭДҮҮЛЭГ

_____ (албан ёсны хаяг) хаягт байрлалтай _____ (андеррайтерийн нэр) нь _____-ны өдөр үнэт цаас гаргагчтай _____ тоот андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан.

Бид _____ (мэдэгдэл, амлалт гаргасан эрх бүхий албан тушаалтны нэр)-ийн гаргасан мэдэгдэл, амлалттай бүрэн танилцсан бөгөөд мэдэгдэлд заасан мэдээлэл нь үнэн зөв, бүрэн гүйцэд болохыг үүгээр баталгаажуулж байна.

Албан тушаал:	
Овог нэр:	
Гарын үсэг:	

ХУУЛЬЧИЙН МЭДҮҮЛЭГ

_____ (албан ёсны хаяг) хаягт байрлалтай _____ (хуулийн дүгнэлт гаргасан аж ахуйн нэгжийн нэр) нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үнэт цаас гаргагчид хууль зүйн зөвлөгөө өгөх эрх бүхий этгээд мөн болно.

Бид энэхүү Маягтад заасан мэдээлэл, баримт бичигт тавигдах шаардлага, түүнийг бөглөх, бүрдүүлэх заавар болон эдгээр мэдээлэл, бичиг баримтыг Биржид худал мэдүүлснээс үүсэх үр дагаврыг _____ (мэдэгдэл, амлалт гаргасан эрх бүхий албан тушаалтны нэр)-д бүрэн тайлбарлаж ойлгуулсан болно. _____ (мэдэгдэл, амлалт гаргасан эрх бүхий албан тушаалтны нэр) нь бидний өгсөн зөвлөгөөг ойлгосон болохыг бид үүгээр баталгаажуулж байна.

Албан тушаал:	
Овог нэр:	
Гарын үсэг:	

АУДИТОРЫН МЭДҮҮЛЭГ

_____ (албан ёсны хаяг) хаягт байрлалтай _____ (аудитын дүгнэлт гаргасан аж ахуйн нэгжийн нэр) нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үнэт цаас гаргагчид аудитын үйлчилгээ үзүүлэх эрх бүхий этгээд мөн болно.

Бид энэхүү Маягтад заасан мэдээлэл, баримт бичигт тавигдах шаардлага, түүнийг бөглөх, бүрдүүлэх заавар болон эдгээр мэдээлэл, бичиг баримтыг Биржид худал мэдүүлснээс үүсэх үр дагаврыг _____ (мэдэгдэл, амлалт гаргасан эрх бүхий албан тушаалтны нэр)-д бүрэн тайлбарлаж ойлгуулсан болно. _____ (мэдэгдэл, амлалт гаргасан эрх бүхий албан тушаалтны нэр) нь бидний өгсөн зөвлөгөөг ойлгосон болохыг бид үүгээр баталгаажуулж байна.

Албан тушаал:	
Овог нэр:	
Гарын үсэг:	

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭЧНИЙ МЭДҮҮЛЭГ

_____ (албан ёсны хаяг) хаягт байрлалтай _____ (хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний дүгнэлт гаргасан аж ахуйн нэгжийн нэр) нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үнэт цаас гаргагчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх эрх бүхий этгээд мөн болно.

Бид энэхүү Маягтад заасан мэдээлэл, баримт бичигт тавигдах шаардлага, түүнийг бөглөх, бүрдүүлэх заавар болон эдгээр мэдээлэл, бичиг баримтыг Биржид худал мэдүүлснээс үүсэх үр дагаврыг _____ (мэдэгдэл, амлалт гаргасан эрх бүхий албан тушаалтны нэр)-д бүрэн тайлбарлаж ойлгуулсан болно. _____ (мэдэгдэл, амлалт гаргасан эрх бүхий албан тушаалтны нэр) нь бидний өгсөн зөвлөгөөг ойлгосон болохыг бид үүгээр баталгаажуулж байна.

Албан тушаал:	
Овог нэр:	
Гарын үсэг:	

НИЙЦҮҮЛЭГЧИЙН ҮҮРГИЙН БАТАЛГАА

Хэнд:	“УЛААНБААТАР ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ” ХК-Д
Огноо:	
Нийцүүлэгчийн бүтэн нэр:	

Манай байгууллага нь _____ *(үнэт цаас гаргагчийн нэр)*-д гэрээний үндсэн дээр нийцүүлэгчийн үйлчилгээ үзүүлж байгаа ба Бүртгэлийн журмын 5.2.43-т заасны дагуу дараах үүргийн баталгааг гаргаж байна:

(1) Нийцүүлэгчийн үйл ажиллагаагаа Бүртгэлийн журам болон Биржийн тогтоосон шаардлагад нийцүүлэн явуулна.

(2) Биржийн тавьсан асуултад хурдан шуурхай, үнэн зөв, нээлттэй хариу өгөх, шаардсан бичиг баримтыг үнэн зөв, бүрэн гүйцэд (эх хувиар нь, эсхүл хуулбараар), цаг алдалгүй гаргаж өгөх, холбогдох хурал, зөвлөгөөнд оролцох зэргээр Биржээс хэрэгжүүлж байгаа хянан шалгах ажиллагаанд цаг тухайд нь туслалцаа үзүүлнэ.

(3) Бүртгэлтэй үнэт цаас гаргагчид өгсөн зөвлөмж, зааварчилгаа болон Биржид ирүүлсэн мэдэгдэл, баримт бичиг, мэдээллийн үнэн зөв, бүрэн гүйцэд байдлыг бүрэн хариуцна.

(4) Бүртгэлийн журам болон холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг зөрчсөн бол хариуцлагаа бүрэн хүлээнэ.

Албан тушаал:	
Овог нэр:	
Гарын үсэг:	

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН АМЛАЛТ

Хэнд: “УЛААНБААТАР ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ” ХК-Д

Огноо:

Үнэт цаас гаргагч _____ (үнэт цаас гаргагчийн нэр) нь дараах амлалтыг гаргаж байна. Үүнд:

(1) Үнэт цаас гаргагч нь Биржид бүртгэлтэй байх хугацаандаа Бүртгэлийн журмыг дагаж мөрдөнө.

(2) Бүртгэлийн хороо өргөдлийг хэлэлцэхээс өмнө бүртгэлийн баримт бичигт өөрчлөлт орсон, эсхүл бүртгэлийн баримт бичгийн төсөлд буруу, ташаа мэдээлэл орсон бол энэ тухай Биржид нэн даруй мэдэгдэнэ.

(3) Биржийн Бүртгэлийн журмын Хавсралт 14-т Бүртгэлийн журамд заасан хугацаанд Биржид ирүүлнэ.

(4) Биржийн Бүртгэлийн журмын Хавсралт 15, 16-д заасан эрх бүхий албан тушаалтнуудын мэдэгдэл, амлалтыг Бүртгэлийн журамд заасан хугацаанд хүн тус бүрээр гаргаж Биржид ирүүлнэ.

(5) Мэдээлэл, баримт бичигт тавигдах шаардлага түүнийг нийтлэхтэй холбоотой Биржээс гаргасан журмыг дагаж мөрдөнө.

Албан тушаал:

Овог нэр:

Гарын үсэг:

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БАТАЛГАА

Хэнд: “УЛААНБААТАР ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ” ХК-Д

Огноо:

Баталгаа гаргагчийн нэр:

_____ (үнэт цаас гаргагчийн нэр)-ийн Гүйцэтгэх захирал _____ би дараах баталгааг гаргаж байна:

(1) Үнэт цаас гаргагч нь бүртгэлийн баримт бичгийг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хорооны холбогдох журам, Бүртгэлийн журам болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд заасан шаардлагад нийцүүлэн гаргасан болно.

(2) Үнэт цаас гаргагч болон түүний гаргаж буй үнэт цаас нь Бүртгэлийн журамд заасан шаардлагыг бүрэн хангасан болно.

(3) Биржийн хянасан бүртгэлийн баримт бичигт ямар нэгэн өөрчлөлт ороогүй бөгөөд цаашид үнэт цаас гаргагчийн зүгээс үнэт цаасны үнэ, тоо ширхэг, тооцооллын алдааг залруулахаас өөр нэмэлт өөрчлөлт оруулахгүй эцсийн хувилбарыг ирүүлсэн.

(4) Үнэт цаасыг бүртгэх болон түүнийг арилжихад шаардлагатай бүх нөхцөл бүрэн хангагдсан.

Албан тушаал:

Овог нэр:

Гарын үсэг:

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ МЭДЭГДЭЛ

Ерөнхий мэдээлэл

Овог: _____
Нэр: _____
Регистрийн дугаар: _____
Хүйс: □ эрэгтэй □ эмэгтэй
Үндэс угсаа: _____
Иргэний харьяалал: _____

Одоо эрхэлж буй ажил, албан тушаалын мэдээлэл

Албан тушаал	
Ажилласан жил	
Ажлын байрны чиг үүргийн талаар товч	

Ажлын туршлага

Компанийн нэр	Албан тушаал	Ажилласан жил	Ажлаас гарсан шалтгаан

Боловсрол

Төгссөн сургууль	Хаана	Мэргэжил	Хугацаа

Хувьцаа

Үнэт цаас гаргагчийн хувьцааг шууд болон шууд бусаар эзэмшдэг эсэх

Шаардлагатай үед холбоо барих

Овог нэр	Таны хэн болох	Байгууллага, албан тушаал	И-мэйл	Утас

Холбоо барих

И-мэйл хаяг: _____
Гар утас, ажлын утас: _____ _____
Гэрийн хаяг: _____

Дээрх мэдээлэл болон Бүртгэлийн баримт бичигт орсон миний намтар үнэн зөв болохыг үүгээр баталж байна.

Албан тушаал:

Овог нэр:

Гарын үсэг:

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ АМЛАЛТ

Хэнд: “УЛААНБААТАР ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ” ХК-Д

Огноо:

(1) Би _____ (үнэт цаас гаргагчийн нэр)-ийн _____ (албан тушаалын нэр)-н чиг үүрэг, бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтлан ажиллахаа амлаж байна:

(a) Бүртгэлийн журам, холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд заасан үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтанд тавигдах шаардлагыг цаг үргэлж хангах,

(b) Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг Бүртгэлийн журам, холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэх,

(c) Намайг түр хугацаагаар орлон ажиллаж буй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих, хамтын хариуцлага хүлээх.

(2) Би өөрийн албан тушаалын чиг үүрэг, бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ хууль тогтоомж, Бүртгэлийн журмыг мөрдлөг болгож ажиллана. Би өөрийн албан тушаалын байдлыг ашиглаж аливаа хууль бус үйлдэл хийхгүй гэдгээ амлаж байна. Би өөрийн хувийн ашиг сонирхлыг компанийн үйл ажиллагаанаас ангид байлгах ба ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд нэн даруй холбогдох этгээдэд мэдэгдэх үүргээ хүлээн зөвшөөрч, бүрэн ухамсарлаж байна.

(3) Би дараах мэдээлэл, баримт бичгүүдийг Биржийн тогтоосон хугацаанд Биржид хүргүүлэхээ амлаж байна.

i. Зах зээлийн зохистой үйл ажиллагааг хангах, хөрөнгө оруулагчдын ашиг сонирхлыг хамгаалахад шаардлагатай гэж Биржийн үзсэн бүх төрлийн мэдээлэл, баримт бичиг,

ii. Бүртгэлийн журмыг хэрэгжүүлэх зорилгоор Биржээс шаардсан бүх төрлийн мэдээлэл, баримт бичиг болон тэдгээртэй холбоотой тайлбар Биржийн Бүртгэлийн алба, Бүртгэлийн хороо болон Хорооноос хяналт, шалгалт хийх тохиолдолд тэдгээрийн тавьсан асуулт, хүсэлтэд хурдан шуурхай, үнэн зөв, хариу өгөх, хурал зөвлөгөөнд оролцох, холбогдох баримт бичгийг гаргаж өгөх зэргээр хамтран ажиллана.

(4) Арилжаа эхлэхээс өмнө үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтны Биржид ирүүлсэн мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд энэ тухай Биржид нэн даруй мэдэгдэхээ амлаж байна.

(5) Биржээс надад хаягласан бүх төрлийн мэдэгдэл, баримт бичгийг миний нэрийн өмнөөс үнэт цаас гаргагч хүлээн авахад татгалзах зүйлгүй гэдгээ үүгээр баталж байна.

(6) Намайг үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байх хугацаанд миний Биржтэй харилцах хаягт өөрчлөлт орсон тохиолдолд 14 хоногийн дотор Бүртгэлийн албанд бичгээр мэдэгдэнэ. Биржээс бүх төрлийн баримт бичиг, мэдэгдлийг миний Биржид өгсөн хаяг, эсхүл үнэт цаас гаргагчийн хаягийн дагуу шууданд хийсэн, эсхүл факсаар илгээснээр тухайн баримт бичиг, мэдэгдлийг би хүлээн авсанд тооцохоо үүгээр хүлээн зөвшөөрч байна. Мөн Биржтэй харилцах хаягийн өөрчлөлтөө энд заасан журмын дагуу Биржид мэдэгдээгүйгээс үүдэн Биржээс надад хариуцлага ногдуулахыг хүлээн зөвшөөрч байна.

(7) Дээр дурдсан миний өгсөн мэдэгдэл, амлалт нь нууц материал биш бөгөөд Бүртгэлийн албаны зүгээс шаардлагатай хүмүүст танилцуулахад татгалзах зүйлгүй болно.

(8) _____ (амлалт гаргагчийн нэр) би энэ маягтад заасан мэдэгдэл, амлалт нь үнэн зөв, бүрэн гүйцэд гэдгийг үүгээр баталж байгаа ба эдгээр мэдэгдэл, амлалт худал байх тохиолдолд хариуцлага хүлээхэд татгалзах зүйлгүй болно. Мэдээлэл орхигдуулсан, худал амлалт өгсөнтэй холбогдуулан Бирж намайг тохиромжтой бус этгээд гэж үзэх буюу албан тушаалаас чөлөөлүүлэх шаардлагыг гаргахад татгалзах зүйлгүй болохоо үүгээр мэдэгдэж байна.

Албан тушаал:

Овог нэр:

Гарын үсэг:

ҮНЭТ ЦААС НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХ ТУХАЙ ЗАРЛАЛЫН ЗАГВАР

[.....] хуульд заасны дагуу [.....] улсад үүсгэн байгуулагдсан [.....] компани нь дараах үнэт цаасыг шинээр гаргаж нийтэд танилцуулж байна.

Нэгж үнэ: [.....] төгрөг

Нийтэд санал болгож байгаа үнэт цаасны хэмжээ: [.....] ширхэг

Үнэт цаасны төрөл: [.....]

Бүртгэлийн баримт бичгийн хуулбарыг өргөдлийн хамт ажлын цагаар дараах хуулийн этгээдээс авах боломжтой. Үүнд:

(1) _____

Хаяг: _____

Утас: _____

(2) _____

Хаяг: _____

Утас: _____

Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага:

(1) _____

(2) _____

Үнэт цаасны арилжааг [*он/сар/өдөр*] эхлүүлэхээр төлөвлөөд байна.

20.. оны .. сарын .. өдөр

[*А Компани*]

Жич: Энэхүү зарлал нь зөвхөн мэдээлэл өгөх зорилготой бөгөөд үнэт цаасыг худалдах, захиалга авах санал, саналын дуудлага биш болно.

ҮНЭТ ЦААС НЭМЖ ГАРГАХАД НИЙТЭД МЭДЭЭЛЭХ МЭДЭЭЛЛИЙН АГУУЛГА

Үнэт цаас нэмж гаргахад Компани дараах мэдээллийг нийтэд мэдээлэх үүрэг хүлээнэ. Үүнд:

(1) Компанийн нэр, түүний үүсгэн байгуулагдсан буюу үйл ажиллагаа явуулдаг улсын нэр;

(2) Гаргахаар зөвшөөрсөн үнэт цаасны тоо ширхэг, төрөл болон нийт нэрлэсэн үнэ;

(3) Татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, түүний ашиглалтын төлөвлөгөө;

(4) Үнэт цаасны үнэ болон үнэ тогтоох аргачлал;

(5) Үнэт цаас гаргах үндэслэл;

(6) Хувьцаа эзэмшигчдийн тухай ерөнхий мэдээлэл;

(7) Үнэт цаас гаргах тухай шийдвэр гарсан өдрийн хаалтын ханш;

(8) Үнэт цаас гаргах тухай нийтэд мэдээлэхээс өмнөх 12 сарын хугацаанд үнэт цаас гаргагчийн татан төвлөрүүлсэн хөрөнгө, тухайн хөрөнгийн ашиглалт, шаардлагатай гэж үзвэл нэмэлт тайлбарууд;

(9) Бирж шаардсан тохиолдолд андеррайтертай хийсэн гэрээний нөхцөл;

(10) Үнэт цаас гаргах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр;

(11) Андеррайтер/Номинал эзэмшигч өөрт хуваарилагдсан үнэт цаасыг худалдах, эсхүл одоогийн хувьцаа эзэмшигчдэд тавигдах хязгаарлалт зэрэг үнэт цаас гаргахтай холбоотой бусад мэдээлэл.

БҮРТГЭЛИЙН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА (Шинээр үнэт цаас бүртгүүлэх)

Үнэт цаас гаргагч, түүний зөвлөхүүд болон бүртгэлийн баримт бичгийн талаарх ерөнхий мэдээлэл

1. Үнэт цаас гаргагчийн бүтэн нэр.

2. Доорх мэдэгдэл:

   “Энэхүү үнэт цаасны бүртгэлийн баримт бичиг нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журам, Биржийн Бүртгэлийн журамд заасан үнэт цаасыг олон нийтэд санал болгохтой холбоотой бүх шаардлагатай мэдээллийг агуулсан болно. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд нь энэ баримт бичигт агуулсан мэдээлэл, хавсаргасан баримт бичиг нь үнэн зөв, бүрэн бөгөөд хуурамчаар бүрдүүлсэн ямар нэгэн баримт бичиг байхгүй гэдгийг албан ёсоор баталж байна. Энд заасан мэдэгдэл нь худал байх тохиолдолд үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд нь дангаар болон хамтын журмаар хариуцлага хүлээхийг хүлээн зөвшөөрч байна”.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

3. Үнэт цаас гаргагчийн гол харилцагч банк, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хуулийн зөвлөхийн нэр, хаяг.

4. Үнэт цаас гаргагчийн аудиторын нэр, хаяг болон түүний мэргэшсэн байдлын талаарх мэдээлэл.

5. Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагдсан улс, бүртгүүлсэн он, сар, өдөр, үүсгэн байгуулсан шийдвэр, бүртгүүлсэн байгууллагын нэр.

6. Гадаад улсад бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн хувьд бүртгүүлсэн байгууллагын хаяг, Монгол Улс дах салбар, төлөөлөгчийн газар болон гүйцэтгэх захирлын оршин суугаа газрын хаяг.

7. Үнэт цаас гаргагчийн дүрэм, хувьцаа эзэмшигчдийн гэрээ болон тэдгээртэй адилтгах бусад бичиг баримтуудад дараах асуудлыг хэрхэн зохицуулсан талаарх товчоон:

   (a) Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам, санал өгөх журам;

   (b) Эрх бүхий албан тушаалтнуудад цалин, урамшуулал, тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт олгохтой холбоотой зохицуулалт;

   (c) Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр авч болох зээлийн хэмжээ, хэрвээ тухайн тогтоосон хэмжээ нь өөрчлөгддөг бол хэрхэн яаж өөрчлөгддөг талаар;

(d) ТУЗ-ийн гишүүдийн насны хязгаар, тэтгэвэрт гарах нөхцөл;

(e) ТУЗ-д нэр дэвшүүлэх хувьцаа эзэмшигчийн эрх;

(f) Компанийн өөрийн хөрөнгийг өөрчлөх нөхцөл;

(g) Ногдол ашиг хуваарилах нөхцөл;

(h) Хувьцааг шилжүүлэх нөхцөл, түүнд тавигдаж буй хязгаарлалт;

(i) Үнэт цаас гаргагчийн хувьцааг эзэмшихэд тавигдаж буй хязгаарлалт.

8. Хэрвээ зуучлагч байгаа бол зуучлагч болон түүнд олгох төлбөр, шагнал, урамшууллын талаарх мэдээлэл.

9. Бүртгэлийн баримт бичигт шинжээч (нягтлан бодогч, инженер, үнэлгээчин, хуульч гэх мэт үнэт цаас гаргагчид мэргэжлийн зөвлөгөө өгч байгаа этгээдүүд)-ийн гаргасан баримт бичиг орсон бол тухайн шинжээчтэй холбоотой дараах мэдээллүүд:

(a) Шинжээчийн мэргэшсэн байдлыг тодорхойлсон мэдээлэл, үнэт цаас гаргагчийн болон түүний хамаарал бүхий компаниудтай шинжээчид хамааралтай эсэх мэдээлэл, тэдгээрийн хувьцааг эзэмшдэг эсэх;

(b) Шинжээчдийн гаргасан холбогдох дүгнэлт (хуулийн дүгнэлт, хөрөнгийн үнэлгээ тэдгээртэй холбоотой санал, захидал гэх мэт)-ийг тэдний нэрийн өмнөөс бүртгэлийн баримт бичигт оруулахад татгалзаагүй талаарх мэдэгдэл;

(c) Шинжээчдийн дүгнэлт гаргасан огноо болон тухайн дүгнэлтийг зөвхөн бүртгэлийн баримт бичигт оруулах зорилгоор гаргасан эсэх талаарх мэдээлэл.

10. Өөр биржид үнэт цаас нь (хувьцаа, өрийн бичиг) бүртгэлтэй, эсхүл бүртгүүлэхээр төлөвлөж байгаа тохиолдолд тухайн биржийн нэр, бүртгэлтэй болон бүртгүүлэхээр төлөвлөж буй үнэт цаасны талаарх мэдээлэл хэрвээ бүртгэлгүй буюу бүртгүүлэхээр төлөвлөөгүй бол энэ тухай мэдэгдэл.

11. Үнэт цаас гаргагчийн хувьцааг гаргах, худалдахтай холбоотойгоор сүүлийн хоёр жилийн хугацаанд үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан, зуучлагч, шинжээчдэд олгосон шагнал, урамшуулал, зуучлалын төлбөр, түүнийг хүлээж авсан этгээдүүдийн талаарх мэдээлэл.

Үнэт цаасны мэдээлэл, тэдгээрийг гаргах болон хуваарилах нөхцөл

12. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасыг Биржид бүртгүүлж арилжаанд оруулахыг хүссэн өргөдлийг Биржид гаргасан тухай мэдэгдэл.

13. Үнэт цаасыг Биржийн тооцооны системээр арилжаанд оруулахад шаардлагатай бүх арга хэмжээг авсан тухай мэдэгдэл.

14. Бүртгүүлэх үнэт цаасны төрөл, хэмжээ, үнэт цаасыг гаргаж байгаа нөхцөл, үнэт цаасанд дагалдах нөхцөл зэрэг үнэт цаасны талаарх мэдээлэл.

15. Үнэт цаасыг гаргах, хуваарилахтай холбоотой дараах мэдээллүүд:

(a) Нийтэд нээлттэй болон хаалттай санал болгож байгаа хувьцааны хэмжээ;

(b) Үнэт цаасны нэрлэсэн болон нийтэд санал болгож буй үнэ;

(c) Үнэт цаасны төлбөрийг хийх арга хэлбэр;

(d) Тэргүүн ээлжид худалдаж авах эрхийг хэрэгжүүлэх, захиалгыг шилжүүлэх журам;

(e) Үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох, захиалга авах хугацаа, газар;

(f) Үнэт цаасыг шилжүүлэх арга, хугацаа;

(g) Андеррайтерийн нэр, хаяг, үнэт цаас гаргагчийн үнэт цаасны анхдагч зах зээлд худалдагдаагүй үлдсэн хэсгийг андеррайтер худалдан авахаар андеррайтерийн гэрээнд заасан эсэх;

(h) Андеррайтер үүргээ гүйцэтгэхэд саад болохуйц андеррайтерийн гэрээний заалт;

(i) Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид болон бусад үнэт цаас эзэмшигчдийн үнэт цаасыг худалдахаар санал болгож байгаа тохиолдолд тухайн үнэт цаас эзэмшигчийн нэр, хаяг, нийт үнэт цаасанд эзлэх хэмжээ гэх мэт мэдээлэл;

(j) Үнэт цаасыг худалдах саналын үр дүн, үнэт цаас хуваарилах үндэслэлийн талаар мэдэгдлийг олон нийтэд мэдээлэхээр төлөвлөсөн хугацаа.

16. Тогтмол хэмжээний ногдол ашиг амлаж байхаар үнэт цаас гаргаж байгаа тохиолдолд тухайн ногдол ашгийг хуваарилахад шаардлагатай орлогыг олох эх үүсвэрийн талаарх мэдээлэл.

17. Үнэт цаас гаргахаас өмнө урьдчилж гарсан эргэн төлөгдөх үүрэг үүсгэсэн бүх төрлийн зардал, өглөгийн мэдээлэл.

18. Арилжаа эхлэх өдөр (хэрвээ мэдэх боломжтой бол).

Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн мэдээлэл

19. Компанийн зарласан болон гаргасан, эсхүл гаргахаар зөвшөөрсөн хувьцааны тоо, төлбөр хийгдсэн хувьцааны тоо, хувьцааны нэрлэсэн үнэ.

20. Компанийн гаргасан хувьцаанд хөрвөх үнэт цаас болон түүний хөрвөх нөхцөлийн талаарх мэдээлэл.

21. Компанийн менежментийг хэрэгжүүлэгч этгээдэд олгохоор шийдвэрлэсэн, амласан хувьцаа, шагнал, опцион болон зарлаагүй ногдол ашгийн талаарх мэдээлэл.

22. Хувьцаа эзэмшигчдийн саналын эрх, тэдгээрийг хэрэгжүүлэх хэлбэр.

23. Бүртгэлийн баримт бичгийг олон нийтэд танилцуулахаас өмнөх хоёр жилийн хугацаанд үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын хувь нийлүүлсэн хөрөнгөнд орсон өөрчлөлтийн мэдээлэл.

24. Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын гаргасан опционы талаарх мэдээлэл.

25. Үнэт цаас гаргагчийн хяналтын багц эзэмшигчдийн мэдээлэл, түүний эзэмшлийн хувь хэмжээ.

Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын үйл ажиллагааны мэдээлэл

26. Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын үйл ажиллагааны мэдээлэлд дараах мэдээлэл хамаарна. Үүнд:

    (a) Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын үйл ажиллагааны чиглэл, тэдгээрийн зах зээлд эзлэх хувь хэмжээ зэрэг бизнесийн үйл ажиллагаатай холбоотой бусад танилцуулга, мэдээлэл. Дээрх компаниудын өмчлөл, эзэмшил, ашиглалтад байдаг хөрөнгийн мэдээлэл;

    (b) Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын гол үйлчлүүлэгч, худалдан авагч болон нийлүүлэгчтэй холбоотой дараах мэдээллүүд:

        i. Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын нийт худалдан авалтад тэргүүлсэн нэг нийлүүлэгчийн нийт худалдан авалтын хэмжээнд эзэлж буй хувь;

        ii. Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын нийт худалдан авалтад айрагдсан таван нийлүүлэгчийн нийт худалдан авалтын хэмжээнд эзэлж буй хувь;

        iii. Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын нийт борлуулалтад тэргүүлсэн нэг худалдан авагчийн нийт борлуулалтын хэмжээнд эзэлж буй хувь;

        iv. Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын нийт борлуулалтад айрагдсан таван худалдан авагчийн нийт борлуулалтын хэмжээнд эзэлж буй хувь;

        v. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд, тэдгээрийн дотно холбоотой этгээд, эсхүл 5 хувиас дээш хувийн хувьцаа эзэмшигчид нь энэ зүйлийн (a) болон (d) хэсэгт нэр дурдагдсан нийлүүлэгч, худалдан авагчтай харилцан хамааралтай эсэх талаарх мэдээлэл.

27. Үнэт цаас гаргагч болон түүний харилцан хамааралтай компаниудын хоорондын хамаарлын талаарх мэдээлэл, эзэмшлийн хувь хэмжээ.

28. Үнэт цаас гаргагч болон түүний харилцан хамааралтай компаниудын нэг жилээс дээш хугацаагаар түрээсээр болон лизингээр авсан, эсхүл түрээслүүлж буй эд хөрөнгийн гэрээний мэдээлэл.

29. Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаанд голлох үүрэгтэй барааны тэмдэг, патент, оюуны болон аж үйлдвэрийн өмчтэй холбоотой зүйлсийн талаарх мэдээлэл.

30. Сүүлийн таван жилийн хугацаанд хийгдсэн томоохон ач холбогдолтой шинэ бүтээгдэхүүний судалгаа, хөгжүүлэлтийн явцын талаарх мэдээлэл.

31. Сүүлийн нэг жилийн хугацаанд үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын санхүүгийн байдалд нөлөөлсөн үйл ажиллагааны түр зогсолтын талаарх мэдээлэл.

32. Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын нийт ажилчдын тоо болон тэдгээрийн тоонд сүүлийн нэг жилийн хугацаанд их хэмжээний өөрчлөлт орсон бол энэ талаарх мэдээлэл.

33. Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын ажилчдад шагнал урамшуулал олгох бодлогын талаарх мэдээлэл.

34. Шинээр үйлдвэр барих зэргээр томоохон хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлж буй, эсхүл хэрэгжүүлэхээр төлөвлөж буй бол уг төслийн талаарх мэдээлэл.

35. Гадаад улсаас Монгол Улсруу хөрөнгө, орлогоо шилжүүлэхэд хязгаарлалт байгаа эсэх.

Үнэт цаас гаргагч болон түүний харилцан хамаарал бүхий компаниудын санхүүгийн мэдээлэл

36. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд ноцтой нөлөөлөхүйц дараах санхүүгийн мэдээллүүд:

    (a) Үнэт цаас гаргагч болон түүний харилцан хамаарал бүхий компаниудын гаргасан өрийн үнэт цаасны хэмжээ;

    (b) Үнэт цаас гаргагч болон түүний харилцан хамаарал бүхий компаниудын өр зээлийн мэдээлэл;

    (c) Үнэт цаас гаргагч болон түүний харилцан хамаарал бүхий компаниудын үл хөдлөх хөрөнгийн зээлийн мэдээ;

    (d) Үнэт цаас гаргагч болон түүний харилцан хамаарал бүхий компаниудын гаргасан баталгаа болон бусад ирээдүйд үүсч болзошгүй өр төлбөрийн хэмжээ;

    (e) Үнэт цаас гаргагч болон түүний харилцан хамаарал бүхий компаниудын хөрвөх чадвар болон санхүүгийн нөөцийн талаарх мэдээлэл;

(f) Үнэт цаас гаргагч болон түүний харилцан хамаарал бүхий компаниудын капиталын бүтцийн талаарх мэдээлэл.

37. Үнэт цаас гаргагч болон түүний харилцан хамаарал бүхий компаниудын сүүлийн гурван жилийн хугацааны орлого болон түүний тооцооллын аргачлалын мэдээлэл.

38. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнуудын цалин урамшуулалтай холбоотой мэдээллүүд. Үүнд:

(a) Сүүлийн гурван жилийн хугацаанд үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнуудад олгосон цалингийн нэгдсэн үзүүлэлтийг;

(b) Сүүлийн гурван жилийн хугацаанд үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнуудад олгосон бүх төрлийн, хөнгөлөлт, урамшуулал, шууд болон шууд бусаар тэдэнд олгосон төлбөр болон эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байгаад ажлаас халагдсан этгээдэд олгосон төлбөрийн мэдээлэл;

(c) Сүүлийн гурван жилийн хугацаанд үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнуудад олгосон тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн даатгалын шимтгэл, даатгал зэрэг мэдээллийн нэгдсэн үзүүлэлт.

39. Сүүлийн гурван жилийн хугацаанд цалин, урамшуулал, хөнгөлөлт, тэтгэвэр, тэтгэмж зэргээр үнэт цаас гаргагчаас авсан орлогоороо айрагдсан таван хүний орлогын мэдээлэл, түүний задаргаа. Эдгээр таван хүний дотор эрх бүхий албан тушаалтнаас өөр этгээд багтсан бол тухайн этгээдийн энэ жагсаалтын 38(1), (2), (3)-т заасан мэдээлэл. Эдгээр айрагдсан таван хүний нэр, бусад хувийн мэдээллийг дурдах шаардлагагүй.

40. Бүртгэлийн баримт бичигт дурдагдаагүй боловч эрсдэлийн хүчин зүйл гэх мэт үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нөлөөлж болох бусад зүйлсийн талаарх мэдээлэл.

41. Энэ журмын 6 дугаар бүлэгт заасан ашгийн таамаглалын мэдээлэл.

42. Санхүүгийн тайланг бэлтгэсэн нягтлан бодогчид болон тэдгээрийн мэргэшсэн байдлын талаарх мэдээлэл.

43. Энэ журмын 6 дугаар бүлэгт заасан ажлын капиталын нөөцийн талаарх мэдээлэл.

44. Үнэт цаас гаргагч болон түүний харилцан хамааралтай компаниудын бүртгэлийн баримт бичиг гаргах өдрийн байдлаар оролцож байгаа, эсхүл оролцож болзошгүй эрүү, иргэн, арбитр, захиргааны хэргийн талаарх мэдээлэл.

Үнэт цаас гаргагчийн менежментийн талаарх мэдээлэл

45. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан, ахлах менежер болон эдгээр албан тушаалд нэр дэвшиж буй этгээдүүдийн намтар, туршлагын талаарх мэдээлэл. Эрх бүхий албан тушаалтнуудын хооронд гэр бүлийн харилцан хамаарал байгаа эсэх.

46. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргын намтар, туршлагын талаарх мэдээлэл.

47. Үнэт цаас гаргагчийн байрлаж буй оффисын эзэмшил, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, түрээсийн гэрээний дагуу эзэмшиж, ашиглаж буй үл хөдлөх хөрөнгөтэй тохиолдолд түрээсийн гэрээний хуулбар, бусад нэмэлт мэдээлэл.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

48. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнуудын үнэт цаас гаргагч компанид эзэмшиж буй бүх төрлийн үнэт цаасны хувь хэмжээний талаарх мэдээлэл.

49. Үнэт цаас гаргагч, түүний хамаарал бүхий компаниуд болон үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнуудын хооронд байгуулсан, эсхүл байгуулахаар төлөвлөсөн үйлчилгээ үзүүлэх, ажил гүйцэтгэх чиглэлийн (хугацаа нь дуусгавар болсон, эсхүл төлбөрийн үүрэг үүсгэхгүйгээр байгуулсан гэрээ үүнд хамаарахгүй) гэрээ хэлцлийн талаарх мэдээлэл.

50. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнуудад олгосон төлбөрийн мэдээллийг сүүлийн нэг жилийн байдлаар.

51. Бүртгэлийн баримт бичгийг бэлтгэж буй санхүүгийн жилд үнэт цаас гаргагч болон түүний харилцан хамаарал бүхий компанийн эрх бүхий албан тушаалтнууд болон түүнд нэр дэвшигчдэд гэрээгээр олгохоор тохиролцсон цалин урамшууллын хэмжээ.

52. Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компанийн хөрөнгийг сүүлийн хоёр жилийн хугацаанд шууд болон шууд бусаар худалдсан, худалдан авсан, түрээсэлсэн, зуучилсан, эсхүл эдгээр үйлдлийг хийхээр төлөвлөсөн үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан болон шинжээчийн мэдээлэл.

Татан төвлөрүүлсэн хөрөнгийг ашиглахтай холбоотой мэдээлэл

53. Үнэт цаас гаргаснаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө.

54. Татан төвлөрүүлсэн хөрөнгөөр үл хөдлөх хөрөнгө худалдаж авахаар төлөвлөсөн бол түүний мэдээлэл.

Уул уурхайн компанийн ирүүлэх нэмэлт баримт

55. Уул уурхайн компанийн хувьд Биржийн тогтоосон журмын дагуу нэмэлт баримт бичгийг ирүүлнэ.

Хөрөнгийн мэдээлэл

56. Энэ журмын 6 дугаар бүлэгт шаардсан хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний мэдээлэл.

Чухал ач холбогдолтой гэрээ болон баримт бичгүүд

57. Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын сүүлийн хоёр жилийн хугацаанд байгуулсан чухал ач холбогдолтой гэрээний мэдээлэл, үндсэн агуулга.

Бусад мэдээлэл

58. Бүртгэлийн журмаас чөлөөлөгдсөн заалтуудын талаарх мэдээлэл.

59. Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаанд хамаарах хууль тогтоомжийн талаарх мэдээлэл.

60. Хөрөнгө оруулагчид шийдвэр гаргахад шаардлагатай бусад мэдээлэл.

61. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хорооны холбогдох журамд заасан бусад мэдээлэл.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

62. Биржийн шаардсан мэдээлэл.

Хавсралт

63. Бүртгэлийн баримт бичигт дараах баримтуудыг хавсаргана:

    (a) Компанийн дүрэм, хувьцаа эзэмшигчдийн гэрээ болон тэдгээртэй адилтгах бусад баримтууд;

    (b) Энэ зүйлийн 51, 59-т нэрлэгдсэн гэрээнүүд;

    (c) Бүртгэлийн баримт бичигт дурдагдсан шинжээчдийн гаргасан бүх төрлийн тайлан, дүгнэлт, албан бичиг, бусад баримтууд;

    (d) Төсөвлөсөн санхүүгийн мэдээлэл;

    (e) Ашгийн таамаглал;

    (f) Сүүлийн гурван жилийн хугацааны үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлангууд, харилцан хамаарал бүхий компаниудын нэгдсэн тайлан болон бусад шаардлагатай санхүүгийн мэдээллүүд;

    (g) Энэ журмын 6 дугаар бүлэгт заасан бусад баримт бичгүүд.

БҮРТГЭЛИЙН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА (Шинээр өрийн хэрэгсэл бүртгүүлэх)

Үнэт цаас гаргагч, түүний зөвлөхүүд болон бүртгэлийн баримт бичгийн талаарх ерөнхий мэдээлэл

1. Үнэт цаас гаргагчийн бүтэн нэр.

2. Доорх мэдэгдэл:

   “Энэхүү үнэт цаасны бүртгэлийн баримт бичиг нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журам, Биржийн Бүртгэлийн журамд заасан үнэт цаасыг олон нийтэд санал болгохтой холбоотой бүх шаардлагатай мэдээллийг агуулсан болно. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд нь энэ баримт бичигт агуулсан мэдээлэл, хавсаргасан баримт бичиг нь үнэн зөв, бүрэн бөгөөд хуурамчаар бүрдүүлсэн ямар нэгэн баримт бичиг байхгүй гэдгийг албан ёсоор баталж байна. Энд заасан мэдэгдэл нь худал байх тохиолдолд үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд нь дангаар болон хамтын журмаар хариуцлага хүлээхийг хүлээн зөвшөөрч байна”.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

3. Үнэт цаас гаргагчийн гол харилцагч банк, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хуулийн зөвлөхийн нэр, хаяг.

4. Үнэт цаас гаргагчийн аудиторын нэр, хаяг болон түүний мэргэшсэн байдлын талаарх мэдээлэл.

5. Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагдсан улс, бүртгүүлсэн он, сар, өдөр, үүсгэн байгуулсан шийдвэр, бүртгүүлсэн байгууллагын нэр.

6. Гадаад улсад бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн хувьд бүртгүүлсэн байгууллагын хаяг, Монгол Улс дах салбар, төлөөлөгчийн газар болон гүйцэтгэх захирлын оршин суугаа газрын хаяг.

7. Бүртгэлийн баримт бичигт хөндлөнгийн шинжээчийн гаргасан дүгнэлт орсон бол тухайн шинжээчтэй холбоотой дараах мэдээллүүд:

   (a) Шинжээчийн мэргэшсэн байдлыг тодорхойлсон мэдээлэл, үнэт цаас гаргагчийн болон түүний хамаарал бүхий компаниудтай шинжээчид хамааралтай эсэх мэдээлэл, тэдгээрийн хувьцааг эзэмшдэг эсэх;

   (b) Шинжээчдийн гаргасан холбогдох дүгнэлт (хуулийн дүгнэлт, хөрөнгийн үнэлгээ тэдгээртэй холбоотой санал, захидал гэх мэт)-ийг тэдний нэрийн өмнөөс бүртгэлийн баримт бичигт оруулахад татгалзаагүй талаарх мэдэгдэл;

(c) Шинжээчдийн дүгнэлт гаргасан огноо болон тухайн дүгнэлтийг зөвхөн бүртгэлийн баримт бичигт оруулах зорилгоор гаргасан талаарх мэдээлэл.

8. Өөр биржид үнэт цаас нь (хувьцаа, өрийн бичиг) бүртгэлтэй, эсхүл бүртгүүлэхээр төлөвлөж байгаа тохиолдолд тухайн биржийн нэр, бүртгэлтэй болон бүртгүүлэхээр төлөвлөж буй үнэт цаасны талаарх мэдээлэл хэрвээ бүртгэлгүй буюу бүртгүүлэхээр төлөвлөөгүй бол энэ тухай мэдэгдэл.

Үнэт цаасны мэдээлэл, тэдгээрийг гаргах болон хуваарилах нөхцөл

9. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасыг Биржид бүртгүүлж арилжаанд оруулахыг хүссэн өргөдлийг Биржид гаргасан тухай мэдэгдэл.

10. Үнэт цаас бүртгүүлэхэд гарах зардлын хэмжээ.

11. Хэрэв мэдэгдэж байгаа бол үнэт цаасыг Бирж дээр гаргах зөвшөөрөл хүчин төгөлдөр үйлчилж эхлэх огноо.

Өрийн хэрэгсэлтэй холбоотой мэдээлэл

12. Үнэт цаас гаргах үйл ажиллагааны төлөвлөгөө болон энэхүү төлөвлөгөө хэрхэн хэрэгжих тухай мэдэгдэл.

13. Дараах агуулга бүхий үнэт цаас гаргахтай холбоотой мэдээллүүд:

(a) Гаргах үнэт цаасны номинал хэмжээ, хэрвээ тогтмол биш үнээр гаргах бол өрийн хэрэгслийн тоо хэмжээ, шинж чанарыг багтаасан мэдэгдэл;

(b) Үнэт цаас эзэмшигчийн эдлэх үндсэн эрхүүд;

(c) Үргэлжлүүлэн гаргахаас бусад тохиолдолд гаргах болон буцаан төлөх үнэ, үндсэн хүүгийн хувь хэмжээ, хөвөгч хүүтэй өрийн хэрэгсэл гаргах тохиолдолд түүнийг тооцоолох арга, хямдруулсан өрийн хэрэгсэл гаргах тохиолдолд энэ тухай мэдээлэл, үнэт цаас худалдан авагч үнэт цаас гаргалттай холбоотой аливаа нэмэлт төлбөр төлөх бол энэ тухай мэдээлэл;

(d) Үнэт цаасыг эхэлж гаргах үед болон дараа нь цувралаар гаргах тохиолдолд тэдгээрийн төлбөрийг хэрхэн төлөх тухай дэлгэрэнгүй мэдээлэл;

(e) Үнэт цаастай холбоотой аливаа татвар болон татвараас чөлөөлөгдөж болох нөхцөлийн тухай мэдээлэл;

(f) Амортизаци болон хугацаанаас нь өмнө үнэт цаасны төлбөр хийж болох эсэх тухай мэдээлэл;

(g) Үнэт цаасыг гаргаж буй валютын төрөл, хэрэв тухайн гаргаж буй валютаас өөр валютаар төлбөр хийхийг зөвшөөрсөн бол энэ тухай мэдээлэл;

(h) Дараах хугацааны хязгаарлалтууд:

i. Үндсэн төлбөр төлөгдөх сүүлийн хугацаа, сүүлийн хугацаанаас өмнө төлж болох хугацаа;

ii. Хүү тооцож эхлэх болон хүү төлөх хугацаа;

(i) Өгөөжийг тооцох аргачлал.

14. Дараах хууль зүйн мэдээлэл:

(a) Үнэт цаас гаргах шийдвэр, энэхүү шийдвэрийг гаргах эрх бүхий этгээдийг нотлох мэдээлэл;

(b) Баталгаа гаргагчийн үндсэн мэдээллүүд болон үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг төлөх бүрэн үүрэг хүлээж буй тухай баталгаа гаргагчийн шийдвэр, амлалт, тэдгээр мэдээллийг харилцагч олж үзэх боломжит байршлын тухай;

(c) Үнэт цаас гаргагч өмнө нь үнэт цаас гаргаж байсан бол энэ тухай мэдээлэл;

(d) Үнэт цаас гаргах үндэслэлийг илэрхийлсэн хууль эрх зохицуулалт, аливаа маргаан гарсан тохиолдолд зохицуулах хууль, шүүх эрх мэдлийн тухай мэдээлэл;

(e) Үнэт цаас хадгалах байгууллагын мэдээлэл;

(f) Үнэт цаасыг чөлөөтэй захиран зарцуулах, шилжүүлэхийг хязгаарласан аливаа зохицуулалт байгаа бол энэ тухай мэдээлэл;

15. Үнэт цаасны бүртгэлийн өргөдөл гаргахтай холбоотой дараах мэдээлэл:

(a) Үнэт цаас гаргагч нь өөр бирж дээр ижил төрлийн өрийн хэрэгсэл гаргасан, эсвэл гаргахаар төлөвлөж байгаа бол энэ тухай мэдээлэл;

(b) Өөр бирж дээр ижил төрлийн үнэт цаас гаргаагүй боловч өөр төрлийн үнэт цаас нь арилжигддаг бол энэ тухай мэдээлэл;

(c) Үнэт цаас гаргах ажлыг зохион байгуулах андеррайтерийн байгууллагын нэр, хэрэв андеерайтергүй бол энэ тухай мэдэгдэл;

(d) Хэд хэдэн удаагийн цуврал (tranche) гаргалтаар үнэт цаас гаргах бол энэ тухай мэдээлэл;

(e) Зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны тухай мэдээлэл

(f) Өрийн хэрэгслийг бүхэлд нь, эсвэл тодорхой хэсгийг нь Бирж дээр гаргах тухай мэдээлэл

16. Үнэт цаас гаргалттай холбоотой дараах нэмэлт мэдээлэл:

(a) Үнэт цаасны төлбөр гүйцэтгэх арга, санал болгох үнийн мэдээлэл

(b) Үнэт цаасыг үргэлжлүүлэн гаргахаас бусад тохиолдолд захиалга авах эхний болон эцсийн хугацаа, захиалгыг хугацаанаас нь өмнө хааж болох хязгаарлалт нөхцөлийн мэдээлэл

(c) Олон нийтээс захиалга хүлээн авах зуучлагч санхүүгийн байгууллагын мэдээлэл

(d) Шаардлагатай бол захиалгын хэмжээг бууруулах нөхцөлүүд

Хөрвөх өрийн хэрэгсэл гаргахтай холбоотой нэмэлт мэдээлэл

17. Хөрвөх хувьцаа болон бусад хөрөнгийн үнэ, хөрвөх харьцаа, тэдгээрийг дагалдан үүсэх эрх үүрэг, тухайлбал хувьцааны саналын эрх, ашгаас хувь хүртэх баталгаа, болон бусад эрх, үүрэг.

18. Хөрвөх эд хөрөнгийн тухай бүрэн мэдээлэл.

19. Хөрвөх нөхцөлийн талаар дараах мэдээллүүд:

(a) Хөрвөх хувьцааны нийт тоо ширхэг, дагалдан үүсэх эрх

(b) Хөрвөх хувьцааг эзэмших эрх үүсэх хугацаа,

(c) Хөрвөх хөрөнгийг шилжүүлэхтэй холбоотой зохицуулалтууд

20. Хэрэв хөрвөх үнэт цаас гаргагч болон хөрвөх хувьцаа гаргагч нь өөр этгээдүүд бол энэ тухай мэдээлэл.

21. Зарласан боловч гүйлгээнд гаргаж төлбөр төлөгдөөгүй хувьцаанд хөрвүүлэх буюу энэ нь компанийн хөрөнгийг нэмэгдүүлэх бол:

(a) Тухайн зарласан хувьцааны тоо хэмжээ, хөрөнгийн өсөлт

(b) Тухайн хувьцаатай холбоотой нөхцөлүүд

(c) Хөрвөх хувьцааны хяналтын багцыг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт эзэмшиж байгаа этгээдийн тухай мэдээлэл

22. Хөрвөх хувьцааны сүүлийн хоёр жилийн татварын дараах ашиг алдагдлын мэдээлэл, хэрэв үнэт цаас гаргагч нэгтгэсэн санхүүгийн тайланг бүртгэлийн баримт бичигт ирүүлсэн бол сүүлийн хоёр жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн ашиг, алдагдлын тухай мэдээлэл.

23. Сүүлийн хоёр жилд хуваарилсан нэгж хувьцааны ногдол ашгийн мэдээлэл.

24. Ногдол ашиг хуваарилсан бүртгэх өдрийн мэдээлэл.

25. Ирээдүйд олгохоор төлөвлөж буй ногдол ашгийн таамаглал.

26. Компанийн тухай хуулийн дагуу үнэт цаас гаргагчийн дүрэмд тусгагдсан хөрөнгө, хувьцаатай холбоотой өөрчлөлтийг зохицуулсан заалтуудын тухай хураангуй мэдээлэл.

Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн мэдээлэл

27. Үнэт цаас гаргагчийн хөрөнгөнд хамаарах сүүлийн хоёр жилд гарсан дараах өөрчлөлтүүд:

    (a) Мөнгөн бус хэлбэрээр бүрэн, эсвэл хагас нь төлөгдсөн, эсвэл төлөхөөр

    хүлээгдэж буй хөрөнгө;

    (b) Мөнгөн хэлбэрээр төлөгдсөн, эсвэл төлөгдөхөөр хүлээгдэж буй хөрөнгийн тухай мэдээлэл, тэдгээрийн үнэ, аливаа хөнгөлөлт урамшуулал, бусад нөхцөлийн талаар мэдээлэл болон аливаа сөрөг агуулга бүхий мэдэгдлүүд.

28. Үнэт цаас гаргагчийн нийт хувьцааны тоо, нэрлэсэн болон дансны үнэ.

29. Компанийн менежментийг хэрэгжүүлэгч этгээдэд олгохоор шийдвэрлэсэн, амласан хувьцаа, шагнал, опцион болон зарлаагүй ногдол ашгийн талаарх мэдээлэл.

30. Хувьцаа эзэмшигчдийн саналын эрх, тэдгээрийг хэрэгжүүлэх хэлбэр.

31. Бүртгэлийн баримт бичгийг олон нийтэд танилцуулахаас өмнөх хоёр жилийн хугацаанд үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын хувь нийлүүлсэн хөрөнгөнд орсон өөрчлөлтийн мэдээлэл.

32. Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын гаргасан опционы талаарх мэдээлэл.

33. Үнэт цаас гаргагчийн хяналтын багц эзэмшигчдийн мэдээлэл, түүний эзэмшлийн хувь хэмжээ.

Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын үйл ажиллагааны мэдээлэл

34. Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын үйл ажиллагааны мэдээлэлд дараах мэдээлэл хамаарна. Үүнд:

    (a) Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын үйл ажиллагааны чиглэл, тэдгээрийн зах зээлд эзлэх хувь хэмжээ зэрэг бизнесийн үйл ажиллагаатай холбоотой бусад танилцуулга, мэдээлэл. Дээрх компаниудын өмчлөл, эзэмшил, ашиглалтад байдаг хөрөнгийн мэдээлэл;

    (b) Үнэт цаас гаргагч болон түүний харилцан хамааралтай компаниудын хоорондын хамаарлын талаарх мэдээлэл, эзэмшлийн хувь хэмжээ;

    (c) Үнэт цаас гаргагч болон түүний харилцан хамааралтай компаниудын нэг жилээс дээш хугацаагаар түрээсээр болон лизингээр авсан, эсхүл түрээслүүлж буй эд хөрөнгийн гэрээний мэдээлэл;

    (d) Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаанд голлох үүрэгтэй барааны тэмдэг, патент, оюуны болон аж үйлдвэрийн өмчтэй холбоотой зүйлсийн талаарх мэдээлэл;

(e) Сүүлийн таван жилийн хугацаанд хийгдсэн томоохон ач холбогдолтой шинэ бүтээгдэхүүний судалгаа, хөгжүүлэлтийн явцын талаарх мэдээлэл;

(f) Сүүлийн нэг жилийн хугацаанд үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын санхүүгийн байдалд нөлөөлсөн үйл ажиллагааны түр зогсолтын талаарх мэдээлэл;

(g) Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын нийт ажилчдын тоо болон тэдгээрийн тоонд сүүлийн нэг жилийн хугацаанд их хэмжээний өөрчлөлт орсон бол энэ талаарх мэдээлэл;

(h) Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын ажилчдад шагнал урамшуулал олгох бодлогын талаарх мэдээлэл;

(i) Шинээр үйлдвэр барих зэргээр томоохон хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлж буй, эсхүл хэрэгжүүлэхээр төлөвлөж буй бол уг төслийн талаарх мэдээлэл.

35. Гадаад улсаас Монгол Улс руу хөрөнгө, орлогоо шилжүүлэхэд хязгаарлалт байгаа эсэх.

Үнэт цаас гаргагч болон түүний харилцан хамаарал бүхий компаниудын санхүүгийн мэдээлэл

36. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд ноцтой нөлөөлөхүйц дараах санхүүгийн мэдээллүүд:

(a) Үнэт цаас гаргагч болон түүний харилцан хамаарал бүхий компаниудын гаргасан өрийн хэрэгслийн хэмжээ;

(b) Үнэт цаас гаргагч болон түүний харилцан хамаарал бүхий компаниудын өр зээлийн мэдээлэл;

(c) Үнэт цаас гаргагч болон түүний харилцан хамаарал бүхий компаниудын үл хөдлөх хөрөнгийн мэдээлэл;

(d) Үнэт цаас гаргагч болон түүний харилцан хамаарал бүхий компаниудын гаргасан баталгаа болон бусад ирээдүйд үүсч болзошгүй өр төлбөрийн хэмжээ;

(e) Үнэт цаас гаргагч болон түүний харилцан хамаарал бүхий компаниудын хөрвөх чадвар болон санхүүгийн нөөцийн талаарх мэдээлэл;

(f) Үнэт цаас гаргагч болон түүний харилцан хамаарал бүхий компаниудын капиталын бүтцийн талаарх мэдээлэл.

37. Үнэт цаас гаргагч болон түүний харилцан хамаарал бүхий компаниудын сүүлийн гурван жилийн хугацааны орлого болон түүний тооцооллын аргачлалын мэдээлэл.

38. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнуудын цалин урамшуулалтай холбоотой мэдээллүүд. Үүнд:

(a) Сүүлийн гурван жилийн хугацаанд үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнуудад олгосон цалингийн нэгдсэн үзүүлэлт;

(b) Сүүлийн гурван жилийн хугацаанд үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнуудад олгосон бүх төрлийн, хөнгөлөлт, урамшуулал, шууд болон шууд бусаар тэдэнд олгосон төлбөр болон эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байгаад ажлаас халагдсан этгээдэд олгосон төлбөрийн мэдээлэл;

(c) Сүүлийн гурван жилийн хугацаанд үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнуудад олгосон тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн даатгалын шимтгэл, даатгал зэрэг мэдээллийн нэгдсэн үзүүлэлт.

39. Сүүлийн гурван жилийн хугацаанд цалин, урамшуулал, хөнгөлөлт, тэтгэвэр, тэтгэмж зэргээр үнэт цаас гаргагчаас авсан орлогоороо айрагдсан таван хүний орлогын мэдээлэл, түүний задаргаа. Эдгээр таван хүний дотор эрх бүхий албан тушаалтнаас өөр этгээд багтсан бол тухайн этгээдийн энэ жагсаалтын 38(1), (2), (3)-т заасан мэдээлэл. Эдгээр айрагдсан таван хүний нэр, бусад хувийн мэдээллийг дурдах шаардлагагүй.

40. Бүртгэлийн баримт бичигт дурдагдаагүй боловч эрсдэлийн хүчин зүйл гэх мэт үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нөлөөлж болох бусад зүйлсийн талаарх мэдээлэл.

41. Энэ журмын 6 дугаар бүлэгт заасан ашгийн таамаглалын мэдээлэл.

42. Санхүүгийн тайланг бэлтгэсэн нягтлан бодогчид болон тэдгээрийн мэргэшсэн байдлын талаарх мэдээлэл.

43. Энэ журмын 6 дугаар бүлэгт заасан ажлын капиталын нөөцийн талаарх мэдээлэл.

44. Үнэт цаас гаргагч болон түүний харилцан хамааралтай компаниудын бүртгэлийн баримт бичиг гаргах өдрийн байдлаар оролцож байгаа, эсхүл оролцож болзошгүй эрүү, иргэн, арбитр, захиргааны хэргийн талаарх мэдээлэл.

Үнэт цаас гаргагчийн менежментийн талаарх мэдээлэл

45. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан, ахлах менежер болон эдгээр албан тушаалд нэр дэвшиж буй этгээдүүдийн намтар, туршлагын талаарх мэдээлэл. Эрх бүхий албан тушаалтнуудын хооронд гэр бүлийн харилцан хамаарал байгаа эсэх.

46. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргын намтар, туршлагын талаарх мэдээлэл.

47. Үнэт цаас гаргагчийн байрлаж буй оффисын эзэмшил, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, түрээсийн гэрээний дагуу эзэмшиж, ашиглаж буй үл хөдлөх хөрөнгөтэй тохиолдолд түрээсийн гэрээний хуулбар, бусад нэмэлт мэдээлэл.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан/

48. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнуудын үнэт цаас гаргагч компанид эзэмшиж буй бүх төрлийн үнэт цаасны хувь хэмжээний талаарх мэдээлэл.

49. Үнэт цаас гаргагч түүний хамаарал бүхий компаниуд болон үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнуудын хооронд байгуулсан, эсхүл байгуулахаар төлөвлөсөн үйлчилгээ үзүүлэх, ажил гүйцэтгэх чиглэлийн (хугацаа нь дуусгавар болсон, эсхүл төлбөрийн үүрэг үүсгэхгүйгээр байгуулсан гэрээ үүнд хамаарахгүй) гэрээ хэлцлийн талаарх мэдээлэл.

50. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнуудад олгосон төлбөрийн мэдээллийг сүүлийн нэг жилийн байдлаар.

51. Бүртгэлийн баримт бичгийг бэлтгэж буй санхүүгийн жилд үнэт цаас гаргагч болон түүний харилцан хамаарал бүхий компанийн эрх бүхий албан тушаалтнууд болон түүнд нэр дэвшигчдэд гэрээгээр олгохоор тохиролцсон цалин урамшууллын хэмжээ.

52. Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компанийн хөрөнгийг сүүлийн хоёр жилийн хугацаанд шууд болон шууд бусаар худалдсан, худалдан авсан, түрээсэлсэн, зуучилсан, эсхүл эдгээр үйлдлийг хийхээр төлөвлөсөн үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан болон шинжээчийн мэдээлэл.

Татан төвлөрүүлсэн хөрөнгийг ашиглахтай холбоотой мэдээлэл

53. Үнэт цаас гаргаснаас татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө.

54. Татан төвлөрүүлсэн хөрөнгөөр үл хөдлөх хөрөнгө худалдаж авахаар төлөвлөсөн бол түүний мэдээлэл.

55. Өрийн хэрэгслийн үндсэн болон хүүгийн төлбөрийг төлөх мөнгөн урсгалын эх үүсвэр, төлбөрийн хугацаа, төлөх хүү, төлбөрийн хэмжээнээс илүү гарсан мөнгөн урсгалыг хэрхэн зарцуулах тухай мэдээлэл.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан/

Уул уурхайн компанийн ирүүлэх нэмэлт баримт

56. Уул уурхайн компанийн хувьд Биржийн тогтоосон журмын дагуу нэмэлт баримт бичгийг ирүүлнэ.

Хөрөнгийн мэдээлэл

57. Энэ журмын 6 дугаар бүлэгт шаардсан хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний мэдээлэл.

Чухал ач холбогдолтой гэрээ болон баримт бичгүүд

58. Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын сүүлийн хоёр жилийн хугацаанд байгуулсан чухал ач холбогдолтой гэрээний мэдээлэл, үндсэн агуулга.

59. Барьцаа болон баталгааны тухай мэдээлэл.

Бусад мэдээлэл

60. Бүртгэлийн журмаас чөлөөлөгдсөн зээлтүүдийн талаарх мэдээлэл.

61. Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаанд хамаарах хууль тогтоомжийн талаарх мэдээлэл.

62. Хөрөнгө оруулагчид шийдвэр гаргахад шаардлагатай бусад мэдээлэл.

63. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хорооны холбогдох журамд заасан бусад мэдээлэл.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

64. Биржийн шаардсан мэдээлэл.

Хавсралт

65. Бүртгэлийн баримт бичигт дараах баримтуудыг хавсаргана:

(a) Компанийн дүрэм, хувьцаа эзэмшигчдийн гэрээ болон тэдгээртэй адилтгах бусад баримтууд;

(b) Энэ зүйлийн 51, 59-т нэрлэгдсэн гэрээнүүд;

(c) Бүртгэлийн баримт бичигт дурдагдсан шинжээчдийн гаргасан бүх төрлийн тайлан, дүгнэлт, албан бичиг, бусад баримтууд;

(d) Төсөвлөсөн санхүүгийн мэдээлэл;

(e) Ашгийн таамаглал;

(f) Сүүлийн гурван жилийн хугацааны үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлангууд, харилцан хамаарал бүхий компаниудын нэгдсэн тайлан болон бусад шаардлагатай санхүүгийн мэдээллүүд;

(g) Энэ журмын 6 дугаар бүлэгт заасан бусад баримт бичгүүд.

БҮРТГЭЛИЙН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА (Нэмэлт үнэт цаас бүртгүүлэх)

Үнэт цаас гаргагч, түүний зөвлөхүүд болон бүртгэлийн баримт бичгийн талаарх ерөнхий мэдээлэл

1. Үнэт цаас гаргагчийн бүтэн нэр.

2. Доорх мэдэгдэл:

   “Энэхүү үнэт цаасны бүртгэлийн баримт бичиг нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны Бүртгэлийн журам, Биржийн Бүртгэлийн журамд заасан үнэт цаасыг олон нийтэд санал болгохтой холбоотой бүх шаардлагатай мэдээллийг агуулсан болно. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд нь энэ баримт бичигт агуулсан мэдээлэл нь үнэн зөв, бүрэн бөгөөд хуурамчаар бүрдүүлсэн ямар нэгэн баримт байхгүй гэдгийг албан ёсоор баталж байна. Энд заасан мэдэгдэл худал байх тохиолдолд үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд нь дангаар болон хамтын журмаар хариуцлага хүлээхийг хүлээн зөвшөөрч байна”.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23/22 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

3. Үнэт цаас гаргагчийн гол харилцагч банк, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хуулийн зөвлөхийн нэр, хаяг.

4. Үнэт цаас гаргагчийн аудиторын нэр, хаяг болон түүний мэргэшсэн байдлын мэдээлэл.

5. Шинжээч (нягтлан бодогч, инженер, үнэлгээчин, хуульч гэх мэт үнэт цаас гаргагчид мэргэжлийн зөвлөгөө өгч байгаа этгээдүүд)-тэй холбоотой дараах мэдээллүүд:

   (a) Тухайн шинжээчийн мэргэшсэн байдлыг тодорхойлсон мэдээлэл, үнэт цаас гаргагчийн болон түүний хамаарал бүхий компаниудтай шинжээчид хамааралтай эсэх мэдээлэл, тэдгээрийн хувьцааг эзэмшдэг эсэх;

   (b) Шинжээчдийн гаргасан холбогдох дүгнэлт (хуулийн дүгнэлт, хөрөнгийн үнэлгээ тэдгээртэй холбоотой санал, захидал гэх мэт)-ийг тэдний нэрийн өмнөөс бүртгэлийн баримт бичигт оруулахад татгалзаагүй талаарх мэдэгдэл;

   (c) Шинжээчдийн дүгнэлт гаргасан огноо болон тухайн дүгнэлтийг зөвхөн бүртгэлийн баримт бичигт оруулах зорилгоор гаргасан эсэх талаарх мэдээлэл.

6. Өөр биржид үнэт цаас нь (хувьцаа, өрийн бичиг) бүртгэлтэй, эсхүл бүртгүүлэхээр төлөвлөж байгаа тохиолдолд тухайн биржийн нэр, бүртгэлтэй

болон бүртгүүлэхээр төлөвлөж буй үнэт цаасны талаарх мэдээлэл хэрвээ бүртгэлгүй буюу бүртгүүлэхээр төлөвлөөгүй бол энэ тухай мэдэгдэл.

7. Ногдол ашиг хуваарилахыг хязгаарласан зохицуулалтын талаар.

8. Үнэт цаас гаргагчийн хувьцааг гаргах, эсхүл түүний хөрөнгийг худалдахтай холбоотойгоор сүүлийн хоёр жилийн хугацаанд үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан, зуучлагч, шинжээчдэд олгосон шагнал, урамшуулал, зуучлалын төлбөр, түүнийг хүлээж авсан этгээдүүдийн талаарх мэдээлэл.

Үнэт цаасны мэдээлэл, тэдгээрийг гаргах болон хуваарилах нөхцөл

9. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасыг Биржид бүртгүүлж арилжаанд оруулахыг хүссэн өргөдлийг Биржид гаргасан тухай мэдэгдэл.

10. Үнэт цаасны шинэ багцыг бүртгүүлэхээр өргөдөл гаргаж байгаа тохиолдолд Биржийн тооцооны системээр арилжаанд оруулахад шаардлагатай бүх арга хэмжээг авсан тухай мэдэгдэл.

11. Үнэт цаасны төрөл, хэмжээ, үнэт цаасыг гаргаж байгаа нөхцөл, үнэт цаасанд дагалдах нөхцөл зэрэг үнэт цаасны талаарх мэдээлэл.

12. Өмнө нь татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ, түүний зарцуулалтын мэдээлэл болон үнэт цаасыг бүртгүүлснээр татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, түүний зарцуулалтын урьдчилсан тооцоолол.

13. Тогтмол ногдол ашиг амлаж үнэт цаас гаргаж байгаа тохиолдолд тухайн ногдол ашгийг хуваарилахад шаардлагатай орлогыг олох эх үүсвэрийн талаарх мэдээлэл.

14. Арилжаа эхлэх өдөр (хэрвээ мэдэх боломжтой бол).

15. Үнэт цаасыг одоогийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжид санал болгох нөхцөлтэйгөөр гаргаж байгаа тохиолдолд тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэх журам, санал болгох хугацаа, хувь тэнцүүлэн санал болгох тохиолдолд түүний аргачлал.

Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгийн мэдээлэл

16. Компанийн зарласан болон гаргасан, эсхүл гаргахаар зөвшөөрсөн хувьцааны тоо, төлбөр хийгдсэн хувьцааны тоо, хувьцааны нэрлэсэн үнэ.

17. Компанийн гаргасан өрийн бичиг, давуу эрхийн хувьцаа болон түүний хөрвөх нөхцөл.

18. Компанийн менежментийг хэрэгжүүлэгч этгээдэд олгохоор шийдвэрлэсэн, амласан хувьцаа, шагнал, опцион болон зарлаагүй ногдол ашгийн талаарх мэдээлэл.

19. Үнэт цаас гаргагчийн сүүлийн аудитлагдсан санхүүгийн тайлан гарсны дараа үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын өөрийн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт орсон тохиолдолд түүний мэдээлэл.

20. Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын гаргасан опционы талаарх мэдээлэл.

Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын үйл ажиллагааны мэдээлэл

21. Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын үйл ажиллагааны мэдээлэлд дараах мэдээлэл хамаарна. Үүнд:

    (a) Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын үйл ажиллагааны чиглэл болон тэдгээрийн өмчлөл, эзэмшил, ашиглалтад байдаг хөрөнгийн мэдээлэл;

    (b) Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын гол үйлчлүүлэгч, худалдан авагч болон нийлүүлэгчтэй холбоотой дараах мэдээллүүд:

        i. Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын нийт худалдан авалтад манлайлсан нэг нийлүүлэгчийн нийт худалдан авалтын хэмжээнд эзэлж буй хувь;

        ii. Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын нийт худалдан авалтад тэргүүлсэн таван нийлүүлэгчийн нийт худалдан авалтын хэмжээнд эзэлж буй хувь;

        iii. Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын нийт борлуулалтад тэргүүлсэн нэг худалдан авагчийн нийт борлуулалтын хэмжээнд эзэлж буй хувь;

        iv. Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын нийт борлуулалтад тэргүүлсэн таван худалдан авагчийн нийт борлуулалтын хэмжээнд эзэлж буй хувь;

        v. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд болон тэдгээрийн харилцан хамаарал бүхий этгээд болон 5 хувиас дээш хувийн хувьцаа эзэмшигчид нь гол үйлчлүүлэгч, худалдан авагч болон нийлүүлэгчтэй харилцан хамааралтай эсэх талаарх мэдээлэл.

22. Үнэт цаас гаргагч болон түүний харилцан хамааралтай компаниудын нэг жилээс дээш хугацаагаар түрээсээр болон лизингээр авсан, эсхүл түрээслүүлж буй эд хөрөнгийн гэрээний мэдээлэл.

23. Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаанд голлох үүрэгтэй барааны тэмдэг, патент, оюуны болон аж үйлдвэрийн өмчтэй холбоотой зүйлсийн талаарх мэдээлэл.

24. Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын санхүүгийн байдалд нөлөөлсөн үйл ажиллагааны түр зогсолтын талаарх мэдээллийг сүүлийн нэг жилийн байдлаар.

25. Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын нийт ажилчдад олгосон шагнал урамшуулал, опционы мэдээг сүүлийн нэг жилийн байдлаар.

26. Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын ажилчдад олгох шагнал урамшууллын бодлогын талаарх мэдээлэл.

27. Хөрөнгө оруулалтыг (хэрэв байгаа бол) зарцуулахаар төлөвлөж буй үйл ажиллагааны талаарх мэдээлэл.

28. Гадаад улсаас Монгол Улс руу хөрөнгө, орлогоо шилжүүлэхэд нөлөөлөх хязгаарлалт байгаа эсэх.

Үнэт цаас гаргагч болон түүний харилцан хамаарал бүхий компаниудын санхүүгийн мэдээлэл

29. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд ноцтой нөлөөлөхүйц дараах санхүүгийн мэдээллүүд:

    (a) Үнэт цаас гаргагч болон түүний харилцан хамаарал бүхий компаниудын гаргасан өрийн үнэт цаасны хэмжээ;

    (b) Үнэт цаас гаргагч болон түүний харилцан хамаарал бүхий компаниудын өр зээлийн мэдээлэл;

    (c) Үнэт цаас гаргагч болон түүний харилцан хамаарал бүхий компаниудын үл хөдлөх хөрөнгийн зээлийн мэдээ;

    (d) Үнэт цаас гаргагч болон түүний харилцан хамаарал бүхий компаниудын нийт болзошгүй өр төлбөрийн хэмжээ.

30. Бүртгэлийн баримт бичигт дурдагдаагүй боловч үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нөлөөлж болох үйл явдлын талаарх мэдээлэл.

31. Энэхүү журмын 6 дугаар бүлэгт заасан ашгийн таамаглал.

32. Ажлын капиталын нөөц 1 жилийн хугацаанд хангалттай талаарх ТУЗ-ийн мэдэгдэл (санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг компанид хамаарахгүй).

33. Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын бизнесийн үйл ажиллагаанд сүүлийн санхүүгийн тайлан гарснаас хойш орсон өөрчлөлтүүдийн мэдээлэл.

34. Үнэт цаас гаргагч болон түүний харилцан хамааралтай компаниудад холбогдон гарсан, эсхүл гарч болзошгүй эрүү, иргэн, захиргааны хэрэг, маргааны талаарх мэдээлэл.

Үнэт цаас гаргагчийн менежментийн талаарх мэдээлэл

35. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан, ахлах менежер болон эдгээр албан тушаалд нэр дэвшиж буй этгээдүүдийн намтар.

36. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргын намтар.

37. Үнэт цаас гаргагчийн албан ёсны хаяг. Албан ёсны хаяг нь байрлаж буй хаягаас нь өөр байх тохиолдолд албан ёсны болон байрлаж байгаа хаяг.

38. Хувьцааны харилцан эзэмшлийн мэдээлэл.

39. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнуудын үнэт цаас гаргагч компанид эзэмшиж буй бүх төрлийн үнэт цаасны хувь хэмжээний талаарх мэдээлэл.

40. Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудтай үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан үйлчилгээ үзүүлэх, ажил гүйцэтгэх чиглэлээр гэрээ (хугацаа нь дуусгавар болсон, эсхүл төлбөрийн үүрэг үүсгэхгүйгээр байгуулсан гэрээ үүнд хамаарахгүй) байгуулсан, эсхүл байгуулахаар төлөвлөсөн тохиолдолд эдгээр гэрээний талаарх мэдээлэл.

41. Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компанийн хөрөнгийг сүүлийн хоёр жилийн хугацаанд шууд болон шууд бусаар худалдсан, худалдан авсан, түрээсэлсэн, зуучилсан, эсхүл эдгээр үйлдлийг хийхээр төлөвлөсөн үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан болон шинжээчийн мэдээлэл.

Уул уурхайн компанийн ирүүлэх нэмэлт баримт

42. Уул уурхайн компанийн хувьд Биржийн тогтоосон журмын дагуу нэмэлт баримт бичгийг ирүүлнэ.

Чухал ач холбогдолтой гэрээ болон баримт бичгүүд

43. Үнэт цаас гаргагч болон түүний хамаарал бүхий компаниудын сүүлийн хоёр жилийн хугацаанд байгуулсан чухал ач холбогдолтой гэрээний мэдээлэл, үндсэн агуулга.

44. Бүртгэлийн баримт бичигт дараах баримтуудыг хавсаргана:

    (a) Компанийн дүрэм, хувьцаа эзэмшигчдийн гэрээ болон тэдгээртэй адилтгах бусад баримтууд;

    (b) Энэ зүйлийн 41, 44-т нэрлэгдсэн гэрээнүүд;

    (c) Бүртгэлийн баримт бичигт дурдагдсан шинжээчдийн гаргасан бүх төрлийн тайлан, дүгнэлт, албан бичиг, бусад баримтууд;

    (d) Сүүлийн хоёр жилийн хугацааны үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлангууд, харилцан хамаарал бүхий компаниудын нэгдсэн тайлан болон бусад шаардлагатай санхүүгийн мэдээллүүд;

    (e) Энэхүү журмын 6 дугаар бүлэгт заасан бусад баримт бичгүүд.

БҮРТГЭЛИЙН ГЭРЭЭ /Хувьцаа, Хөрөнгө оруулалтын сан/

№

Энэхүү Бүртгэлийн гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г 20 __ оны __ сарын __ -ны өдөр

Нэг талаас _____ хаягт байрлах “Улаанбаатар Үнэт Цаасны Бирж” ХК (цаашид “Бирж” гэх), түүнийг төлөөлж _____,

Нөгөө талаас _____ хаягт байрлах _____ тоот регистрийн дугаартай “_____” ХК (цаашид “Үнэт цаас гаргагч” гэх), түүнийг төлөөлж _____ (хамтад нь “Талууд” гэх) нь

Биржийн Бүртгэлийн хорооны 20 __ оны __ сарын __ -ны өдрийн ___ тоот шийдвэр, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ны 20 __ оны __ сарын __ -ны өдрийн __ тоот шийдвэрийг тус тус үндэслэн дараах нөхцөлөөр байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү Гэрээгээр Үнэт цаас гаргагч нь Биржид бүртгэлтэй байх хугацаанд түүний хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлж, Бирж болон Үнэт цаас гаргагчийн хооронд үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Үнэт цаас гаргагчийн олон нийтэд мэдээлэл хүргэх, бүртгэлтэй байх хугацаанд тогтмол хүлээх нарийвчилсан үүрэгтэй холбоотой харилцааг Гэрээний Ерөнхий нөхцөлөөр зохицуулах ба Биржээс шаардлагатай гэж үзвэл тодорхой төрлийн харилцааг Тусгай нөхцөлөөр зохицуулна.

1.3. Гэрээний Ерөнхий нөхцөл болон Тусгай нөхцөлийг Биржийн Гүйцэтгэх захирал батлах ба өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтийг мөрдөж эхлэхээс ажлын 10 (арав) хоногийн өмнө Үнэт цаас гаргагчид мэдэгдэнэ.

1.4. Гэрээнд зохицуулаагүй аливаа асуудлыг талууд Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хороо, Биржээс баталсан холбогдох журмын дагуу шийдвэрлэнэ.

1.5. Гэрээнд дурдсан нэр томьёог Бүртгэлийн журам болон Биржийн бусад журамд заасан нэр томьёоны тайлбарын дагуу ойлгож хэрэглэнэ.

ХОЁР. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮНЭТ ЦААС

2.1. Үнэт цаас гаргагчийн нийт эргэлтэд гаргасан энгийн / давуу эрхтэй хувьцаа / сангийн нэгж эрх нь ..... ширхэг байна.

2.2. Бирж нэг бүр нь ..... төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий ..... ширхэг гаргасан энгийн / давуу эрхтэй хувьцааг / сангийн нэгж эрхийг бүртгэв.

2.3. Үнэт цаас гаргагч нийт ..... ширхэг энгийн / давуу эрхтэй хувьцаа / сангийн нэгж эрхийг Биржийн холбогдох журмын дагуу үндсэн / хөгжлийн талбарт арилжина.

ГУРАВ. БҮРТГЭЛТЭЙ БАЙХ ХУГАЦААНД ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХҮЛЭЭХ НИЙТЛЭГ ҮҮРЭГ

Хууль тогтоомж, дүрэм журам дагаж мөрдөх

3.1. Үндсэн болон Хөгжлийн талбарт бүртгэгдэх Үнэт цаас гаргагч нь төрийн эрх бүхий байгууллагаас баталсан хууль тогтоомжоос гадна Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрийн байдлаар хэрэгжиж байгаа Гэрээ, Гэрээний Ерөнхий нөхцөл, Гэрээний Тусгай нөхцөл, Биржээс батлагдан гарах дүрэм журам, заавар, удирдамж, зөвлөмж, тушаал шийдвэр болон тэдгээрийн нэмэлт өөрчлөлтийг дагаж мөрдөх үүрэгтэй.

Үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах

3.2. Үнэт цаас гаргагч нь бүртгэлтэй байх хугацаандаа үйл ажиллагаагаа хэвийн явуулах үүрэгтэй ба уг үүргийг биелүүлэхэд хангалттай хүрэлцэхүйц эдийн болон эдийн бус хөрөнгөтэй байна.

3.3. Үнэт цаас гаргагч бүртгэлтэй байх хугацаандаа Улаанбаатар Үнэт Цаасны Биржийн бүртгэлийн журам (цаашид “Бүртгэлийн журам” гэх)-д заасан шалгуур үзүүлэлтийг тогтмол хангаж ажиллах үүрэгтэй.

Шаардлага биелүүлэх

3.4. Бирж нь зохицуулалттай зах зээлийн хэвийн үйл ажиллагааг хангах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд Үнэт цаас гаргагчид шаардлага тавих эрхтэй ба Үнэт цаас гаргагч нь тухайн шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлэх үүрэгтэй.

Олон нийтэд мэдээлэх

3.5. Үнэт цаас гаргагч мэдээллийг олон нийтэд хүргэхдээ Бүртгэлийн журмын 8.4-д заасны дагуу мэдээлнэ.

3.6. Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчдыг мэдээлэлд суурилсан, үндэслэл бүхий шийдвэр гаргахад нь шаардлагатай мэдээллээр хангах үүрэгтэй. Энэ үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг Гэрээний Ерөнхий нөхцөл, Гэрээний Тусгай нөхцөл, Биржээс батлах бусад дүрэм, журмаар зохицуулна.

3.7. Бирж шаардсан, эсхүл Үнэт цаас гаргагч шаардлагатай гэж үзсэн тохиолдолд цахим хуудсанд байршуулсан мэдээллийг бусад мэдээллийн хэрэгслийг ашиглан нийтэд хүргэж болно.

Биржтэй харилцах

3.8. Үнэт цаас гаргагч нь Бүртгэлийн журамд заасны дагуу томилсон итгэмжлэгдсэн төлөөлөгч, Үнэт цаас гаргагчтай гэрээ байгуулсан нийцүүлэгчээр дамжуулан Биржтэй харилцана.

3.9. Бирж Үнэт цаас гаргагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн Биржид бүртгүүлсэн ажлын газрын хаяг, цахим шуудан, факс зэргийн аль нэгээр (тухайн нөхцөлд тохиромжтой хэлбэрээр нь) аливаа зар, мэдээлэл, мэдэгдэл, баримт бичиг зэргийг илгээснээр түүнийг итгэмжлэгдсэн төлөөлөгч хүлээн авсан эсэхээс үл шалтгаалан Үнэт цаас гаргагчид хүргүүлсэнд, Үнэт цаас гаргагч хүлээн зөвшөөрсөнд тооцно.

3.10. Үнэт цаас гаргагчаас Биржид илгээх мэдээллийг Биржтэй тохиролцсон хэлбэр, сувгаар хүргүүлнэ.

Бусад нийтлэг үүрэг

3.11. Татан төвлөрүүлсэн хөрөнгийг бүртгэлийн баримт бичигт заасан зориулалтын дагуу ашиглах;

3.12. Бүртгэлийн журамд заасан тодорхой шаардлагаас чөлөөлөгдсөн тохиолдолд тэдгээр шаардлага, түүний биелүүлэх болзол, нөхцөлийг Биржээс тогтоосон хугацааны дотор хангаж, энэ талаар Бирж болон олон нийтэд мэдээлэх;
3.13. Биржтэй хийсэн аливаа уулзалт, зөвлөгөөн, тэдгээрээс гарсан шийдвэрийг нууцлах;
3.14. Биржээс шаардсан лавлагаа, мэдээллийг цаг тухайд нь хүргүүлэх;
3.15. Бирж шаардсан тохиолдолд Үнэт цаас гаргагчийн удирдлагын багийн зарим гишүүдийг тодорхой хугацаанд өөрчлөхгүй байх;
3.16. Бизнесийн үндсэн үйл ажиллагааны чиглэлд Биржийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөлт оруулахгүй байх;
3.17. Биржээс явуулж буй хяналт шалгалтын ажилд туслалцаа үзүүлэх;
3.18. Гэрээний Ерөнхий нөхцөлд заасан тогтмол хүлээх үүргийг биелүүлэх зэрэг болно.

ДӨРӨВ. ТӨЛБӨР, ХУРААМЖ

4.1. Үнэт цаас гаргагч Биржийн баталсан Шимтгэл, хураамжийн журамд заасан бүртгэлтэй холбоотой бүх шимтгэл хураамжийг заасан хугацаанд төлөх үүрэгтэй.
4.2. Хэрэв Үнэт цаас гаргагч Гэрээний 4.1-д заасан хураамжийг тогтоосон хугацаанд төлөөгүй тохиолдолд Бирж төлөгдөөгүй үнийн дүнгээс алданги тооцож авна.

ТАВ. АЛБАН ЁСНЫ НЭР, ЛОГО, ВЭБ САЙТЫН ХАЯГ, БАРААНЫ ТЭМДЭГ АШИГЛАХ

5.1. Үнэт цаас гаргагчийн болон үнэт цаасны бүртгэлтэй холбогдох мэдээ, мэдээлэл, баримт бичгийг олон нийтэд хүргэх зорилгоор Бирж Үнэт цаас гаргагчийн лого, вэб сайтын хаяг, албан ёсны нэр, барааны тэмдгийг ашиглах эрхтэй. Үнэт цаас гаргагч нь Биржийг Үнэт цаас гаргагчийн лого, вэб сайтын хаяг, албан ёсны нэр, барааны тэмдгийг ашиглах боломжоор хангах үүрэгтэй.
5.2. Үнэт цаас гаргагч өөрийн лого, вэб сайтын хаяг, албан ёсны нэр, барааны тэмдэг нь гуравдагч этгээдэд хамаарах зохиогчийн эрхийг зөрчөөгүй болохыг үүгээр баталж байгаа бөгөөд Бирж Үнэт цаас гаргагчийн лого, вэб сайтын хаяг, албан ёсны нэр, барааны тэмдгийг ашигласнаас үүдэн гуравдагч этгээдэд хохирол учирсан тохиолдолд тухайн асуудлыг Үнэт цаас гаргагч бүрэн хариуцаж шийдвэрлэнэ.
5.3. Бирж урьдчилан бичгээр зөвшөөрөл өгснөөс бусад тохиолдолд Үнэт цаас гаргагч Биржийн лого, вэб сайтын хаяг, албан ёсны нэр, барааны тэмдгийг ашиглахыг хориглоно.

ЗУРГАА. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БАТАЛГАА

6.1. Үнэт цаас гаргагч нь дараах байдлаар мэдэгдэл болон баталгааг гаргаж байна:
6.1.1. Үнэт цаас гаргагч, эсхүл түүний төлөөлөгч нь энэхүү Гэрээг зохих журмын дагуу хийсэн бөгөөд Гэрээгээр хүлээх түүний үүрэг нь хууль ёсны бөгөөд Үнэт цаас гаргагчид заавал биелүүлэх үүрэг хүлээлгэж байна.
6.1.2. Үнэт цаас нь (энэхүү гэрээний дагуу үүрэг хүлээснээс гадна) ямар нэгэн барьцаанд тавигдаагүй, түүнийг барьцаа болгох ямар нэгэн гэрээ, хэлцэл, хийгдээгүй, энэ талаар Үнэт цаас гаргагч ямар нэгэн үйлдэл хийгээгүй болно.

6.1.3. ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага нь Үнэт цаас гаргагчийн эд хөрөнгийн болон эзэмшлийн холбогдолтой аливаа шүүхийн маргаанд татагдаагүй болно.

6.1.4. Үнэт цаас гаргагчийг дампууруулах ямар нэгэн нэхэмжлэл гараагүй, Үнэт цаас гаргагч нь дампуурах болон татан буугдах үндэслэл байхгүй.

6.2. Энэхүү гэрээ, түүнд орсон зүйл заалт нь үнэт цаас болон Талуудад хамааралтай ямар нэгэн хууль тогтоомж, шүүхийн шийдвэр, зөвшөөрөл, тушаал, шийдвэрийг зөрчөөгүй болно.

6.3. Талууд энэ зүйлд заасан мэдэгдэл болон баталгаанд үндэслэн энэхүү гэрээг байгуулсан болно. Энэхүү гэрээг байгуулах үед гаргасан мэдэгдэл ба баталгаа нь үнэн зөв болохыг Үнэт цаас гаргагч нотолж байна.

ДОЛОО. ЧӨЛӨӨЛӨЛТ БА ХЯЗГААРЛАЛТ

7.1. Үнэт цаас гаргагч Хавсралт 1-т заасан нөхцөлөөр чөлөөлөлт эдэлнэ.

7.2. Гэрээний Хавсралт 2-т заасан хязгаарлалтыг Үнэт цаас гаргагч дагаж мөрдөх үүрэгтэй.

7.3. Бирж нь зах зээлийн шударга, үр ашигтай байдлыг хангах зорилгоор үнэт цаас, түүний арилжаа, Үнэт цаас гаргагч болон түүний эрх бүхий албан тушаалтнуудад Гэрээний 7.2-т зааснаас гадна нэмэлт хязгаарлалт тогтоож болно.

НАЙМ. ЗӨРЧИЛ БА ХАРИУЦЛАГА

8.1. Үнэт цаас гаргагч нь холбогдох хууль тогтоомж, Биржээс баталсан дүрэм, журам болон Гэрээний заалтыг зөрчсөн тохиолдолд үүнээс шалтгаалан Биржийн нэр хүндэд хохирол учруулсан, Биржийн үйл ажиллагаанд сөрөг үр дагавар үүссэн эсэхээс үл шалтгаалан Үнэт цаас гаргагчийг зөрчил гаргасан гэж үзнэ.

8.2. Үнэт цаас гаргагч зөрчил гаргасан тохиолдолд Бирж Бүртгэлийн журмын 10 дугаар бүлэгт заасны дагуу үнэт цаасны арилжааг түр зогсоох, түдгэлзүүлэх, үнэт цаасны бүртгэлийг цуцлах эрхтэйгээс гадна Бүртгэлийн журамд заасан сахилгын хариуцлагыг зөрчлийн хэмжээнээс шалтгаалан шууд, эсхүл шат дараалан ногдуулна.

8.3. Гэрээний 8.2-т заасны дагуу Бирж үнэт цаасны арилжааг түр зогсоох болон түдгэлзүүлэх нь хууль тогтоомж болон энэхүү Гэрээгээр Үнэт цаас гаргагчид хүлээлгэсэн үүргээс Үнэт цаас гаргагчийг чөлөөлөх үндэслэл болохгүй.

8.4. Үнэт цаас гаргагч зөрчил гаргасны улмаас Бирж болон хөрөнгө оруулагч, түүнчлэн бусад этгээдэд учирсан аливаа хохирлыг Үнэт цаас гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтнууд хариуцна. Үнэт цаас гаргагч хохирлыг үл маргах журмаар барагдуулсан нь Гэрээний 8.2-т заасан хариуцлагаас Үнэт цаас гаргагчийг чөлөөлөх үндэслэл болохгүй.

8.5. Бирж арилжааг түдгэлзүүлсэн, түр зогсоосон, эсхүл Гэрээг цуцалсан тохиолдолд Биржийн цахим хуудсанд энэ тухай мэдээллийг байршуулах замаар хөрөнгө оруулагчдад мэдээлнэ.

8.6. Үнэт цаас гаргагч хариуцлага хүлээсэнтэй холбоотой хөрөнгө оруулагчдад учирсан аливаа хохирлыг Бирж хариуцахгүй.

ЕС. ХЭРЭГЛЭГДЭХ ХУУЛЬ БА МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

9.1. Энэхүү Гэрээ нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан бөгөөд аливаа маргаан үүсвэл Монгол улсын холбогдох хууль, тогтоомжийг баримтлан хянан шийдвэрлэнэ.

9.2. Бүртгэлийн журамд зааснаас бусад энэхүү Гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан, түүнчлэн уг гэрээг зөрчих, цуцлах, дуусгавар болгохтой холбоотой бүх маргааныг Арбитрийн тухай хуульд заасны дагуу Биржийн арилжаанд оролцогчдын дэргэд байгуулагдах Түр арбитраар, түүний тогтоосон дүрмийн дагуу Монгол улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

9.3. Гэрээний 9.2-т заасан арбитрийн шийдвэр эцсийнх байна.

АРАВ. БУСАД ЗҮЙЛ

10.1. **Эрх үл шилжүүлэх:** Үнэт цаас гаргагч Биржийн зөвшөөрөлгүйгээр Гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй.

10.2. **Хохирол нөхөн төлөх баталгаа:** Үнэт цаас гаргагч Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс Бирж, хувьцаа / сангийн нэгж эрх эзэмшигч, бусад хөрөнгө оруулагч нарт учруулсан аливаа хохирлыг дангаар бүрэн хариуцна.

10.3. **Нэмэлт өөрчлөлт:** Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр Гэрээг анх байгуулсан хэлбэр шаардлагын дагуу Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

10.4. **Бүртгэлийн гэрээний Ерөнхий нөхцөл:** Үнэт цаас гаргагч Гэрээний Ерөнхий нөхцөлийг уншиж танилцсан, хүлээн зөвшөөрсөн болно.

10.5. **Бүртгэлийн гэрээний Тусгай нөхцөл:** Үнэт цаас гаргагч Гэрээний Тусгай нөхцөлийг уншиж танилцсан, хүлээн зөвшөөрсөн болно.

10.6. **Гэрээ хүчин төгөлдөр болох:** Талууд гарын үсэг зурж, тамга дарснаар Гэрээ хүчин төгөлдөр болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

БИРЖИЙГ ТӨЛӨӨЛЖ:	**ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**
(албан тушаал)	(албан тушаал)
_____	_____
(гарын үсэг)	(гарын үсэг)
Хаяг:	Хаяг:
Утас:	Утас:
Цахим шуудан:	Цахим шуудан:

Гэрээний хавсралт 1

ЧӨЛӨӨЛӨЛТ

Бирж Үнэт цаас гаргагчийн ирүүлсэн хүсэлтийг үндэслэн дараах шаардлагаас чөлөөлөв. Үүнд:

№	**Үнэт цаас гаргагчийн ирүүлсэн хүсэлт**	**Чөлөөлсөн тухай тайлбар**
1.	[.]	• [.]
2.		• [.]

Гэрээний хавсралт 2

ШААРДЛАГА, ХЯЗГААРЛАЛТ

Үнэт цаас гаргагч болон түүний гаргасан үнэт цаасанд дараах шаардлага, хязгаарлалт тавигдана. Үүнд:

№	Төрөл	Шаардлага, хязгаарлалт
1.	Үнэт цаас гаргагчид тавигдах шаардлага, хязгаарлалт	• Хоёрдогч зах зээлд [.]-с доошгүй зах зээл үүсгэгчтэй зах зээл үүсгэх гэрээ байгуулан ажиллах
2.		• [.]
3.	Эрх бүхий албан тушаалтнуудад тавигдах шаардлага, хязгаарлалт	• Хяналтын багц эзэмшигч этгээдийг гүйцэтгэх захирлын албан тушаалд томилон ажиллуулахгүй байх
4.		• [.]
5.	Үнэт цаас санал болгох, захиалахад тавигдах шаардлага, хязгаарлалт	• Үнэт цаас гаргагч, түүний хамаарал бүхий хуулийн этгээдийн ажилтан, удирдлагын багт нийт бүртгүүлсэн үнэт цаасны [.] илүүгүй хувийг давуу байдлаар санал болгох
6.		• [.]
7.	Үнэт цаас худалдах, нэмж гаргах, буцаан худалдан авахад тавигдах шаардлага, хязгаарлалт	• Анхдагч зах зээлийн арилжааны дараа [.]-аас доошгүй хувьцаа / сангийн нэгж эрх эзэмшигчтэй байх
8.		• Анхдагч зах зээлийн арилжааны дараа нэг хувьцаа / сангийн нэгж эрх эзэмшигчийн эзэмших хувьцааны тоо [.]-с багагүй байх
9.		• Нээлттэй Үнэт цаас гаргагч болохоос өмнө гаргасан үнэт цаасыг [.] сарын дотор бусдад худалдахгүй байх
10.		• Анхдагч арилжаа хийгдсэнээс хойш [.] сарын хугацаанд ижил төрлийн үнэт цаас нэмж гаргахгүй байх
		• [.]

БҮРТГЭЛИЙН ГЭРЭЭ /Өрийн хэрэгсэл, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас/

№

Энэхүү Бүртгэлийн гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г 20 __ оны __ сарын __ -ны өдөр

Нэг талаас _____ хаягт байрлах “Улаанбаатар Үнэт Цаасны Бирж” ХК (цаашид “Бирж” гэх), түүнийг төлөөлж _____,

Нөгөө талаас _____ хаягт байрлах _____ тоот регистрийн дугаартай “_____” ХК (цаашид “Үнэт цаас гаргагч” гэх), түүнийг төлөөлж _____ (хамтад нь “Талууд” гэх) нь

Биржийн Бүртгэлийн хорооны 20 __ оны __ сарын __ -ны өдрийн ___ тоот шийдвэр, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ны 20 __ оны __ сарын __ -ны өдрийн __ тоот шийдвэрийг тус тус үндэслэн дараах нөхцөлөөр байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү Гэрээгээр Үнэт цаас гаргагч нь Биржид бүртгэлтэй байх хугацаанд түүний хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлж, Бирж болон Үнэт цаас гаргагч хооронд үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Үнэт цаас гаргагчийн олон нийтэд мэдээлэл хүргэх, бүртгэлтэй байх хугацаанд тогтмол хүлээх нарийвчилсан үүрэгтэй холбоотой харилцааг Гэрээний Ерөнхий нөхцөлөөр зохицуулах ба Биржээс шаардлагатай гэж үзвэл тодорхой төрлийн харилцааг Тусгай нөхцөлөөр зохицуулна.

1.3. Гэрээний Ерөнхий нөхцөл болон Тусгай нөхцөлийг Биржийн Гүйцэтгэх захирал батлах ба өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтийг мөрдөж эхлэхээс ажлын 10 (арав) хоногийн өмнө Үнэт цаас гаргагчид мэдэгдэнэ.

1.4. Гэрээнд зохицуулаагүй аливаа асуудлыг талууд Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, Хороо, Биржээс баталсан холбогдох журмын дагуу шийдвэрлэнэ.

1.5. Гэрээнд дурдсан нэр томьёог Бүртгэлийн журам болон Биржийн бусад журамд заасан нэр томьёоны тайлбарын дагуу ойлгож хэрэглэнэ.

ХОЁР. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮНЭТ ЦААС

2.1. Бирж нэг бүр нь ..... төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий .... сарын хугацаатай ..... хувийн хүүтэй ..... бүр хүү төлөгдөх ..... ширхэг Үнэт цаас гаргагчийн өрийн хэрэгсэл / хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэв.

2.2. Үнэт цаас гаргагч нийт ..... ширхэг өрийн хэрэгсэл / хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Биржийн холбогдох журмын дагуу үндсэн / хөгжлийн талбарт арилжина.

2.3. Өрийн хэрэгслийн барьцаа / баталгаа нь ..... байна.

ГУРАВ. БҮРТГЭЛТЭЙ БАЙХ ХУГАЦААНД ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХҮЛЭЭХ НИЙТЛЭГ ҮҮРЭГ

Үндсэн болон хүүгийн төлбөрийг төлөх

3.1. Үнэт цаас гаргагч нь бондын үндсэн болон хүүгийн төлбөрийг Бирж болон Төв клирингээс тооцсон дүнгээр цаг хугацаанд нь төлөх үүрэгтэй.

Хууль тогтоомж, дүрэм журам дагаж мөрдөх

3.2. Үндсэн болон Хөгжлийн талбарт бүртгэгдэх Үнэт цаас гаргагч нь төрийн эрх бүхий байгууллагаас баталсан хууль тогтоомжоос гадна Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрийн байдлаар хэрэгжиж байгаа Гэрээ, Гэрээний Ерөнхий нөхцөл, Гэрээний Тусгай нөхцөл, Биржээс батлагдан гарах дүрэм журам, заавар, удирдамж, зөвлөмж, тушаал шийдвэр болон тэдгээрийн нэмэлт өөрчлөлтийг дагаж мөрдөх үүрэгтэй.

Үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах

3.3. Үнэт цаас гаргагч нь бүртгэлтэй байх хугацаандаа үйл ажиллагаагаа хэвийн явуулах үүрэгтэй ба уг үүргийг биелүүлэхэд хангалттай хүрэлцэхүйц эдийн болон эдийн бус хөрөнгөтэй байна.

3.4. Үнэт цаас гаргагч бүртгэлтэй байх хугацаандаа Улаанбаатар Үнэт Цаасны Биржийн бүртгэлийн журам (цаашид “Бүртгэлийн журам” гэх)-д заасан шалгуур үзүүлэлтийг тогтмол хангаж ажиллах үүрэгтэй.

Шаардлага биелүүлэх

3.5. Бирж нь зохицуулалттай зах зээлийн хэвийн үйл ажиллагааг хангах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд Үнэт цаас гаргагчид шаардлага тавих эрхтэй ба Үнэт цаас гаргагчийн нь тухайн шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлэх үүрэгтэй.

Олон нийтэд мэдээлэх

3.6. Үнэт цаас гаргагч мэдээллийг олон нийтэд хүргэхдээ Бүртгэлийн журмын 8.4-д заасны дагуу мэдээлнэ.

3.7. Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчдыг мэдээлэлд суурилсан, үндэслэл бүхий шийдвэр гаргахад нь шаардлагатай мэдээллээр хангах үүрэгтэй. Энэ үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг Гэрээний Ерөнхий нөхцөл, Гэрээний Тусгай нөхцөл, Биржээс батлах бусад дүрэм, журмаар зохицуулна.

3.8. Бирж шаардсан, эсхүл Үнэт цаас гаргагч шаардлагатай гэж үзсэн тохиолдолд цахим хуудсанд байршуулсан мэдээллийг бусад мэдээллийн хэрэгслийг ашиглан нийтэд хүргэж болно.

Биржтэй харилцах

3.9. Үнэт цаас гаргагч нь Бүртгэлийн журамд заасны дагуу томилсон итгэмжлэгдсэн төлөөлөгч, Үнэт цаас гаргагчийн гэрээ байгуулсан нийцүүлэгчээр дамжуулан Биржтэй харилцана.

3.10. Бирж Үнэт цаас гаргагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн Биржид бүртгүүлсэн ажлын газрын хаяг, цахим шуудан, факс зэргийн аль нэгээр (тухайн нөхцөлд тохиромжтой хэлбэрээр нь) аливаа зар, мэдээлэл, мэдэгдэл, баримт бичиг зэргийг илгээснээр түүнийг итгэмжлэгдсэн төлөөлөгч хүлээн авсан эсэхээс үл шалтгаалан Үнэт цаас гаргагчид хүргүүлсэнд, Үнэт цаас гаргагч хүлээн зөвшөөрсөнд тооцно.

3.11. Үнэт цаас гаргагчаас Биржид илгээх мэдээллийг Биржтэй тохиролцсон хэлбэр, сувгаар хүргүүлнэ.

Төлбөр, хураамж

3.12. Үнэт цаас гаргагч Биржийн баталсан Шимтгэл, хураамжийн журамд заасан бүртгэлтэй холбоотой бүх шимтгэл хураамжийг заасан хугацаанд төлөх үүрэгтэй.

3.13. Үнэт цаас гаргагч Гэрээний 3.12-д заасан хураамжийг тогтоосон хугацаанд төлөөгүй тохиолдолд Бирж төлөгдөөгүй үнийн дүнгээс алданги тооцож авна.

Бусад нийтлэг үүрэг

3.14. Татан төвлөрүүлсэн хөрөнгийг бүртгэлийн баримт бичигт заасан зориулалтын дагуу ашиглана.

3.15. Бүртгэлийн журамд заасан тодорхой шаардлагаас чөлөөлөгдсөн тохиолдолд тэдгээр шаардлага, түүний биелүүлэх болзол, нөхцөлийг Биржээс тогтоосон хугацааны дотор хангаж, энэ талаар Бирж болон олон нийтэд мэдээлнэ.

3.16. Биржтэй хийсэн аливаа уулзалт, зөвлөгөөн, тэдгээрээс гарсан шийдвэрийг нууцална.

3.17. Биржээс шаардсан лавлагаа, мэдээллийг цаг тухайд нь хүргүүлнэ.

3.18. Бирж шаардсан тохиолдолд Үнэт цаас гаргагчийн удирдлагын багийн зарим гишүүдийг тодорхой хугацаанд өөрчлөхгүй.

3.19. Бизнесийн үндсэн үйл ажиллагааны чиглэлд Биржийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөлт оруулахгүй.

3.20. Биржээс явуулж буй хяналт шалгалтын ажилд туслалцаа үзүүлнэ.

3.21. Гэрээний Ерөнхий болон Тусгай нөхцөлд заасан тогтмол хүлээх үүргийг биелүүлэх зэрэг болно.

ДӨРӨВ. АЛБАН ЁСНЫ НЭР, ЛОГО, ВЭБ САЙТЫН ХАЯГ, БАРААНЫ ТЭМДЭГ АШИГЛАХ

4.1 Үнэт цаас гаргагчийн болон үнэт цаасны бүртгэлтэй холбогдох мэдээ, мэдээлэл, баримт бичгийг олон нийтэд хүргэх зорилгоор Бирж Үнэт цаас гаргагчийн лого, вэб сайтын хаяг, албан ёсны нэр, барааны тэмдгийг ашиглах эрхтэй. Үнэт цаас гаргагч нь Биржийг Үнэт цаас гаргагчийн лого, вэб сайтын хаяг, албан ёсны нэр, барааны тэмдгийг ашиглах боломжоор хангах үүрэгтэй.

4.2 Үнэт цаас гаргагч өөрийн лого, вэб сайтын хаяг, албан ёсны нэр, барааны тэмдэг нь гуравдагч этгээдэд хамаарах зохиогчийн эрхийг зөрчөөгүй болохыг үүгээр баталж байгаа бөгөөд Бирж Үнэт цаас гаргагчийн лого, вэб сайтын хаяг, албан ёсны нэр, барааны тэмдгийг ашигласнаас үүдэн гуравдагч этгээдэд хохирол учирсан тохиолдолд тухайн асуудлыг Үнэт цаас гаргагч бүрэн хариуцаж шийдвэрлэнэ.

4.3 Бирж урьдчилан бичгээр зөвшөөрөл өгснөөс бусад тохиолдолд Үнэт цаас гаргагч Биржийн лого, вэб сайтын хаяг, албан ёсны нэр, барааны тэмдгийг ашиглахыг хориглоно.

ТАВ. БАРЬЦАА ХӨРӨНГӨ

5.1 Үнэт цаас гаргагч нь барьцаа байршуулсан талаарх мэдээллээ Биржид мэдэгдэх ба өөрчлөлт орсон тохиолдол бүрт нэн даруй мэдэгдэх шаардлагатай.

5.2 Үнэт цаас гаргагчид гуравдагч этгээд баталгаа, батлан даалт гаргасан бол бондын танилцуулгад уг этгээдийн тодорхой, үнэн зөв, бүрэн, мэдээллийг заавал тусгана.

5.3 Бирж нь зөвхөн барьцаанд хяналт тавьж ажиллах ба Үнэт цаас гаргагчийн барьцаатай холбоотой ямар нэгэн үүрэг хүлээхгүй.

5.4 Энэхүү харилцааг “Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай” хууль болон Хорооны журмаар зохицуулна.

ЗУРГАА. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БАТАЛГАА

6.1 Үнэт цаас гаргагч нь дараах байдлаар мэдэгдэл болон баталгааг гаргаж байна:

6.1.1. Үнэт цаас гаргагч, эсхүл түүний төлөөлөгч нь энэхүү Гэрээг зохих журмын дагуу хийсэн бөгөөд Гэрээгээр хүлээх түүний үүрэг нь хууль ёсны бөгөөд Үнэт цаас гаргагчид заавал биелүүлэх үүрэг хүлээлгэж байна.

6.1.2. Үнэт цаас нь (энэхүү гэрээний дагуу үүрэг хүлээснээс гадна) ямар нэгэн барьцаанд тавигдаагүй, түүнийг барьцаа болгох ямар нэгэн гэрээ, хэлцэл, хийгдээгүй, энэ талаар Үнэт цаас гаргагч ямар нэгэн үйлдэл хийгээгүй болно.

6.1.3. ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага нь Үнэт цаас гаргагчийн эд хөрөнгийн болон эзэмшлийн холбогдолтой аливаа шүүхийн маргаанд татагдаагүй болно.

6.1.4. Үнэт цаас гаргагчийг дампууруулах ямар нэгэн нэхэмжлэл гараагүй, Үнэт цаас гаргагч нь дампуурах болон татан буугдах үндэслэл байхгүй.

6.2 Энэхүү гэрээ, түүнд орсон зүйл заалт нь үнэт цаас болон Талуудад хамааралтай ямар нэгэн хууль тогтоомж, шүүхийн шийдвэр, зөвшөөрөл, тушаал, шийдвэрийг зөрчөөгүй болно.

6.3 Талууд энэ зүйлд заасан мэдэгдэл болон баталгаанд үндэслэн энэхүү гэрээг байгуулсан болно. Энэхүү гэрээг байгуулах үед гаргасан мэдэгдэл ба баталгаа нь үнэн зөв болохыг Үнэт цаас гаргагч нотолж байна.

ДОЛОО. ЧӨЛӨӨЛӨЛТ БА ХЯЗГААРЛАЛТ

7.1. Үнэт цаас гаргагч Хавсралт 1-т заасан нөхцөлөөр чөлөөлөлт эдэлнэ.

7.2. Гэрээний Хавсралт 2-т заасан хязгаарлалтыг Үнэт цаас гаргагч дагаж мөрдөх үүрэгтэй.

7.3. Бирж нь зах зээлийн шударга, үр ашигтай байдлыг хангах зорилгоор үнэт цаас, түүний арилжаа, Үнэт цаас гаргагч болон түүний эрх бүхий албан тушаалтнуудад Гэрээний 7.2-т зааснаас гадна нэмэлт хязгаарлалт тогтоож болно.

НАЙМ. ЗӨРЧИЛ БА ХАРИУЦЛАГА

8.1. Үнэт цаас гаргагч нь холбогдох хууль тогтоомж, Биржээс баталсан дүрэм, журам болон Гэрээний заалтыг зөрчсөн тохиолдолд үүнээс шалтгаалан Биржийн нэр хүндэд хохирол учруулсан, Биржийн үйл ажиллагаанд сөрөг үр дагавар үүссэн эсэхээс үл шалтгаалан Үнэт цаас гаргагчийг зөрчил гаргасан гэж үзнэ.

8.2. Үнэт цаас гаргагч зөрчил гаргасан тохиолдолд Бирж Бүртгэлийн журмын 10 дугаар бүлэгт заасны дагуу үнэт цаасны арилжааг түр зогсоох, түдгэлзүүлэх, үнэт цаасны бүртгэлийг цуцлах эрхтэйгээс гадна Бүртгэлийн журамд заасан сахилгын хариуцлагыг зөрчлийн хэмжээнээс шалтгаалан шууд, эсхүл шат дараалан ногдуулна.

8.3. Гэрээний 8.2-т заасны дагуу Бирж үнэт цаасны арилжааг түр зогсоох болон түдгэлзүүлэх нь хууль тогтоомж болон энэхүү Гэрээгээр Үнэт цаас гаргагчид хүлээлгэсэн үүргээс Үнэт цаас гаргагчийг чөлөөлөх үндэслэл болохгүй.

8.4. Үнэт цаас гаргагч зөрчил гаргасны улмаас Бирж болон хөрөнгө оруулагч, түүнчлэн бусад этгээдэд учирсан аливаа хохирлыг Үнэт цаас гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтнууд хариуцна. Үнэт цаас гаргагч хохирлыг үл маргах журмаар барагдуулсан нь Гэрээний 8.2-т заасан хариуцлагаас Үнэт цаас гаргагчийг чөлөөлөх үндэслэл болохгүй.

8.5. Бирж арилжааг түдгэлзүүлсэн, түр зогсоосон, эсхүл Гэрээг цуцалсан тохиолдолд Биржийн цахим хуудсанд энэ тухай мэдээллийг байршуулах замаар хөрөнгө оруулагчдад мэдээлнэ.

8.6. Үнэт цаас гаргагч бүртгэлийн баримт бичигт заасны дагуу үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг цаг хугацаанд нь төлж чадахгүй болсон тохиолдолд үнэт цаас гаргагч бүх хариуцлагыг өөрөө хүлээнэ.

8.7. Үнэт цаас гаргагч хариуцлага хүлээсэнтэй холбоотой хөрөнгө оруулагчдад учирсан аливаа хохирлыг Бирж хариуцахгүй.

ЕС. ХЭРЭГЛЭГДЭХ ХУУЛЬ БА МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

9.1. Энэхүү Гэрээ нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан бөгөөд аливаа маргаан үүсвэл Монгол улсын холбогдох хууль, тогтоомжийг баримтлан хянан шийдвэрлэнэ.

9.2. Бүртгэлийн журамд зааснаас бусад энэхүү Гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан, түүнчлэн уг гэрээг зөрчих, цуцлах, дуусгавар болгохтой холбоотой бүх маргааныг Арбитрийн тухай хуульд заасны дагуу Биржийн арилжаанд оролцогчдын дэргэд байгуулагдах Түр арбитраар, түүний тогтоосон дүрмийн дагуу Монгол улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

9.3. Гэрээний 9.2-т заасан арбитрийн шийдвэр эцсийнх байна.

АРАВ. БУСАД ЗҮЙЛ

10.1. **Эрх үл шилжүүлэх:** Үнэт цаас гаргагч Биржийн зөвшөөрөлгүйгээр Гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй.

10.2. **Хохирол нөхөн төлөх баталгаа:** Үнэт цаас гаргагч Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс Бирж, үнэт цаас эзэмшигч, бусад хөрөнгө оруулагч нарт учруулсан аливаа хохирлыг дангаар бүрэн хариуцна.

10.3. **Нэмэлт өөрчлөлт:** Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр Гэрээг анх байгуулсан хэлбэр шаардлагын дагуу Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

10.4. **Бүртгэлийн гэрээний Ерөнхий нөхцөл:** Үнэт цаас гаргагч Гэрээний Ерөнхий нөхцөлийг уншиж танилцсан, хүлээн зөвшөөрсөн болно.

10.5. **Бүртгэлийн гэрээний Тусгай нөхцөл:** Биржээс шаардлагатай гэж үзэн Үнэт цаас гаргагчид Гэрээний Тусгай нөхцөл тавьсан бол түүнтэй уншиж танилцсан, хүлээн зөвшөөрсөн болно.

10.6. **Гэрээ хүчин төгөлдөр болох:** Талууд гарын үсэг зурж, тамга дарснаар Гэрээ хүчин төгөлдөр болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

БИРЖИЙГ ТӨЛӨӨЛЖ:	**ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**
(албан тушаал)	(албан тушаал)
_____	_____
(гарын үсэг)	(гарын үсэг)
Хаяг:	Хаяг:
Утас:	Утас:
Цахим шуудан:	Цахим шуудан:

Гэрээний хавсралт 1

ЧӨЛӨӨЛӨЛТ

Бирж Үнэт цаас гаргагчийн ирүүлсэн хүсэлтийг үндэслэн дараах шаардлагаас чөлөөлөв. Үүнд:

№	**Үнэт цаас гаргагчийн ирүүлсэн хүсэлт**	**Чөлөөлсөн тухай тайлбар**
1.	[.]	• [.]
2.		• [.]

Гэрээний хавсралт 2

ШААРДЛАГА, ХЯЗГААРЛАЛТ

Үнэт цаас гаргагч болон түүний гаргасан үнэт цаасанд дараах шаардлага, хязгаарлалт тавигдана. Үүнд:

№	Төрөл	Шаардлага, хязгаарлалт
1.	Үнэт цаас гаргагчид тавигдах шаардлага, хязгаарлалт	● Хоёрдогч зах зээлд [.]-с доошгүй зах зээл үүсгэгчтэй зах зээл үүсгэх гэрээ байгуулан ажиллах
2.		● [.]
3.	Эрх бүхий албан тушаалтнуудад тавигдах шаардлага, хязгаарлалт	● Хяналтын багц эзэмшигч этгээдийг гүйцэтгэх захирлын албан тушаалд томилон ажиллуулахгүй байх
4.		● [.]
5.	Үнэт цаас санал болгох, захиалахад тавигдах шаардлага, хязгаарлалт	● Үнэт цаас гаргагч, түүний хамаарал бүхий хуулийн этгээдийн ажилтан, удирдлагын багт нийт бүртгүүлсэн үнэт цаасны [.] илүүгүй хувийг давуу байдлаар санал болгох
6.		● [.]
7.	Үнэт цаас худалдах, нэмж гаргах, буцаан худалдан авахад тавигдах шаардлага, хязгаарлалт	● Анхдагч зах зээлийн арилжааны дараа [.]-аас доошгүй үнэт цаас эзэмшигчтэй байх
8.		● Анхдагч зах зээлийн арилжааны дараа нэг үнэт цаас эзэмшигчийн эзэмших-үнэт цаасны тоо [.]-с багагүй байх
9.		● Нээлттэй компани болохоос өмнө гаргасан үнэт цаасыг [.] сарын дотор бусдад худалдахгүй байх
10.		● Анхдагч арилжаа хийгдсэнээс хойш [.] сарын хугацаанд ижил төрлийн үнэт цаас нэмж гаргахгүй байх
		● [.]

ХӨГЖЛИЙН ТАЛБАРААС ҮНДСЭН ТАЛБАРТ ШИЛЖИХТЭЙ ХОЛБООТОЙ АЛБАН ЁСНЫ ӨРГӨДЛИЙН МАЯГТ

Хэнд: “УЛААНБААТАР ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ” ХК-Д

Огноо:

Үнэт цаас гаргагчийн бүтэн нэр:

1. _____ (бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн нэр) ХК нь энэ маягтын 3-р хэсэгт заасан үнэт цаасыг бүртгүүлэх, арилжихтай холбоотойгоор энэхүү өргөдлийг Биржийн бүртгэлийн журмын дагуу гаргаж байна.

2. Үнэт цаас гаргагчийн хувьцааны мэдээлэл:
   Бүртгүүлсэн огноо: 20__ оны __ сарын __ өдөр
   Бүртгэлтэй үнэт цаасны тоо: _____ ширхэг
   Үнэт цаасны зах зээлийн үнэлгээ: _____төгрөг

3. Энэхүү өргөдөлтэй холбоотой хувьцааны тоо ширхэг, тодорхойлолт
   _____
   _____
   _____
   _____
   талбар шилжүүлэх хувьцаатай зэрэг өргөдөл гаргах шаардлагатай опцион, варрант, эсвэл хөрвөх нөхцөлтэй өрийн хэрэгсэл, тэдгээрийн тоо ширхгийг тусгах

4. Энэхүү өргөдлийг холбогдох хувьцааны бүртгэлийг хөгжлийн талбараас үндсэн талбарт шилжүүлэн бүртгэх зорилгоор гаргасан болно.

5. Доор дурдсан этгээдүүд нь үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүд, эрх бүхий этгээдүүдээс ирүүлсэн лавлагааны үндсэн дээр компанийн эсхүл нийт саналын эрхийн 10-аас дээш хувийн саналын эрхтэй үнэт цаас эзэмшигч(ид) мөн болно.

Нэр	Саналын эрх /%/	Компани	Хаяг
1			
...			

Дараах этгээдүүд нь үнэт цаас гаргагчийн эрх бүхий этгээд (ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, Нарийн бичгийн дарга) мөн болно.

Нэр	Албан тушаал	Утас, хаяг
1		
...		

6. Бид дараах зүйлсийг мэдүүлж байна:
   (1) Бүртгэлийн журам, гэрээний холбогдох бүлгүүдэд заасан талбар шилжих тухай өргөдөл гаргахаас өмнө үнэт цаас гаргагч болон энэ Хавсралтын 3-р хэсэгт заасан үнэт цаасны хангах шаардлагатай бүх нөхцөлийг хангасан.
   (2) Бүртгэлийн журам, гэрээнд заасны дагуу өргөдөлд хавсаргах шаардлагатай бүх баримт бичгийг хавсаргасан ба эцсийн хувилбарыг ирүүлээгүй эсвэл хянуулаагүй тохиолдолд ирүүлэх буюу хянах үед шаардлагатай баримт бичгийг бүрэн гүйцэд хавсаргах болно.
   (3) Бүртгэлийн журам, гэрээний дагуу өргөдөл гаргах үед хангасан байх үнэт цаас гаргагч болон үнэт цаастай холбоотой шаардлагуудыг биелүүлсэн болно.
   (4) Үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг бүртгүүлэх, арилжихтай холбоотой дээрх мэдээллээс өөр Биржид ил тод болгох шаардлагатай ямар нэг мэдээлэл байхгүй болно.
7. Үнэт цаас гаргагчийн үүрэг

   _____ ХК нь өөрт хамааралтай Бүртгэлийн журамд тухай бүр заасан шаардлагыг хангах үүргээ биелүүлэх болно.

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Албан тушаал:

Овог нэр:

Гарын үсэг:

ХӨГЖЛИЙН ТАЛБАРААС ҮНДСЭН ТАЛБАРТ ШИЛЖИХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГЫН ТАЛААР КОМПАНИЙН ТУЗ-ИЙН ГИШҮҮН БОЛОН БУСАД ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН ГАРЫН ҮСЭГ БҮХИЙ МЭДҮҮЛЭГ

Хөгжлийн талбараас үндсэн талбарт шилжихэд тавигдах урьдчилсан нөхцөлүүдийг үнэт цаас гаргагч хангасан болохыг баталж байна.

Жич: Энэхүү хавсралтад талбар шилжихтэй холбоотойгоор Биржийн зүгээс тухай бүр тавих шаардлагыг биелүүлсэн эсэхийг шалгасан хяналтын хуудсыг хавсаргана. Эдгээр баримт бичиг нь үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүн, эрх бүхий этгээд тус бүрийн гарын үсгээр баталгаажсан байна.

Албан тушаал:	
Овог нэр:	
Гарын үсэг:	
Огноо:	
Албан тушаал:	
Овог нэр:	
Гарын үсэг:	
Огноо:	
Албан тушаал:	
Овог нэр:	
Гарын үсэг:	
Огноо:	

АЛБАН МЭДЭГДЭЛ (Аймаг, нийслэлийн Засаг даргын өрийн хэрэгсэл)

Хэнд: “УЛААНБААТАР ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ” ХК-Д

Огноо:

Өргөдөл гаргагчийн нэр:

_____ (үнэт цаас гаргагчийн нэр) нь өрийн хэрэгслийг Биржид бүртгүүлэхээр энэхүү албан мэдэгдлийг гаргаж байна.

НЭГ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧТАЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ	
1. Үнэт цаас гаргагчийн ерөнхий мэдээлэл	
1. Үнэт цаас гаргагч аймаг, нийслэл хот-ын нэр	
2. Өрийн хэрэгслийн нэр	
3. Өрийн хэрэгсэл гаргахтай холбоотойгоор гаргасан иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрийн огноо, дугаар	
4. Засгийн газраас олгосон зөвшөөрлийн огноо, дугаар	
5. Үнэт цаас гаргагчийн гол харилцагч банк	
2. Өрийн хэрэгслийн товч мэдээлэл	
Өрийн хэрэгслийн нэр	_____

Тоо ширхэг	_____	
Нэгж өрийн хэрэгслийн нэрлэсэн үнэ	_____	
Нийт үнийн дүн	_____	
Хугацаа	_____	
Жилийн хүү	_____	
Хүүгийн төлөлт хийгдэх давтамж	_____	
3. Хуулийн зөвлөхийн мэдээлэл		
Нэр	_____	
Хаяг, холбоо барих мэдээлэл	_____	
4. Шалгуур хангасан эсэх		
Үндэсний мөнгөн тэмдэгтээр гаргаж буй эсэх	□ Тийм	□ Үгүй
	Бусад _____	
Засгийн газраас үнэт цаас гаргах тухай зөвшөөрөл авсан эсэх	□ Тийм	□ Үгүй
	Бусад _____	
Засгийн газрын шинээр үүсгэх өрийн дээд хэмжээнд нийцсэн байх	□ Тийм	□ Үгүй
	Бусад _____	
Аймаг, нийслэлийн төсөвт тусгагдсан эсэх	□ Тийм	□ Үгүй
	Бусад _____	
Аймаг, нийслэлийн төсвийн төсөлд үнэт цаасаар хүлээх үүргийн хэмжээг тусгасан эсэх	□ Тийм	□ Үгүй
	Бусад _____	
Аймаг, нийслэлийн төсвийн төсөлд үнэт цаас гаргахтай холбогдсон зардлыг тусгасан эсэх	□ Тийм	□ Үгүй
	Бусад _____	
Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн эсэх	□ Тийм	□ Үгүй

	Бусад _____	
Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан эсэх	□ Тийм	□ Үгүй
	Бусад _____	
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас аймаг, нийслэлийн үнэт цаас гаргах тухай Засаг даргын саналыг дэмжсэн эсэх	□ Тийм	□ Үгүй
	Бусад _____	
Эргэн төлөлтийг улсын төсвийн шилжүүлэг болон дэмжлэгээр төлөх эсэх	□ Тийм	□ Үгүй
	Бусад _____	
Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрээгүй эсэх	□ Тийм	□ Үгүй
	Бусад _____	
Тухайн төсөл, арга хэмжээний төрлөөс хамааран зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг хийж, баталгаажуулсан эсэх	□ Тийм	□ Үгүй
	Бусад _____	

ХОЁР. ИРҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА

1. Өрийн хэрэгсэлтэй холбоотой мэдээлэл, тэдгээрийг гаргах болон хуваарилах нөхцөл	**Хуудасны дугаар**
1. Үнэт цаас гаргагч нь өрийн хэрэгслийг Биржид бүртгүүлж арилжаанд оруулахыг хүссэн өргөдлийг Биржид гаргасан тухай мэдэгдэл	
2. Үнэт цаасыг Биржийн тооцооны системээр арилжаанд оруулахад шаардлагатай бүх арга хэмжээг авсан тухай мэдэгдэл	
3. Өрийн хэрэгслийн зэрэглэл тогтоолгосон бол зэрэглэл, зэрэглэл тогтоосон байгууллагын нэр.	
4. Өрийн хэрэгсэл гаргах үйл ажиллагааны төлөвлөгөө болон энэхүү төлөвлөгөө хэрхэн хэрэгжих тухай мэдэгдэл.	
5. Дараах агуулга бүхий үнэт цаас гаргахтай холбоотой мэдээллүүд. Үүнд: a. Гаргах үнэт цаасны тоо ширхэг, нэрлэсэн үнэ, номинал хэмжээ, хэрвээ тогтмол биш үнээр гаргах бол өрийн хэрэгслийн тоо хэмжээ, шинж чанарыг багтаасан мэдэгдэл b. Стратегийн хөрөнгө оруулагч болон/эсхүл олон нийтэд санал болгон худалдахаар төлөвлөсөн хугацаа c. Гаргах үнэт цаасны хүүгийн төрөл d. Гаргах үнэт цаасны хүү, үндсэн төлбөр төлөх давтамж хугацаа, дэлгэрэнгүй хуваарь e. Өрийн хэрэгсэл эзэмшигчийн эдлэх үндсэн эрх, үүргүүд	

f. Хөвөгч хүүтэй өрийн хэрэгсэл гаргах тохиолдолд түүнийг тооцоолох арга, хямдруулсан өрийн хэрэгсэл гаргах тохиолдолд энэ тухай мэдээлэл, үнэт цаас худалдан авагч үнэт цаас гаргалттай холбоотой аливаа нэмэлт төлбөр төлөх бол энэ тухай мэдээлэл g. Үнэт цаасыг эхэлж гаргах үед болон дараа нь цувралаар гаргах тохиолдолд тэдгээрийн төлбөрийг хэрхэн төлөх тухай дэлгэрэнгүй мэдээлэл h. Үнэт цаастай холбоотой аливаа татвар болон татвараас чөлөөлөгдөж болох нөхцөлийн тухай мэдээлэл i. Амортизаци болон хугацаанаас нь өмнө үнэт цаасны төлбөр хийж болох эсэх тухай мэдээлэл j. Үнэт цаасыг гаргаж буй валютын төрөл, хэрэв тухайн гаргаж буй валютаас өөр валютаар төлбөр хийхийг зөвшөөрсөн бол энэ тухай мэдээлэл k. Анхдагч зах зээлд санал болгох арга, хэлбэр l. Шаардлагатай бол захиалгын хэмжээг бууруулах нөхцөлүүд	
6. Үнэт цаасны бүртгэлийн өргөдөл гаргахтай холбоотой дараах мэдээлэл. Үүнд: a. Үнэт цаас гаргагч нь өөр бирж дээр ижил төрлийн өрийн хэрэгсэл гаргасан, эсвэл гаргахаар төлөвлөж байгаа бол энэ тухай мэдээлэл b. Өөр бирж дээр ижил төрлийн үнэт цаас гаргаагүй боловч өөр төрлийн үнэт цаас нь арилжигддаг бол энэ тухай мэдээлэл c. Үнэт цаас гаргах ажлыг зохион байгуулах андеррайтерийн байгууллагын нэр, хэрэв андеррайтергүй бол энэ тухай мэдэгдэл d. Хэд хэдэн удаагийн цуврал (tranche) гаргалтаар үнэт цаас гаргах бол энэ тухай мэдээлэл e. Зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны тухай мэдээлэл f. Өрийн хэрэгслийг бүхэлд нь, эсвэл тодорхой хэсгийг нь Бирж дээр гаргах тухай мэдээлэл	
7. Арилжаа эхлэх өдөр (хэрвээ мэдэх боломжтой бол)	
2. Татан төвлөрүүлсэн хөрөнгийг ашиглахтай холбоотой мэдээлэл	
1. Үнэт цаас гаргагч татан төвлөрүүлсэн хөрөнгөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны тухай дэлгэрэнгүй мэдээллүүд. Үүнд: a. Нэр b. Төсөвт өртөг, татан төвлөрүүлсэн хөрөнгөнд эзлэх хувь c. Хэрэгжүүлж эхлэх, дуусах болон нийт хугацаа d. Хэрэгжүүлэх этгээд: □ Орон нутаг □ Хувийн хэвшил □ Төр, хувийн хэвшлийн түншлэл e. Бэлэн байдлын үнэлгээ	

□ Зураг төсөл □ Техник, эдийн засгийн үнэлгээ □ Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ □ Тусган гүйцэтгэгч □ Бусад мэргэжлийн байгууллагаас гаргасан дүгнэлт □ Шаардлагатай бусад …… f. Тухайн үйл ажиллагаа нь төр, орон нутгийн бодлого, стратегид нийцсэн байдал, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө, хүрэх үр дүн, учирч болзошгүй эрсдэл зэрэг болон бусад дэлгэрэнгүй мэдээлэл	
2. Удирдлага, хэрэгжүүлэх үйл ажиллагааны удирдлагын систем, бүтцийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл.	
3. Татан төвлөрүүлсэн хөрөнгөөр хийхийг хориглох үйл ажиллагааны жагсаалт	
4. Чөлөөт хөрөнгийн удирдлагатай холбоотой мэдээлэл	
5. Шаардлагатай нэмэлт мэдээлэл	
3. Үнэт цаас гаргагчийн тайлагнал	
1. Тайлантай холбоотой дараах мэдээллүүд. Үүнд: a. Тайлангийн нэр b. Олон нийтэд хүргэх хэлбэр c. Давтамж	
2. Хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой дараах мэдээллүүд. Үүнд: a. Үйл ажиллагааны явц b. Үе шат c. Үр дүнг илэрхийлэх чанарын болон тоон үзүүлэлтүүд	
3. Үйл ажиллагааны тайлан хариуцсан ажилтантай холбоотой дараах мэдээллүүд. Үүнд: a. Ажилтан, алба нэгжийн холбоо барих хаяг b. Утас c. Цахим хаяг	
4. Бусад мэдээлэл	
1. Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаанд хамаарах хууль тогтоомжийн талаарх мэдээлэл	
2. Хөрөнгө оруулагчид шийдвэр гаргахад шаардлагатай бусад мэдээлэл	
3. Өрийн удирдлагын тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хорооны холбогдох журамд заасан бусад мэдээлэл	
4. Биржийн шаардсан мэдээлэл	

5. Хавсралтаар ирүүлэх мэдээллүүд	
1. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэр, Засгийн газраас олгосон зөвшөөрлийн хуулбарууд	
2. Хүү, үндсэн төлбөр төлөх давтамж, хугацааны дэлгэрэнгүй хуваарь	
3. Бүртгэлийн баримт бичигт дурдагдсан шинжээчдийн гаргасан бүх төрлийн тайлан, дүгнэлт, албан бичиг, бусад баримтууд	
4. Мэргэжлийн оролцогчидтой гэрээ байгуулсан тохиолдолд гэрээний хуулбар	
5. Өрийн удирдлагын тухай хуульд заасан шалгууруудыг хангасанг нотлох баримт бичгийн хуулбар	
6. Бусад чухал ач холбогдолтой баримт бичгүүд	

[БАТАЛГААЖУУЛАЛТ]